



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар Е/10

Төрийн срдон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Зохих журмын дагуу хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

2023000027



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай-6,
Утас: 26-30-83, Факс: 26-12-73
E-mail: Office@president.mn

2023.04.13 № ТП/287
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацаа товлох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулж, өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хуулийн төслийг холбогдох материалын хамт хавсаргав.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Я.СОДБААТАР

2023000302

БАТЛАВ:  МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1-д “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж, 3-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.” гэж нэмэлт оруулсан.

Түүнчлэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 1.4-т Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлтэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах; намын үйл ажиллагаа, дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах; Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх; төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох.” чиглэл баримтална гэж заасан.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг Конвенцид 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Тус Конвенцийн 7 дугаар зүйлийн 3-т “Сонгогддог төрийн албан тушаалтны нэрийг дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор оролцогч улс бүр энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ” гэж тунхагласныг Монгол Улс гишүүн орны хувьд дагаж мөрдөх, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээж байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт “Улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, санхүүжилтийг шилэн болгох улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиуд санаачилна.” гэж заасан.

1.2. Практик шаардлага

Монгол Улс 1990 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиа баталж, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч, улс төрийн ардчилсан дэглэмд шилжсэнээс хойш эдүгээ 40 гаруй улс төрийн нам байгуулагдан үйл ажиллагаагаа эрхлэн явуулж иржээ. Эдүгээ Монгол Улсын Дээд шүүхэд албан ёсоор 36 улс төрийн нам бүртгэлтэй байна.

Монгол Улсын 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, Орон нутгийн хурлын нийт 22 сонгууль зохион байгуулагдсан бөгөөд энэхүү сонгуулиудад Монгол Ардын Нам, Ардчилсан Намаас гадна цөөн тооны улс төрийн нам Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулиудад нэр дэвшигчид нь сонгогдож байжээ.

Судалгаанаас үзвэл Монгол Улсад өдгөө үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намууд санхүүжилтийн ил тод байдал хязгаарлагдмал, улс төрийн нам бодлогын институц болон төлөвшиж чадаагүй, хэн нэгэн лидер буюу үүсгэн байгуулагчийн удирдлагаас шууд хараат нэг хүний юм уу лидер тойрсон бүлэглэл маягийн хэлбэртэй байгаа хэмээн дүгнэж байна.

Улс төрийн намын төлөвшил сул, үйл ажиллагаа, санхүүжилт нь ил тод бус байгаа нь Үндсэн хуулиар бий болгосон төрийн байгуулал, түүний тогтолцоо, институцийн чадавх, ардчиллын бэхжилтэд сөргөөр нөлөөлөх болов. Монгол Улсын төрийн байгуулал институцүүдийг бүрдүүлэхэд чухал үүрэг бүхий улс төрийн намуудын чиг үүрэг, дотоод зохион байгуулалтыг ардчилсан зарчимд нийцүүлж, нийт үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг ил тод, нийтэд нээлттэй болгох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Улс төрийн намуудын тухай хуулийг 1990 онд баталснаар улс төрийн намын эрх зүйн үндсийг анх тогтоож, улмаар 2005 онд Улс төрийн намын тухай хууль болгон шинэчлэн найруулснаар улс төрийн намын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг илүү нарийвчлан тусгаж, намын хөрөнгө, тайлагнал зэрэг дэвшилттэй зохицуулалт орсон. Гэсэн хэдий ч өнөөгийн хуулийн хүрээнд улс төрийн нам үйл ажиллагаагаа явуулахад дараах хүндрэл бэрхшээл үүсэж байна. Үүнд:

1/Намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, гишүүдийн эрх, үүрэг, намын дотоод ардчиллын асуудал нарийвчлан зохицуулагдаагүйгээс сахилга, хариуцлага, хяналт суларч, дур зорго, хувийн болон бүлэглэлүүдийн эрх ашиг илүү идэвхжиж, жирийн гишүүдийнх нь болон ард иргэдийн намд итгэх итгэлийг алдагдуулж байна.

2/Намын санхүүжилтийн талаарх одоогийн эрх зүйн зохицуулалт нь намыг аливаа нэг санхүүгийн эх үүсвэрээс хэт хараат болгох, санхүүжүүлэгчийн ашиг сонирхолд үйлчлэх эрсдэлийг бий болгож байна.

3/Намын бодлого боловсруулах механизмыг сайжруулахад чиглэсэн зохицуулалт байхгүй, гаргаж буй бодлого шийдвэр нь судалгаанд тулгуурлахаас илүүтэйгээр лидерийн мэдрэмж, олон нийтийн санаа бодол, нийгмийн цахим сүлжээ, бизнесийн бүлэглэлүүдийн захиалгад тулгуурлах хандлагатай, бодлогын намыг хөгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүй.

4/Улс төрийн намууд үзэл баримтлал, үнэт зүйлд суурилсан намын мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зохицуулах харилцааг хуульд заагаагүйгээс үүдэн намууд өөрийн үнэт зүйл, үзэл баримтлалаас хазайх, цаг зуурын шинжтэй олон нийтийг татах гэсэн популист амлалт бүхий хөтөлбөр дэвшүүлэх, үүнээс үүдэн улс төрийн үнэт зүйлс нийгмийн харилцаанд баттай суурьших хөрсийг бүрдүүлэх боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.

5/Улс төрийн намын үйл ажиллагаа, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад өөрийнх нь хяналтын нэгж буюу дотоод хяналтаас өөр хяналт тавих хөндлөнгийн бүтэц байхгүй, дотоодын хяналтын нэгж нь үр дүнтэй байж чадахгүй байгаагаас санхүүгийн тайландаа аудит хийлгэж, олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлдэггүй байна.

6/Улс төрийн намыг эрх бүхий байгууллага татан буулгах процедур хангалтгүй зохицуулагдсан, түүнчлэн улс төрийн намын үндсэн зорилго болох улс төрийн сонгуульд оролцохгүй байх нь улс төрийн намын үндсэн шинжээ хангаж чадахгүйд хүрч байгаа боловч түүнийг өөрөө тарахаас бусдаар татан буулгах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Иймд намуудын төлөвшилтийг дэмжсэн, институцчиллыг хангасан хууль зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 7 бүлэгтэй байна.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, улс төрийн намын эрх, үүрэг, намд эвлэлдэн нэгдэх иргэний эрх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан байх, нам цахим орчинд үйл ажиллагаа явуулах, намын үйл ажиллагаанд хориглох зүйлийг тусгана.

Хуулийн төслийн зорилтод Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам байгуулах, намын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт улс төрийн намыг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, сонгуулийн төв байгууллагын уламжилснаар Улсын дээд шүүх улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгана.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт намын бүтэц зохион байгуулалтыг дэлхийн чиг хандлага, дотоод ардчилал, хүний эрх, жендерийн тэгш эрхийг хангах зарчмуудын дагуу уян хатан бүтэцтэй, хүний эрхийг дээдэлсэн, гишүүдийн оролцоо, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад үе, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн оролцоог дэмжсэн, бодлогын нам болж ажиллах асуудлыг шинээр тусгана.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт намын үйл ажиллагааг идэвхгүйд тооцох, өөрчлөн байгуулах, намын үйл ажиллагааг зогсоох, намыг тараах асуудлыг олон улсын жишгийн дагуу нийгэмд гүйцэтгэх үүрэг, ардчилсан тогтолцоонд учруулах сөрөг нөлөөллийг тооцож шинээр нарийвчлан тусгана.

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт улс төрийн намуудад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл шалгуур, түүний мөнгөн болон мөнгөн бус хэмжээ, хуваарилалт, шилэн санхүүжилтийн зарчим, зарцуулалтын зориулалт гишүүний татвар, хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлогыг нарийвчлан тусгана.

Хуулийн төслийн зургадугаар бүлэгт намууд санхүүгийн тайлан гаргах, тайланг мэдүүлэх, аудит хийлгэх, сонгуулийн төв байгууллага тайланг нягтлан шалгах, нийтэд мэдээлэх, улмаар намын тайлантай холбоотой алдаа зөрчилд хариуцлага тооцох, долдугаар бүлэгт бусад асуудлыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар улс төрийн намуудын эрх зүйн орчин сайжирч, тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг нэмэгдэнэ.

Нэгдүгээрт, намууд цөөнх юм уу хэсэг бүлгийн эрх ашгийн илэрхийлэл болсон явцуу бүлэглэл бус, улс орны нийтлэг ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, нийгмийн өргөн давхаргын төлөөлөл бүхий бодлогын нам болно.

Хоёрдугаарт, ардчилсан нийгмийн бодлого боловсруулагч гол институц болох улс төрийн намууд нийгмийн өмнө үүрэг хүлээдэг, хариуцлагатай болсноор намд итгэх иргэдийн итгэл дээшилж, төрийн бодлого, шийдвэр гаргах явцад ард иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх болно.

Гуравдугаарт, улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийн хувь хэмжээ, зарцуулалтыг нарийн тогтоож, ил тод болгосноор улс төрийн намуудад өрсөлдөөний ижил нөхцөл бий болгож, авлигын түвшнийг бууруулахад эерэг үр дүн авчирна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэж буй бөгөөд энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Шилэн дансны тухай хуулиудад нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Улс төрийн намын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон Улс төрийн намын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг боловсруулна.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1-д “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана” гэж, 3-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэж нэмэлт оруулсан.

Түүнчлэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 1.4-т Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлтэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах; намын үйл ажиллагаа, дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах; Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх; төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох.” чиглэл баримтална гэж заасан.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг Конвенцид 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Тус Конвенцийн 7 дугаар зүйлийн 3-т “Сонгогддог төрийн албан тушаалтны нэрийг дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор оролцогч улс бүр энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ” гэж тунхагласныг Монгол Улс гишүүн орны хувьд дагаж мөрдөх, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээж байгаа юм.

Монгол Улс 1990 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиа баталж, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч, улс төрийн ардчилсан дэглэмд шилжсэнээс хойш эдүгээ 40 гаруй улс төрийн нам байгуулагдан үйл ажиллагаагаа эрхлэн явуулж иржээ. Эдүгээ Монгол Улсын Дээд шүүхэд албан ёсоор 36 улс төрийн нам бүртгэлтэй байна.

Монгол Улсын 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, Орон нутгийн хурлын нийт 22 сонгууль зохион байгуулагдсан бөгөөд энэхүү сонгуулиудад Монгол Ардын Нам, Ардчилсан Намаас гадна цөөн тооны улс төрийн нам Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулиудад нэр дэвшигчид нь сонгогдож байжээ.

Монгол Улсад өдгөө үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намууд санхүүжилтийн ил тод байдал хязгаарлагдмал, улс төрийн нам бодлогын институт болон төлөвшиж чадаагүй, хэн нэгэн лидер буюу үүсгэн байгуулагчийн удирдлагаас шууд хараат лидер тойрсон бүлэглэл маягийн хэлбэртэй байгаа хэмээн судалгаагаар дүгнэсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт "Улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, санхүүжилтийг шилэн болгох улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиуд санаачилна." гэж заасан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн нэгдэл болох улс төрийн намын эрх зүйн шинэтгэлд анхаарал хандуулж парламентад суудалтай намууд болон бусад намууд, эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 06 дугаар захирамжаар байгуулсан болно.

Уг ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд парламентад суудалтай намууд болон бусад намууд, эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагын төлөөллийг хангасан олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлага хийсний зэрэгцээ хуулийн төслийн талаарх санал авахаар Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн бүх намуудад 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр илгээж хуулийн төсөлд Улсын Их Хурал суудал бүхий бүх намуудаас болон бусад улс төрийн намуудын саналыг авсан болно.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаанаар хуулийн төсөл, түүнийг дагалдах хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэн холбогдох саналыг авч төсөлд тусгасан болно.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зарчмын шинжтэй дараах зүйлийг тусгав. Үүнд:

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, улс төрийн намын эрх, үүрэг, намд эвлэлдэн нэгдэх иргэний эрх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан байх, нам цахим орчинд үйл ажиллагаа явуулах, намын үйл ажиллагаанд хориглох зүйл;

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт улс төрийн намыг үүсгэх байгуулах, бүртгүүлэх, сонгуулийн төв байгууллагын уламжилснаар Улсын дээд шүүх улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах зохицуулалтын талаар;

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт намын бүтэц зохион байгуулалтыг дэлхийн чиг хандлага, дотоод ардчилал, хүний эрх, жендерийн тэгш эрхийг хангах зарчмуудын дагуу уян хатан бүтэцтэй, хүний эрхийг дээдэлсэн, гишүүдийн оролцоо, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад үе, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн оролцоог дэмжсэн, бодлогын нам болж ажиллах асуудлыг;

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт намын үйл ажиллагааг идэвхгүйд тооцох, өөрчлөн байгуулах, намын үйл ажиллагааг зогсоох, намыг тараах зохицуулалт;

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт улс төрийн намуудад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл шалгуур, түүний мөнгөн болон мөнгөн бус хэмжээ, хуваарилалт, шилэн санхүүжилтийн зарчим, зарцуулалтын зориулалт, гишүүний татвар, хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлогын талаар;

Хуулийн төслийн зургадугаар бүлэгт намууд санхүүгийн тайлан гаргах, тайланг мэдүүлэх, аудит хийлгэх, сонгуулийн төв байгууллага тайланг нягтлан шалгах, нийтэд мэдээлэх, улмаар намын тайлантай холбоотой алдаа зөрчилд тооцох хариуцлагын талаар, долдугаар бүлэгт бусад асуудлыг тусгав.

Хуулийн төсөл батлагдсанаар улс төрийн намын эрх зүйн орчин сайжирч энэ хүрээнд дараах эерэг үр дүн авчирна хэмээн үзэж байна. Үүнд:

1)Улс төрийн намын хариуцлага дээшилнэ. Намын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцэж, түүний санхүүжилт илт тод болох, намын гишүүдийн эрх, үүрэг, сахилга хариуцлага дээшлэх, санхүү болон үйл ажиллагааны тодорхой асуудлуудаар сонгуулийн төв байгууллагад тайланг гаргах замаар олон нийтийн хяналтыг сайжруулах эрх зүйн орчин бүрдэнэ;

2)Улс төрийн нам бодлогын институц болон төлөвшинө. Нам улсын хэмжээнд бодлого дэвшүүлэн ажиллах, үйл ажиллагаа, сонгуулийн мөрийн хөтөлбөр нь улс орноо хөгжлийн бодлогод захирагдан ажиллах, төрийн өндөр ёс зүйтэй алба хаагчийг бэлтгэх, төр ард түмний гүүр болж, иргэдэд улс төрийн боловсрол олгох институц болон төлөвших үндэс бүрдэнэ;

3)Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, хяналт сайжирна. Намын санхүүжилтэд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн механизмыг боловсронгуй болох, түүнийг хяналтыг олон нийтэд ил тод, нээлттэй, шилэн болгох чиглэлд эрх зүйн шинэтгэл хийгдэнэ. Намын санхүүжилт дан ганц сонгуулийн үед бус өдөр тутмын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй болох эрх зүйн үндэс бүрдэнэ. Түүнчлэн намд өгөх иргэд, аж ахуй нэгжийн хандив, түүнийг захиран зарцуулалтад

сонгуулийн төв байгууллага хяналт тавих замаар намын үйл ажиллагаа хариуцлагатай болон төлөвших үндэс бүрдэнэ;

4) Улс төрийн намын гишүүдийн тэгш оролцоог хангана. Намыг бодлогын институц болон төлөвших нэгэн гол үндэс нь намын гишүүнчлэлийн статусыг тодорхой болгох эрх зүйн үндэс бүрдүүлэх хэлбэрээр энэхүү шинэтгэл илрэн гарна. Энэ хүрээнд намын дэмжигч гишүүн хэмээх эрх зүйн орчныг бүрдүүлснээр намын бодлого, үйл ажиллагаанд ач холбогдол өгч, үнэт зүйлд үндэслэн бодлогын намын үйл ажиллагаанд дэмжин оролцох эрх зүйн үндэс бүрдэнэ. Түүнчлэн гишүүдийн тэгш оролцоог хангах, улс төрд төлөөлөл нь бага хангагдаж буй иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд жендерийн тэгш байдал, залуу болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын өөрчлөлт баталгаажих нөхцөл бүрдэнэ;

5) Улс төрийн намуудын дотоод ардчиллыг хөгжүүлнэ. Иргэдийн сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийг баталгааг хангах хүрээнд намын бүтэц, сонгууль, гишүүдийн оролцоог хуульд тусгах замаар намын дотоод ардчиллыг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлнэ хэмээн үзэж байна.

Дээрх цогц улс төрийн намын шинэтгэлийг хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын үндэс болсон иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө баталгаажиж, намд итгэх иргэдийн итгэл дээшилж, төрийн бодлого, шийдвэр гаргах явцад ард иргэдийн шууд оролцоо нэмэгдэж, улс төрийн намуудад өрсөлдөөний ижил нөхцөл бий болгож, авлигын түвшин бууруулахад эерэг үр дүн авчирна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

“XIV.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачлан боловсруулсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачлан боловсруулсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн 5.9-д “Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй тохирсон хязгаарлалт гэж үзвэл эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх үндсэн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болох”-оор хэт өргөн хүрээг хамааруулан тусгасан, түүнчлэн “тохирсон хязгаарлалт” гэдгийг хэрхэн үнэлэх нь тодорхойгүй байх тул уг хэсгийг дахин нягтлах.

2.Хуулийн төслийн 6.6-д “нам татан буугдсан, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдгийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхгүй байх”-аар тусгасан байна. Тус зохицуулалт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улс төрийн намын тухай хуульд байсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болсныг анхаарч үзэх.

Түүнчлэн, хуулийн төслийн 6.7-д заасан намын нэр, бэлгэ тэмдэг нь Оюуны өмчийн тухай хуулиар зохицуулагдахгүй тул уг зохицуулалтыг хасах.

3.Хуулийн төсөлд тусгасан “намын харьяа байгууллага” болон “намын бусад байгууллага” нь намын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд эрхлэх үйл ажиллагааны хувьд ямар ялгаатай байгууллага болох нь тодорхойгүй байна. Түүнчлэн, улс төрийн намын харьяа байгууллагад холбоо, сан зэрэг ашгийн төлөө бус байгууллага байхаар тусгасан нь оновчтой эсэхийг нягталж, тэдгээрийн үйл ажиллагааг намын зорилгод нийцүүлэн хуулийн этгээдийн эрхгүй клубийн зарчмаар явуулдаг байхаар тусгах.

Хэрэв холбоо, сан зэрэг хуулийн этгээдийн эрхтэй байгууллага байхаар бол тэдгээрийн санхүүгийн тайланг намын санхүүгийн тайлантай нэгдсэн байдлаар гаргаж, нээлттэй, ил тод тайлагнадаг байх зохицуулалтыг тусгах.

4.Хуулийн төслийн 11.1-д заасан намыг зохион байгуулах Их хурлын төлөөлөгчдийн квотыг тогтоох, хурлын ирц, гарах шийдвэрийг хүчинтэйд тооцох зохицуулалтыг тодорхой тусгах.

5.Хуулийн төсөлд улс төрийн намыг бүртгэхтэй холбоотой зохицуулалтыг ерөнхий байдлаар тусгасныг анхаарч, Улсын дээд шүүх намыг бүртгэх процедур, улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл, намыг бүртгүүлэх болон бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийлгэхэд бүрдүүлэх баримт бичиг, холбогдох бүртгэлийг хэн, ямар үндэслэл, журмаар хэрхэн хийх, улсын бүртгэлийн мэдээллийг санд хэрхэн оруулах, сангаас лавлагаа авах, маргаан бүхий асуудлаар тухайлсан чиг үүрэг бүхий улсын байцаагчийг Улсын дээд шүүхэд ажиллуулах эсэх зэргийг нарийвчлан тусгах.

6.Хуулийн төслийн 13.2.3, 13.2.4-т заасан зөрчлийг арилгуулах арга хэмжээг сонгуулийн төв байгууллага хэрэгжүүлсний үндсэн дээр шаардлага хангасан материалыг Улсын дээд шүүхэд хүргүүлэхээр заасан боловч төслийн 14.4.3, 14.4.4-т Улсын дээд шүүх мөн үндэслэлээр тухайн намыг бүртгэхээс татгалзахаар заасан нь агуулгын хувьд зөрчилдөж байгааг анхаарах.

7.Хуулийн төслийн 1.1-д заасан намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын эрх зүйн үндсийг тогтоох зорилтыг хангах хүрээнд төслийн 16.1-д заасан намын төлөөллийн төв болон гүйцэтгэх төв байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагааны талаар төсөлд тодорхой тусгах.

Мөн хуулийн төслийн 19.1-д заасан намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар тодорхой хуульчилж, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан намын бодлого боловсруулах механизмыг сайжруулах, намыг ардчилсан нийгмийн бодлого боловсруулагч гол институт болгон төлөвшүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг бүрэн тусгахад анхаарах.

8.Хуулийн төслийн 21.1-д заасны дагуу намыг идэвхгүйд тооцсон тухай шийдвэрийг гаргахаас өмнө энэ тухай мэдэгдэх, хугацаа зааж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааг нарийвчлан хуульчлахад анхаарах. Тухайлбал, төслийн 21.1.1-д заасан үндэслэлээр идэвхгүйд тооцогдсон нам тухайн зөрчлөө арилгахад төслийн 21.2-т заасан нөхцөлөөр хязгаарлагдаж байгаа тул зохицуулалтыг эргэн харж үзэх.

9.Хуулийн төслийн 25.5-д “Сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш санал хураалт явагдаж дуусах хүртэл намыг тараах асуудлыг Улсын дээд шүүх хянан шийдвэрлэхгүй” гэж тусгажээ. Хэрэв нам нь хуулийн төслийн 10.1.1-10.1.4-т заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан тохиолдолд тус намын үйл ажиллагаа хэвийн явагдах эсэх, санал хураалт явагдаж дууссаны дараа нам тарах эсэх, тухайн намаас сонгуульд нэр дэвшүүлж сонгогдсон тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх зэргийг нягтлах.

10.Хуулийн төслийн 26.7-д “нам нь төрийн санхүүжилтийг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр данстай байхыг хориглоно” гэж заасан боловч сонгуулийн бус үед бие даасан хуулийн этгээдийн эрх эдлэхгүй “эвсэл”-д данс нээх эсэх нь тодорхой бус байх бөгөөд хуулийн төслийн 27.10-д зааснаар эвсэлд олгох санхүүжилтийг аль дансанд олгохыг тодорхой болгох шаардлагатай. Мөн хуулийн төслийн 22.4-т зааснаар хөрөнгийг улсын орлого болгох, 26.6-д зааснаар төрийн санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх, эсхүл төрийн санхүүжилтээс хасаж тооцох шийдвэр гаргах этгээдийг тодорхойлох.

11.Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг бий болгох зорилгоор намын санхүүгийн тайланг шилэн болгохоор хуулийн төсөлд заасан бөгөөд уг

тайланд санхүүжилтийн хэмжээ, зарцуулалт, орлого зэргийг хамааруулжээ. Гэтэл нам нь санхүүжилтийн гол эх үүсвэрээ хандиваар бүрдүүлдэг учраас төсөлд тусгасан намын санхүүгийн тайланд хандивлагчийн талаарх мэдээллийг нэмж тусгах нь зүйтэй.

Түүнчлэн, хуулийн төслийн 33.6-д “Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээс нэг жилийн хугацаанд нэг намд өгөх хандив нь энэ хуулийн 33.8, 33.9-д заасан хэмжээнээс илүүгүй байна” гэж заасан боловч төслийн 33.7-д заасан иргэнээс авах хандивын дээд хэмжээний хязгаарын зохицуулалтыг эшлэхийг орхигдуулсныг залруулах.

12.Хуулийн төслийн 34.6.1, 34.6.2-т намд “гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын буюу гадаад улсын төрийн байгууллага, нам, хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжээс хандив авахыг хориглох”-оор заасан. Гэтэл хуулийн төслийн 35.5-д “Нам нь зээлийн гэрээний үндсэн дээр зээл авч болно” гэж дээрх этгээдүүдээс зээл авч болохоор нээлттэй байдлаар тусгасан нь улс төрийн намын хараат бус байх зорилгод нийцэх эсэхийг анхаарах.

13.Ээлжит бус сонгууль явагдсаны үндсэн дээр байгуулагдсан Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвсэл төрийн санхүүжилт хүсэх эрхтэй байх эсэхийг тодорхой болгох.

14.Хуулийн төсөлд намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох, санхүүжилтийг олгох, эсхүл зогсоох, торгох шийтгэл оногдуулах, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын сонгуульд нэр дэвшүүлэн оролцох эрхийг түдгэлзүүлэх, намыг идэвхгүйд тооцох, намыг тараах тухай дүгнэлт гаргах зэрэг өргөн чиг үүргийг сонгуулийн төв байгууллага хэрэгжүүлэхээр тусгасан нь чиг үүргийн төвлөрлийг бий болгох, улс төрийн намын үйл ажиллагаан дахь төрийн байгууллагын оролцоо, хяналтыг хэт нэмэгдүүлсэн болохыг анхаарч үзэх.

15.Хуулийн төсөлд намын үйл ажиллагаанд хориглох, хязгаарлах зохицуулалт ихээхэн орсон боловч тухайн хязгаарлалт, хориглолтыг үр дүнтэй болгох хөшүүрэг болон хяналтын механизм, шийтгэл оногдуулах этгээдийг тодорхой тусгаагүй байгааг анхаарах. Түүнчлэн, уул уурхай, банк, газрын тос импортлогчдоос нам хандив авдаг байдлыг хязгаарлаж, зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагыг тодорхой тусгах.

16.Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын дүнг үндэслэн гаргасан Зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжид тусгасан асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан. Тус зөвлөмжийн 2.1-д “2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу батлан гаргах хуулиудыг хойшлуулахгүйгээр баталж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүнг үзэх” гэж зөвлөсөн байх бөгөөд Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т “Сонгуульд өрсөлдөх улс төрийн намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх шаардлагыг тусгах; дээрх шаардлага хангагдаагүйгээс үүсэх хууль зүйн үр дагаврыг хуульчлах” гэсэн харилцааг Улс төрийн намын тухай хуульд тусгахаар заасан. Мөн зөвлөмжийн 2.5-д “улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалтыг ил тод, олон нийтийн хяналттай

болгох эрх зүйн шинэчлэлийг яаралтай хийх”, 2.6-д “улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзаж, бодлогын нам болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж тус тус заасан.

Иймд дээрх зөвлөмж болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт тусгасан асуудлуудыг цогцоор нь хуулийн төсөлд нэг мөр тодорхой тусгахад анхаарах.

17.Төсвийн тухай хуулийн 6.2.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх” гэж заасны дагуу холбогдох тооцоо, судалгааг гаргаж ирүүлээгүй байх тул төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтийг боловсруулах, түүнчлэн хуулийн төсөлд хийгдэх холбогдох судалгааг хийх, Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан хуулийн төслийн төрөл, бүтэц, хэлбэр, эх бичвэрт тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн төслийн боловсруулалтыг сайжруулах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам /цаашид “нам” гэх/ үүсгэн байгуулах, намын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Намын тухай хууль тогтоомж

2.1.Улс төрийн намын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“намын гишүүн” гэж намын зорилго, үзэл баримтлал, намын хөтөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр намд эвлэлдэн нэгдэж элссэн, гишүүний татвар төлдөг, тухайн намын үйл ажиллагаанд саналын болон сонгох, сонгогдох эрхтэйгээр оролцох иргэнийг;

3.1.2.“намын дэмжигч гишүүн” гэж намын зорилго, үзэл баримтлалыг сайн дурын үндсэн дээр дэмжин намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог иргэнийг;

3.1.3.“сонгуульт гишүүн” гэж намаас төрийн улс төрийн албан тушаалд нэр дэвшин сонгогдсон болон намын бүх шатны удирдах, төлөөллийн, гүйцэтгэх байгууллага, удирдах албан тушаалд сонгогдсон намын гишүүнийг;

3.1.4.“намын хөтөлбөр” гэж намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго, бодлогыг тодорхойлсон үндсэн баримт бичгийг;

3.1.5.“намын сонгуулийн мөрийн хөтөлбөр” гэж намын хөтөлбөрт үндэслэсэн тухайн төлөөлөгчдийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг;

3.1.6.“намын санхүүгийн тайлан” гэж тайлант хугацаанд намаас энэ хуулийн дагуу гүйцэтгэсэн орлого, зарлагын тооцоо, намын хөрөнгийн баланс, тэдгээрийн тайлбарыг нэгтгэсэн цахим болон хэвлэмэл мэдээллийн цогцыг;

3.1.7.“хандив” гэж иргэн, хуулийн этгээдээс намын өмчлөлд хариу төлбөргүйгээр шилжүүлсэн мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, биет ба биет бус хөрөнгө, үйлчилгээ, төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг;

3.1.8.“төрийн санхүүжилт” гэж төрөөс намд мөнгөн хэлбэрээр олгож буй хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэгийг;

3.1.9.“төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг” гэж энэ хуульд заасан нөхцөлийг хангасан намд олгох төрийн санхүүжилт болон төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг;

3.1.10.“төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг” гэж төрөөс намд олгож буй мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээний хэлбэрээр үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг;

3.1.11.“төрийн санхүүжилт авах эрх үүсэх жил” гэж Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус сонгуулийн дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг;

3.1.12.“намын гишүүнээс түдгэлзэх” гэж намын гишүүний эрхгүй, намын гишүүний эсхүл дэмжигчийн хувиар намын үйл ажиллагаанд оролцохгүй байхыг;

3.1.13.“гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дах хэсэгт заасныг;

3.1.14.“намын харьяа байгууллага” гэж намын зорилго, зорилтыг биелүүлэх хүрээнд намын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг эсхүл намын үйл ажиллагааны хүрээнд үүсгэн байгуулагдсан, намтай шууд эсхүл шууд бус холбоотой сан, холбоо болон төрийн бус байгууллагыг.

4 дүгээр зүйл. Нам, түүний чиг үүрэг

4.1. Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.

4.2.Нам нь Үндсэн хуульт байгуулал, ардчилсан тогтолцооны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.ард түмний улс төрийн хүсэл зориг, олон нийтийн үзэл бодлыг илэрхийлэх;

4.2.2.төр, ард түмний хооронд байнгын, тогтвортой, идэвхтэй холбоо харилцаа үүсгэх;

4.2.3.иргэдийн улс төрийн боловсрол, идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих;

4.2.4.төрийн улс төрийн алба хаах, хариуцлагатай иргэнийг бэлтгэх;

4.2.5.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцох;

4.2.6.сонгуульд нэр дэвшүүлэн шударгаар өрсөлдөх.

5 дугаар зүйл.Намд эвлэлдэн нэгдэх иргэний эрх

5.1.Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль тогтоомж болон тухайн намын дүрэм, намын хөтөлбөрт нийцүүлэн түүний үйл ажиллагаанд оролцох, намыг дэмжих, эс дэмжих эрхтэй.

5.2.Аль нэг намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд иргэнийг болон тухайн намыг аливаа хэлбэрээр мөшгөн хавчих, заналхийлэх, дарамтлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.

5.3.Намын гишүүн төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдвол уг албыг хаах хугацаанд намын гишүүнээс түдгэлзэнэ.

5.4.Иргэнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр эсхүл албадан намд элсүүлэх, эсхүл ийм зорилгоор хууль бус нөлөөлөл, шахалт үзүүлэхийг хориглоно.

5.5.Хуульд зааснаас бусад тохиолдолд намын гишүүн байх нь түүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, давуу байдал олгох үндэслэл болохгүй.

5.6.Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хувийн байдлыг тодорхойлсон албаны бичиг баримтад тухайн иргэний зөвшөөрөлгүйгээр аль нэг намын гишүүн болох талаар тодорхойлохыг хориглоно.

5.7.Намын гишүүн хэдийд ч намаас өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр намаас гарах эрхтэй. Намын гишүүнээс гарах тухай өргөдлийг гаргаснаар намаас гарсанд тооцно.

5.8.Төр, иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүрэгтэй.

5.9.Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй, тохирсон бөгөөд хуульд зааснаас өөр хязгаарлалтыг эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үндсэн эрх, эрх чөлөөг эдлэхэд тавьж үл болно.

5.10.Энэ хуулийн 5.9-д зөвшөөрсөн хязгаарлалт нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

5.11.Хуульд өөрөөр заагаагүй бол намын зүгээс төрийн байгууллага, албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

5.12.Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд намын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож үл болно.

5.13.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нам үүсгэн байгуулахад оролцохыг хориглоно.

6 дугаар зүйл. Намын нэр, бэлгэ тэмдэг

6.1.Нам нь оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд “нам” гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ.

6.2.Нам сонгуулийн сурталчилгаа болон бусад үйл ажиллагаанд зөвхөн намын бүртгэлд бүртгүүлсэн бүтэн болон товчилсон нэрийг хэрэглэнэ.

6.3.Сонгуульд эвсэл байгуулж оролцож буй намууд сонгуулийн үйл ажиллагаанд эвслийн гэрээнд заасан нэрийг хэрэглэнэ.

6.4.Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг нь төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, сүм хийд, өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй.

6.5.Орон нутаг дахь салбар нэгж нь намынхаа нэрийн өмнө тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг заасан тодотголыг хэрэглэнэ.

6.6.Нам татан буугдсан, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдгийг шинээр байгуулагдах болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно.

6.7.Намаас бусад хуулийн этгээд өөрийн оноосон нэрд “нам” гэсэн үг хэрэглэхийг хориглоно.

7 дугаар зүйл. Намын эрх, үүрэг

7.1. Нам дараах эрхийг эдэлнэ:

7.1.1. үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглааныг хуулийн хүрээнд санаачлан зохион байгуулах;

7.1.2. намын болон гишүүнийхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

7.1.3. хуульд өөрөөр заагаагүй бол намын бүтэц, зохион байгуулалт, зорилт, арга хэлбэрээ чөлөөтэй сонгох;

7.1.4. хуульд заасны дагуу орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, өөрийн өмчтэй байх;

7.1.5. Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох;

7.1.6. бусад намтай эвсэл байгуулах;

7.1.7. олон улсын байгууллага, бусад орны нам, байгууллагуудтай хамтран ажиллах, улс төрийн намуудын олон улсын байгууллагад гишүүнээр элсэх;

7.1.8. нам хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;

7.1.9. иргэдийн мэдээлэл авах, соён гэгээрүүлэх хүрээнд хуульд заасан үндэслэл журмын дагуу сум, дүүргийн соёлын төв, театр, иргэний танхимыг үнэ төлбөргүй ашиглах;

7.1.10. хуульд тогтоомжид заасан журмын дагуу намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулж, сонгогчдод танилцуулах, сурталчлах;

7.1.11. хуульд заасан бусад.

7.2. Нам нь Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх үүрэгтэй.

8 дугаар зүйл. Намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх

8.1. Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно.

8.2.Энэ хуулийн 17.1-д заасан байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход болон төрийн улс төрийн албан тушаалд намаас санал болгож сонгогдох, томилогдох нэр дэвшигчийг тодруулахад дараах шаардлагыг хангана:

8.2.1.нууц санал хураалт явуулах;

8.2.2.гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах;

8.2.3.аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх.

8.3.Энэ хуулийн 17.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх бөгөөд тодорхой асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр намын дүрэмд зааж болно.

8.4.Намын дүрэм, хөтөлбөрийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн саналыг сонсож оролцоог хангана.

8.5.Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана.

8.6.Нам бодлого, үйл ажиллагаандаа хувь хүн болон нийгмийн бүлгийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

8.7.Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 8.4-т заасны дагуу намын үйл ажиллагаа дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх тайланг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ.

8.8.Энэ хуулийн 8.2.3, 17.6-т заасан шаардлагыг хангаагүй намд тухайн зөрчлийг арилгах талаар сонгуулийн төв байгууллага сануулна. Ийнхүү сануулсан өдрөөс хойш 6 сарын дотор уул зөрчлийг арилгаагүй бол сонгуулийн төв байгууллага тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно.

9 дүгээр зүйл.Намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах

9.1.Хуульд өөрөөр заагаагүй бол намын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулна.

9.2.Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, бусад журам, санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг ил тод, нээлттэй байлгаж, нийтэд тогтмол мэдээлэх, мэдээлэл авах боломжоор хангана.

9.3.Нам өөрийн бүх шатны байгууллагын хуралдаан, санал хураалт, сургалт, зөвлөгөөн, гишүүн элсүүлэх, гишүүний татвар хураах, хандив цуглуулах болон бусад

ажиллагаа, нийгэмд болон гишүүдэд чиглэсэн арга хэмжээг цахимаар явуулж болно. Ингэхдээ сонгуулийн төв байгууллагаар баталгаажсан программ хангамжийг ашиглана.

9.4.Цахим хуралдаан, санал хураалтын үр дүнд гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно. Нам цахим хуралдаан, санал хураалтыг зохион байгуулахдаа цахим системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах боломжит арга хэмжээг авах бөгөөд нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд түүний нууцлалыг алдагдуулахгүй.

9.5.Нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягтай бол тэдгээрийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.

9.6.Нам цахим хуудастаа дараах баримт бичиг, мэдээллийг ил тод байршуулж, тухай бүр шинэчилнэ:

9.6.1.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;

9.6.2.намын дүрэм;

9.6.3.намын хөтөлбөр;

9.6.4.намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа хаяг;

9.6.5.намын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

9.6.6.намын удирдах дээд байгууллага эсхүл төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын төв байгууллагын дарга, гишүүний овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

9.6.7.намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

9.6.8.намын гишүүний тоо;

9.6.9.намын санхүүгийн тайлан;

9.6.10.намын үйл ажиллагааны товч тайлан;

9.6.11.нам аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх салбар нэгжтэй бол тэдгээрийн нэгжийн даргын овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

9.6.12.намын бүтэц, зохион байгуулалт;

9.6.13.намын үйл ажиллагааны мэдээлэл;

9.6.14.бусад мэдээлэл.

9.7.Намын дансанд хүлээж авсан хандивын болон бусад мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу намын цахим хуудаст байршуулна. Хандивлагчдыг мэдээлэхдээ хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг ил тод мэдээлнэ.

9.8.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан цахим хуудастаа байршуулж олон нийт, гишүүд, дэмжигчдэдээ нээлттэй танилцуулж байна.

9.9.Нам энэ хуулийн 9.6.1-9.6.7-д заасан баримт бичиг, мэдээлэлд өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

9.10.Сонгуулийн төв байгууллагын цахим хуудаст намын цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг, энэ хуулийн 9.6.1-9.6.7-д заасан намын баримт бичиг, мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчилнэ.

10 дугаар зүйл.Намын үйл ажиллагаанд хориглох зүйл

10.1.Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

10.1.1.Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэлд ноцтой аюул учруулах;

10.1.2.Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах аливаа үйл ажиллагаа явуулах;

10.1.3.зэвсэглэх эсхүл цэрэгжих, цэрэгжсэн бүтэцтэй болох, үймээн самуун дэгдээх, зорилгоо хүчирхийллийн замаар гүйцэлдүүлэх;

10.1.4.хүнийг үндэс, угсаа, яс үндэс, нас, хүйс, арьсны өнгө, нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхах;

10.1.5.энэ хуулийн 35.6-д хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах;

10.1.6.сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авах;

10.1.7.намаас бусад байгууллага, хуулийн этгээдийн бүтэц, үйл ажиллагааны хүрээнд намын салбар нэгж байгуулах;

10.1.8.хуульд заасан бусад.

10.2.Шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист түүнчлэн гадаад улсын намын салбар нэгжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулахыг хориглоно.

10.3.Энэ хуулийн 10.1.7-т заасан зөрчлийг арилгах шаардлагыг сонгуулийн төв байгууллага намд үндэслэл бүхий хугацаа заан хүргүүлэх бөгөөд заасан шаардлагыг хугацаанд биелүүлээгүй тохиолдолд уг зөрчлийг арилгах хүртэл сонгуульд намын нэрээ дэвшүүлэн оролцох эрхийг түдгэлзүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НАМ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

11 дүгээр зүйл. Нам үүсгэн байгуулах

11.1. Намыг зохион байгуулах Их Хурал /цаашид "үүсгэн байгуулах хурал" гэх/- аар үүсгэн байгуулна.

11.2. Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах ба зохион байгуулж явуулах газар, хугацааг нэг сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна.

11.3. Намыг үүсгэн байгуулах хуралд орон нутгаас төлөөлөх төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулна.

11.4. Намыг үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

11.4.1. намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдгийн загварыг батлах;

11.4.2. намын хөтөлбөр, дүрмийг батлах;

11.4.3. төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгон байгуулах, түүний зохион байгуулалтын бүтэц, эрх, үүргийг тогтоох;

11.4.4. намын даргыг сонгох;

11.4.5. нам үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах.

11.4.6. намыг үүсгэн байгуулах хурлаас нам үүсгэн байгуулсан тухай шийдвэр гарсан өдрийг тухайн нам үүсэн байгуулагдсан өдөрт тооцох бөгөөд энэ тухай нийтэд зарлан мэдээлнэ.

11.5. Монгол Улсын иргэд нам үүсгэн байгуулахад аливаа байгууллага, албан тушаалтны зүгээс дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

12 дугаар зүйл. Намыг бүртгүүлэх өргөдөл

12.1. Энэ хуулийн 11.3.4-д заасан намын даргаар сонгогдсон гишүүн эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нам үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн хамт сонгуулийн төв байгууллагад бичгээр хүргүүлнэ.

12.2. Намыг бүртгүүлэх өргөдлийг сонгуулийн төв байгууллагын баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд өргөдөл гаргагч гарын үсэг зурна:

12.2.1. өргөдөл гаргасан он, сар, өдөр;

12.2.2. намын нэр;

12.2.3. намын гүйцэтгэх төв байгууллагын хаяг;

12.2.4. намын үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;

12.2.5. өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл.

12.3. Намыг бүртгүүлэх өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

12.3.1. нам үүсгэн байгуулах тухай шийдвэр, уг шийдвэрт хуралдаан даргалагч эсхүл тэргүүлэгчид гарын үсэг зурсан байна;

12.3.2. намын бүтэн болон товчилсон нэрийн бичвэр, намын нэр, бэлгэдэл, далбааны зургийг тайлбарын хамт;

12.3.3. намын дүрэм;

12.3.4. намын хөтөлбөр;

12.3.5. намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа хаягийн нотлох баримт;

12.3.6. намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг/;

12.3.7. намын санхүүгийн асуудал хариуцсан ажилтны бүртгэл /овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг, иргэний үнэмлэхийн хуулбар/;

12.3.8.намын хөрөнгийн жагсаалт, намд өгсөн хандивын жагсаалт, намыг үүсгэн байгуулахтай холбогдон гарсан зардлын эх үүсвэр зэргийг тусгасан намын хөрөнгийн мэдээ;

12.3.9.нам үүсгэн байгуулах хурлын тов, байршлыг энэ хуулийн 11.2-т заасны дагуу мэдэгдэж, зарласан тухай баримт;

12.3.10.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

12.4.Энэ хуулийн 12.3.8-д заасан намын хөрөнгийн мэдээнд намыг бүртгүүлэх өргөдөл гаргахаас өмнө тухайн намын аль нэг үүсгэн байгуулагчийн нэр дээр банкны түр данс нээж намын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, гишүүний татвар, хандив, намыг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг тусгаж тайлагнана.

12.5.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 12.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийг хамт сонгуулийн төв байгууллагад хүргүүлж болно.

13 дугаар зүйл.Намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг нягтлан шалгах

13.1.Сонгуулийн төв байгууллага нь намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн өргөдөл, дагалдах баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

13.2.Сонгуулийн төв байгууллага нь өргөдөл, бичиг баримтад дараах зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уул зөрчлийг арилгаж, нэмэлт мэдээллийг ирүүлэх тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

13.2.1.энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу;

13.2.2.намын дүрэм нь энэ хуулийн 15.2-т заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй;

13.2.3.гишүүдийн тоо нь энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй, бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай эсхүл өөр хүн төлөөлсөн;

13.2.4.намын бүтэн нэр, товчилсон нэр, бэлгэдэл, далбаа энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй.

13.3.Сонгуулийн төв байгууллага намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, нягтлан шалгахдаа энэ хуулийн 12.3-т болон хуульд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

13.4.Сонгуулийн төв байгууллага намыг бүртгүүлэх өргөдөл, холбогдох баримтыг хүлээн авч, энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаанд нягтлан шалгаж

дуусгаснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх намыг бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

13.5.Намын бүртгэлийн жагсаалт, бүртгэлийн хувийн хэрэг, холбогдох мэдээллийг Сонгуулийн төв байгууллага эрхлэн хариуцна.

13.6.Нам хуулийн этгээд болох хувьдаа оршин байх албан ёсны хаяг, хөрөнгө түүний өөрчлөлттэй холбоотой бүртгэлийг холбогдох шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор Сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл.Намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах

14.1.Улсын дээд шүүх нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 13.4-д зааснаар ирүүлсэн өргөдөл, холбогдох барим бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тухайн намыг намын бүртгэлд бүртгэх эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж, ажлын гуч хоногийн дотор өргөдөл гаргагч, сонгуулийн төв байгууллагад бичгээр болон цахимаар хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

14.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 14.4-д зааснаас бусад тохиолдолд намыг улс төрийн намын бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргана.

14.3.Намыг улс төрийн намын бүртгэлд бүртгэх шийдвэрийг нийтэд мэдээлснээс хойш ажлын таван өдрийн дотор сонгуулийн төв байгууллага гэрчилгээ олгоно. Сонгуулийн төв байгууллага тухайн намын зорилго, үнэт зүйл, үзэл баримтлалын товч, гүйцэтгэх төв байгууллага, албан тушаалтны мэдээлэл, намын оршин байгаа хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаягийн талаарх мэдээлэл багтаасан танилцуулгыг нийтэд ил тод байршуулна.

14.4.Улсын дээд шүүх намыг дараах үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

14.4.1.намын дүрэм, хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан;

14.4.2.энэ хуулийн 10.1.1-10.1.3-т заасан үндэслэл байгаа бол;

14.4.3.гишүүдийн тоо нь энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй буюу бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн;

14.4.4.энэ хуулийн 6 дугаар зүйлийг зөрчин нэр хэрэглэсэн.

14.5.Улсын дээд шүүх тухайн намыг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг энэ хуулийн 14.1-т заасан хугацаанд гаргах бөгөөд уг шийдвэрт татгалзсан үндэслэлээ тодорхой заана. Энэхүү шийдвэрийг зохих этгээдэд албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлнэ.

14.6.Улсын дээд шүүх нь энэ хуулийн 14.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө өргөдөл гаргагч, сонгуулийн төв байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг мэдээлэл гаргуулан авч болно.

14.7.Энэ зүйлийн 14.1-д заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

14.8.Энэ хуулийн 14.5-т заасан шийдвэр гаргасан тохиолдолд уул зөрчлийг арилгасан этгээд энэ хуульд заасны дагуу намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12, 13 дугаар зүйлд заасан журмыг үндэслэн дахин гаргах эрхтэй.

14.9.Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалт болохоос 90 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг сонгуулийн төв байгууллага хүлээн авахгүй бөгөөд энэ хуулийн 13.1, 14.1-д заасан хугацаа түдгэлзэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

НАМЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

15 дугаар зүйл. Намын дүрэм

15.1. Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна.

15.2. Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана:

15.2.1. намын үзэл баримтлал, үнэт зүйл, зорилго;

15.2.2. намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;

15.2.3. намын гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс түдгэлзэх, гишүүний эрх, үүрэг, гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл;

15.2.4. намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага, бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам;

15.2.5. намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ;

15.2.6. намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

15.2.7. намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох арга, журам;

15.2.8.төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам;

15.2.9.намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах;

15.2.10.намын салбар болон бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах үндэслэл журам.

15.3.Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ.

15.4.Намын дүрэмд оруулсан энэ хуулийн 15.2.9-д зааснаас бусад нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх бөгөөд сонгуулийн төв байгууллага уг хүсэлтийг ажлын 3 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ.

15.5.Улсын дээд шүүх энэ зүйлийн 15.3-т заасны дагуу гаргасан хүсэлтийг 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

16 дугаар зүйл.Намын бүтэц, зохион байгуулалт

16.1.Нам нь намын удирдах дээд, төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагатай байна.

16.2.Намын бүтцийн нэгжийг намын дүрмээр зохицуулах бөгөөд энэ хуулийн 16.1-д зааснаас бусад байгууллагыг намын дүрмээр байгуулж болно.

17 дугаар зүйл.Намын удирдах байгууллага

17.1.Намын гишүүдийн эсхүл тэдгээрийн төлөөлөгчдийн хурал нь намын удирдах дээд байгууллага мөн бөгөөд түүнийг дөрвөн жил тутам нэгээс доошгүй удаа хуралдуулна.

17.2.Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:

17.2.1.намын дүрэм, хөтөлбөрийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

17.2.2.намын төлөөллийн төв байгууллагын болон хяналтын төв байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эдгээр байгууллагын тайланг дөрвөн жил тутам нэгээс доошгүй удаа хэлэлцэх;

17.2.3.намын нэрийг өөрчлөх, намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох;

17.2.4.намын дүрэмд заасан бусад асуудал.

17.3.Намын дүрэмд заасан тохиолдолд нам нь намын удирдах дээд байгууллагын чөлөө цагт ажиллах намын төлөөллийн төв байгууллагатай байх бөгөөд түүнийг жил тутам нэгээс доошгүй удаа хуралдуулна.

17.4.Намын дүрэмд заасны дагуу намын удирдах дээд байгууллага эсхүл төлөөллийн төв байгууллага нь намын гүйцэтгэх төв байгууллагыг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгоно. Гүйцэтгэх төв байгууллага нь гурваас доошгүй тооны гишүүнтэй байна.

17.5.Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага эсхүл төлөөллийн төв байгууллага, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг гүйцэтгэх төв байгууллага тус тус сонгоно.

17.6.Намын төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.

18 дугаар зүйл.Намын хяналтын байгууллага

18.1.Нам нь намын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, намын дүрмээр зохицуулах дотоод маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий хяналтын байгууллагатай байна.

18.2.Намын хяналтын төв байгууллагын гишүүнээр намын төлөөллийн болон гүйцэтгэх төв байгууллагын гишүүн, орон тооны ажилтныг сонгохыг хориглоно.

18.3.Намын хяналтын байгууллага хараат бусаар ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

18.4.Намын хяналтын байгууллага нь дор дурдсан маргааныг хянан шийдвэрлэж, шийдвэртээ үндэслэлээ тодорхой бичнэ:

18.4.1.намын дүрэм зөрчсөн эсэх;

18.4.2.нам болон түүний гишүүн хооронд үүссэн;

18.4.3.намын дотоод сонгуультай холбогдон үүссэн;

18.4.4.намын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой.

18.5.Энэ хуулийн 18.4-т заасан маргаан хянан шийдвэрлэх журмыг намын дүрэмд заасны дагуу батална. Энэ журам нь маргагч талаас тайлбар, нотлох баримт гаргаж өгөх, маргаан шийдвэрлэх хуралдаанд биечлэн оролцох зэргээр шударгаар хянан шийдвэрлүүлэх эрхийн баталгааг хангасан байна.

19 дүгээр зүйл.Намын бусад байгууллага

19.1. Намын бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий бодлогын судалгааны байгууллага намын дэргэд ажиллана.

19.2. Намын бодлогын судалгааны байгууллага сангийн хэлбэртэй байж болох бөгөөд үйл ажиллагаа, санхүүгийн тайланг энэ хуульд заасан журмын дагуу тайлагнах үүрэгтэй.

19.3. Энэ хуульд заасан намын бүтэц, зохион байгуулалтаас гадна нийгэм, эдийн засгийн болон бусад салбарын бодлогын асуудлаар зөвлөлдөх, намын бодлого, үйл ажиллагаа нь хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдалд нийцэж буй эсэхийг үнэлэх зэрэг чиг үүрэгтэй бүтцийн нэгж байгуулах эсэхийг нам дүрмээрээ зохицуулж болно.

20 дугаар зүйл. Намын гишүүний эрх, үүрэг, баталгаа

20.1. Намын гишүүн дараах эрхтэй байна:

20.1.1. намын үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох;

20.1.2. намын бүтцийн байгууллагад сонгох, сонгогдох;

20.1.3. намын дүрэмд заасан бусад эрх.

20.2. Намын гишүүн дараах үүрэг байна:

20.2.1. намын дүрэмд заасан татвар төлөх;

20.2.2. хууль тогтоомж, намын дүрэмд захирагдах;

20.2.3. намын дүрэмд заасан бусад үүрэг.

20.3. Намын дэмжигч гишүүн нь намын дүрэмд зааснаас гадна энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 болон 20.2.2 дах хэсэг заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

20.4. Намын гишүүнээс хасах асуудлыг тогтоосон журмын дагуу намын хяналтын байгууллага шийдвэрлэнэ.

20.5. Намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд намын гишүүнээс хасахыг хориглоно.

20.6. Нам, намын гишүүний бүртгэлийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн хөтөлж, жил бүр шинэчилнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НАМЫГ ИДЭВХГҮЙД ТООЦОХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

21 дүгээр зүйл. Намыг идэвхгүйд тооцох

21.1. Сонгуулийн төв байгууллага дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэр гаргана:

21.1.1. Улсын Их Хурлын ээлжит сонгуульд хоёр удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй;

21.1.2. Энэ хуулийн 37.2-т заасан үүргээ зөрчин 2 жил дараалан санхүүгийн тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй;

21.1.3. Намын удирдах дээд байгууллагыг эсхүл төлөөллийн төв байгууллагыг 5 жилийн хугацаанд хуралдуулаагүй.

21.2. Намыг идэвхгүйд тооцсон бол тухайн намд олгох төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд нам бүх шатны сонгуульд оролцох эрхгүй болно. Энэ хугацаанд намын гишүүний аливаа сонгуульд бие даан нэр дэвших эрхийг үл хязгаарлана.

21.3. Энэ хуулийн 21.1-д заасан хугацаанд тухайн зөрчлийг арилгасан болохоо мэдэгдэж, холбогдох нотлох баримтын хамт сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

21.4. Энэ хуулийн 21.3-т заасан нотлох баримтыг сонгуулийн төв байгууллага хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянан үзэж, намыг идэвхтэйд тооцох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

21.5. Сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш санал хураалт явагдаж дуусах хүртэл намыг идэвхгүйд тооцох шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргахгүй.

21.6. Энэ хуулийн 21.1-д заасан сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн талаарх маргааныг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.6, 112.2-т зааснаар шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл. Намыг татан буулгах

22.1. Намын удирдах дээд байгууллагын шийдвэрээр намыг өөрчлөн байгуулах, түүний үйл ажиллагааг зогсоох, эсхүл Улсын дээд шүүхийн шийдвэрээр намыг тараах замаар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгана.

22.2. Сонгуулийн төв байгууллага нь энэ хуулийн 23.1 эсхүл 25.3-т заасан шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор уг намыг намын бүртгэлээс

хасаж гэрчилгээг нь хүчингүй болгох бөгөөд энэ тухай мэдээллийг сонгуулийн төв байгууллагын цахим хуудаст байнга байршуулж, нийтэд түгээнэ.

22.3.Татан буугдсан намын хөрөнгийг гишүүдэд хуваарилахыг хориглоно.

22.4.Энэ хуулийн 23.6-д заасныг зөрчиж өөрчлөн байгуулагдсан намын өмч, хөрөнгийг эзэмшил, өмчлөлдөө байлгасан, 22.3-т заасныг зөрчин гишүүддээ хуваарилсан тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол хураан авч, улсын орлого болгоно.

22.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол татан буулгах комисс томилох зэрэг намыг татан буулгахтай холбогдсон бусад харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

23 дугаар зүйл.Намыг өөрчлөн байгуулах

23.1.Нам энэ хуульд заасны дагуу нийлэх, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдаж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг намын удирдах дээд байгууллага гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

23.2.Нийлсэн намуудын эрх, үүрэг, хариуцлага, эд хөрөнгө нь нийлэх замаар өөрчлөн зохион байгуулагдсан намд шилжих бөгөөд уг нам энэ хуульд заасны дагуу шинээр бүртгүүлнэ.

23.3.Нийлэх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа намууд нь аль нэг намынхаа нэрийг шинээр байгуулсан намын нэр болгон хэрэглэж болно.

23.4.Нийлэх замаар өөрчлөн байгуулагдсан намуудаас хамгийн эхэнд байгуулагдсан намын өдрөөр төлөөлүүлэн уг намын үүсгэн байгуулагдсан өдрийг тодорхойлно.

23.5.Нам үйл ажиллагаагаа зогсоож өөр намтай нэгдсэн бол тэр намын эрх, үүрэг, хариуцлага, намын гишүүдийн харьяалал, эд хөрөнгө нэгтгэн авсан намд шилжинэ.

23.6.Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан тохиолдолд түүний өмч, хөрөнгийг дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно.

23.7.Намыг өөрчлөн байгуулахтай холбогдсон бусад харилцааг Иргэний хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

24 дүгээр зүйл.Намын үйл ажиллагааг зогсоох

24.1.Намын үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэрийг намын удирдах дээд байгууллага гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

24.2.Үйл ажиллагаагаа зогсоосон намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.

25 дугаар зүйл.Намыг тараах

25.1.Энэ хуулийн 10.1.1-10.1.3-т заасан хориглолтыг зөрчсөн тохиолдолд сонгуулийн төв байгууллага намыг тараах тухай дүгнэлт гаргаж Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан дүгнэлтийг сонгуулийн төв байгууллага нийт гишүүдийн дөрөвний гурвын саналаар гаргана.

25.3.Намыг тараах тухай сонгуулийн төв байгууллагын дүгнэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүх нийт шүүгчийн хуралдаанаар хянан хэлэлцэх бөгөөд энэ хуулийн 25.1-д заасан үндэслэл тогтоогдвол намыг тараах тухай шийдвэр гаргаж, ажлын 10 өдрийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

25.4.Энэ зүйлийн 25.3-т заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

НАМЫН САНХҮҮЖИЛТ

26 дугаар зүйл.Намын орлогын эх үүсвэр

26.1.Намын орлого нь дараах эх үүсвэртэй байна:

26.1.1.төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;

26.1.2.гишүүний татвар;

26.1.3.хандив;

26.1.4.намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого;

26.1.5.энэ хуулийн 36.3-т заасан бусад орлого.

26.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу төрөөс намд үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу олгох төрийн санхүүжилт болон энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгээс бүрдэнэ.

26.3.Жил бүрийн намд олгох төрийн санхүүжилтийн дор дурдсан хувийг дараах зориулалтаар зарцуулна:

26.3.1.төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сурган бэлтгэх;

26.3.2.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг олон нийтэд таниулах;

26.3.3.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх.

26.4.Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар зарцуулна.

26.5.Энэ хуулийн 26.3-т заасан санхүүжилтийг тухайн зорилгоос өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

26.6.Төрийн санхүүжилтийн холбогдох хувийг энэ хуулийн 26.3-т заасныг зөрчин зарцуулсан бол хууль бусаар зарцуулсан хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх эсхүл дараагийн төрийн санхүүжилтээс хасан тооцно.

26.7.Нам нь энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр данстай байхыг хориглоно. Тус хориглолт нь энэ хуулийн 34.4, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлд хамаарахгүй.

26.8.Нам нь энэ хуулийн 26.1-т заасан орлогыг цахим мөнгөн хэрэгсэл /крипто валют, NFT зэрэг/-ээр хүлээн авахыг хориглоно.

27 дугаар зүйл.Төрийн санхүүжилт

27.1.Улсын Их Хурлын ээлжит эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид “нийт сонгогч” гэх/-ийн тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувиар үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу хуваарилах замаар төрийн санхүүжилт олгоно.

27.2.Төрийн санхүүжилтийн хэмжээ нь энэ хуулийн 27.1, 27.8-т зааснаас хэтрэхгүй байна.

27.3.Нийт сонгогчийн 2-оос дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно.

27.4.Энэ хуулийн 27.3-д заасан шаардлагыг хангаагүй намд төрийн санхүүжилт олгохыг хориглоно.

27.5.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд дараах томъёогоор төрийн санхүүжилтийг жил бүр олгоно.

$$H = (C1 * T1) + (C2 * T2)$$

27.6.Энэ хуулийн 27.5-д заасан томъёо дахь дараах тэмдэглэгээг доор дурдсан утгаар ойлгоно:

27.6.1.“Н” гэж нийт сонгогчийн 2-оос дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг;

27.6.2.“С1” гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог;

27.6.3.“С2” гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог;

27.6.4.“Т1” гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг;

27.6.5.“Т2” гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг.

27.7.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.

27.8.Энэ хуулийн 27.6.2-т заасан саналын тоог дараах байдлаар тооцно:

27.8.1.хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоогоор сонгууль явуулбал намын нэрсийн жагсаалтаар авсан хүчинтэй саналын хувь;

27.8.2.нэг мандаттай олонхын тогтолцоогоор сонгууль явуулбал нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын хувь;

27.8.3.олон мандаттай олонхын тогтолцоогоор сонгууль явуулбал нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын нийлбэрийг энэ хуулийн 27.7.2-т заасантай дүйцүүлэн гаргасан саналын хувь;

27.8.4.холимог тогтолцоогоор сонгууль явуулбал энэ хуулийн 27.8.1, 27.8.2, 27.8.3-т заасан аргачлалаар тооцсон нийлбэр саналын хувь.

27.9.Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын энэ хуулийн 36.3.1-36.3.3-д заасан орлогын нийлбэрээс хоёр дахин их эсхүл түүнээс илүү байж болохгүй.

27.10.Хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн нам эвсэл болж сонгуульд оролцсон тохиолдолд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийг эвсэлд олгоно. Эвсэлд олгосон санхүүжилтийг энэ хууль болон эвслийн гэрээгээр хуваарилна.

27.11.Нам тарах, намыг идэвхгүйд тооцсон, татан буулгасан, эсхүл эвсэл тарсан бол энэ тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн нам, эвсэлд олгох төрийн санхүүжилтийг сонгуулийн төв байгууллага зогсооно.

28 дугаар зүйл.Төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах

28.1.Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд төрийн санхүүжилт авах зорилгоор уул санхүүжилтийн хэмжээг тогтоолгох, санхүүжилт авах тухай хүсэлтээ нам тухайн жилийн өмнөх жилийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн төв байгууллагад гаргана. Энэ хуулийн 28.1-д заасан хугацаанд хүсэлт гаргаагүй бол сонгуулийн төв байгууллага энэ тухай сануулж, 30 хоногийн дотор хүсэлт гаргах боломж олгоно.

28.2.Намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан энэ хуулийн 28.1-д заасан хүсэлтийг сонгуулийн төв байгууллагаас гаргасан маягтын дагуу гаргана. Энэ маягтад намын шуудангийн хаяг, намын дансны дугаар зэрэг мэдээллийг бичихээр тусгана.

28.3.Намын төв байгууллага нь нийт намыг төлөөлж нэгдсэн хүсэлт гаргана.

28.4.Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн өмнөх онд сонгуулийн төв байгууллага төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоосон шийдвэр гаргасан бол төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд нам шинээр хүсэлт гаргах шаардлагагүй. Төрийн санхүүжилтийн хэмжээнд нөлөөлөх өөрчлөлт гарсан бол сонгуулийн төв байгууллагад даруй мэдэгдэх бөгөөд энэ талаар цаг тухайд нь мэдэгдээгүйн үр дагаврыг нам хариуцна.

28.5.Нам энэ хуулийн 27.5-д заасны дагуу үүссэн эрхээсээ татгалзах эрхтэй бөгөөд ийнхүү татгалзсан тохиолдолд тухайн намд олговол зохих төрийн санхүүжилт улсын төсөвт үлдэнэ.

29 дүгээр зүйл.Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох

29.1.Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 9 дүгээр сарын 15-наас өмнө төрийн санхүүжилт авах эрх бүхий нам бүрд төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн санхүүжилтийн хэмжээг энэ хуульд заасны дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан шийдвэрийн дагуу олгох санхүүжилтийг дараа жилийн 01 дүгээр сарын 01-нээс эхлэн энэ хуульд өөрөөр заагаагүй бол ээлжит болон ээлжит бус сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан тухайн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл хугацаанд жил бүр 2 удаа олгоно.

29.3.Сонгуулийн төв байгууллага нь намаас энэ хуулийн 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангаж ирүүлсэн тайланг үндэслэн энэ хуулийн 28 дугаар зүйлд заасныг баримтлан төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож олгоно.

29.4.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланг нягтлан шалгах ажиллагаа явуулж буй бол уул ажиллагаа дууссаны дараа санхүүжилтийн хэмжээг эцэслэн тогтооно.

29.5.Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох үндэс суурь нь төрийн санхүүжилт авах намын эрх үүссэн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө хамгийн сүүлд явагдсан Улсын Их Хурлын сонгуулиар авсан хүчинтэй саналын тоо болон энэ хуулийн 27.5-д заасан бусад үзүүлэлт байна.

29.6.Энэ хуулийн 29.2-т заасан хугацаанд хагас жилийн тайланг ирүүлээгүй бол энэ хуулийн 27.5-д заасны дагуу тухайн намын авсан хүчинтэй саналын тоо (С1)-нд суурилсан төрийн санхүүжилтийн хэсгийг олгохгүй.

29.7.Тайлангийн агуулга алдаа, зөрчилтэй эсэхээс үл хамааран тайлангаа энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан бүтэц, хэлбэрээр 38.12-т заасан аудитын тэмдэглэлийн хамт тогтоосон хугацаанд ирүүлбэл хугацаа баримталсанд тооцно.

29.8.Бусад намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээ, олголт нь тухайн нэг намын үйлдлээс шалтгаалан өөрчлөгдөхгүй.

29.9.Энэ хуулийн 27.8-д дурдсан хязгаарыг тооцон бодоход тайлант жилд авч, тайланд нийтлэгдсэн намын орлогын хэмжээг энэ хуулийн 36.3.1-37.3.3-д үндэслэнэ.

29.10.Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоохдоо эхлээд нам бүрээр энэ хуулийн 29.7-д заасан хязгаарыг, дараа нь энэ хуулийн 27.1-д заасан хязгаарыг баримтална. Төрийн санхүүжилт энэ хуулийн 27.1-д заасан хязгаараас давж хэтрэх тооцоо гарсан бол уул хязгаартай тэнцүү санхүүжилтийг намуудад ногдох хувь хэмжээгээр нь олгоно.

29.11.Төрийн санхүүжилтийг хуваарилахад харгалзан үзэх тухайн намд өгсөн хүчинтэй саналын тоо нь түүнд нөхөн болон дахин сонгуулийн дүн, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу өөрчлөлт орсноос бусад тохиолдолд тухайн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөгдөхгүй.

30 дугаар зүйл.Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг

30.1.Нийт сонгогчийн 1 хувиас доошгүй санал авсан нам нь сонгуулийн бус жилд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг дараах хэлбэрээр авах эрхтэй:

30.1.1.намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулахад төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд 1 удаа үнэ төлбөргүй ашиглах;

30.1.2.хуваарийн дагуу намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг үндэсний олон нийтийн радио, телевизээр жилд гучин минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэг авах тухай намын хүсэлтийг үндэслэн 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллага шийдвэрлүүлнэ.

30.3.Энэ хуулийн 30.1.1-д заасан байгууллага уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах, энэ хуулийн 30.1.2-д заасны дагуу Үндэсний олон нийтийн радио, телевиз үнэ төлбөргүй нэвтрүүлэх үүрэгтэй.

30.4.Энэ хуулийн 30.1.2-т заасан нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд төрөөс үзүүлсэн шууд бус дэмжлэгийг дурдана.

30.5.Сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс санал хураалтын дүн гарах хүртэл хугацаанд энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэгийг намд үзүүлэхгүй.

31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт

31.1.Намд олгох төрийн санхүүжилт болон төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгт шаардагдах зардлыг жил бүр сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлуулна.

31.2.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллага намд олгох төрийн санхүүжилт болон төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг зөв тогтоож олгосон эсэх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.

32 дугаар зүйл.Гишүүний татвар

32.1.Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно.

32.2.Гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байна.

32.3.Сонгуульт гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

32.4.Гишүүний татварыг тухайн намын гишүүн зөвхөн өөрийн орлогоос төлнө.

32.5.Намын гишүүн нь бусад гишүүний өмнөөс гишүүний татвар төлөхийг хориглоно.

32.6.Нам өөрийн дүрэм, журмаар намын гишүүний татварыг хөнгөлөх, чөлөөлөхөөр зохицуулж болно.

32.7.Хуульд өөрөөр заагаагүй бол намын гүйцэтгэх төв байгууллага нь гишүүний татвар төлсөн баримтыг арван жилийн хугацаанд архивлан хадгална.

32.8.Намын гишүүнээс энэ хуулийн 32.2, 32.3-т заасны дагуу төлөх татвар, намд өгөх бусад аливаа мөнгийг хандив гэж үзэх бөгөөд тэдгээрийн нийлбэр нь энэ хуулийн 33.8-д заасан хэмжээнээс илүүгүй байна. Бүх төрлийн гэнэтийн зардлыг гишүүдэд ногдуулан хуваарилах, мөнгө цуглуулах, мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эд хөрөнгө намд өгөхийг хандивт тооцно.

33 дугаар зүйл.Хандив

33.1.Хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна.

33.2.Иргэний болон хуулийн этгээдийн мөнгөн хандивыг зөвхөн намын дансаар хүлээн авах бөгөөд бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно. Гишүүний татвар болон хандивыг тооцооны нэг дансанд байршуулна.

33.3.Дараах зүйл нь үнэ төлбөргүйгээр эсхүл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хийгдэж буй тохиолдолд мөнгөн бус хандивт хамаарна:

33.3.1.хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялгийг ашиглуулах, эзэмшүүлэх;

33.3.2.үйлчилгээ үзүүлэх;

33.3.3.төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх;

33.3.4.арга хэмжээний зардлыг төлөх;

33.3.5.ивээн тэтгэх.

33.4.Хандивыг мөнгөн бус хэлбэрээр авах тохиолдолд түүнийг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн үнэлэн бүртгэж, мөнгөн дүнгээр илэрхийлэн санхүүгийн тайланд тусгана.

33.5.Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.

33.6.Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээс нэг жилийн хугацаанд нэг намд өгөх хандив нь энэ хуулийн 33.8, 33.9-т заасан хэмжээнээс илүүгүй байна. Намд өгсөн хандивын хэмжээг уг нам, түүний салбар болон бүтцийн нэгжид өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.7.Нэг жилд нэг иргэнээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван хоёр дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.8.Нэг жилд нэг хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.9.Хуулийн этгээдийн намд өгсөн хандивын хэмжээг уг хуулийн этгээд, хуулийн этгээдийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрын өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно. Намд өгсөн хандивын хэмжээг мөнгөн болон мөнгөн бус хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.10.Хандивлагч намын салбар болон бүтцийн нэгжид нэр заан өгсөн хандивыг тухайн зориулалтын дагуу захиран зарцуулна.

33.11.Намын харьяа байгууллага нь энэ хуулийн 34.6, 34.7-д хориглосон этгээдээс хандив авахыг хориглоно.

33.12.Нэг хуулийн этгээд эсхүл иргэнээс намд болон тухайн намын харьяа байгууллагад өгөх нийт хандив нь энэ хуулийн 33.7, 33.8-д зааснаас илүүгүй байна.

33.13.Намын харьяа байгууллагад өгөх байгууллага нь санхүүгийн тайлангаа энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан шаардлагын дагуу гаргаж тухайн намд болон сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

34 дүгээр зүйл.Хандивтай холбогдуулан хүлээх үүрэг, хориглох зүйл

34.1.Нам дараах хандив өгсөн иргэний овог, нэр эсхүл хуулийн этгээдийн нэр, хандивын хэмжээ, хандивыг хүлээн авсан огноог цахим хуудастаа хайлт хийх боломжтой нээлттэй өгөгдлийн санд улирал татам байршуулж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх бөгөөд уул мэдээллийг намын санхүүгийн тайланд тусгайлан заана.

34.1.1.нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх эсхүл түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн;

34.1.2.нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх эсхүл түүнээс дээш төгрөгийн үнийн дүнтэй мөнгөн бус хандив.

34.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 34.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор цахим хуудастаа нийтэлж, ил тод, нээлттэй байлгана. Иргэн, хуулийн этгээд энэ хуульд тусгасан хандивын дээд хэмжээнд багтаан нэгээс дээш удаа хандив өгсөн бол хандивын дүнг өмнөх хандивын дүн, хүлээн авсан огнооны хамт мэдээлнэ.

34.3.Нам энэ хуулийн 34.1-д заасан мэдээллийг нээлттэй өгөгдлийн санд улирал тутамд байршуулаагүй эсхүл сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй бол тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг олгохгүй.

34.4.Нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс бага хандивыг намын санхүүгийн тайланд тусгана.

34.5.Нам хандивтай холбогдуулан дараах үүрэг хүлээнэ:

34.5.1.хандивлагч хандив өгөх эрхтэй эсэхийг хуулийн дагуу тодорхойлох;

34.5.2.хандивлагчийн нэр, хаягийн талаар бүртгэл хөтлөх;

34.5.3.энэ хуулийн 34.6, 34.7-д хориглосон этгээдээс хандив өгсөн бол хандивыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад энэ тухай мэдэгдэж, хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх;

34.5.4.нэр хаяг нь тодорхойгүй, буцаах боломжгүй хандивыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад мэдэгдэж, сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх;

34.5.5.хандив болон хандивлагчийн мэдээллийг санхүүгийн тайланд тусгаж, сонгуулийн төв байгууллагад мэдэгдэх, сонгуулийн төв байгууллагын шаардсан нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгөх;

34.5.6.энэ хуульд заасан бусад.

34.6.Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно:

34.6.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

34.6.2.гадаад улс буюу гадаад улсын төрийн байгууллага, нам, хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж;

34.6.3.төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

34.6.4. үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо;

34.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, тэдгээрийн захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, бусад удирдах албан тушаалтан;

34.6.6. арван найман нас хүрээгүй Монгол Улсын иргэн;

34.6.7. байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд;

34.6.8. тодорхой нэр, хаяггүй этгээд эсхүл нэр нь тодорхойгүй гуравдагч этгээдийн хандивыг дамжуулж буй нь илэрхий этгээд;

34.6.9. өөртөө эсхүл бусдад давуу байдал бий болгох зорилгоор хандив өгч буй этгээд;

34.6.10. бусад иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс мөнгөн болон мөнгөн бус хандивыг намд өгч буй иргэн, хуулийн этгээд;

34.6.11. дампуурсан хуулийн этгээд;

34.6.12. хуулиар хориглосон бусад этгээд.

34.7. Иргэдийн улс төрийн боловсрол, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дэмжих эсхүл тухайн намыг ардчилсан зарчмын дагуу бэхжүүлэх зорилгоор хамтарч ажиллах хүрээнд олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтран зохион байгуулах арга хэмжээ, хэрэгжүүлэх төслийн санхүүжилт энэ хуулийн 34.6.2-т хамаарахгүй.

34.8. Хандивлагч өөртөө, бусдад давуу байдал бий болгох зорилгоор хандив өгөхийг хориглоно.

34.9. Намд хандив өгснийхөө төлөө хандивлагч нь өөртөө болон бусдад аливаа давуу байдал олгохыг болон намын дотоод асуудлыг ардчилсан бус зарчмаар шийдвэрлэхийг шаардах, шахалт үзүүлэхийг хориглоно.

34.10. Хандивлагч нь намд хандив өгөхдөө бусад этгээдийн нэр, хаяг, мэдээллийг ашиглахыг хориглоно.

34.11. Иргэн, хуулийн этгээд нь бусад иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс мөнгөн болон мөнгөн бус хандивыг намд өгөхийг хориглоно.

35 дугаар зүйл. Намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого

35.1. Нам нь тухайн намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар орлого олж болно.

35.2.Энэ хуулийн 35.1-д зааснаас өөр аж ахуйн үйл ажиллагаанаас орлого олохыг хориглоно.

35.3.Энэ хуулийн 35.1-д заасан худалдан борлуулах үнэ зах зээлийн дундаж ханшаас их байвал түүнийг намд өгсөн хандивт тооцох бөгөөд түүний хэмжээ энэ хуулийн 35.8, 35.9-т зааснаас илүүгүй байна.

35.4.Намын нэг жилд өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого нь тухайн намд олгосон төрийн санхүүжилтийн 50 хувиас ихгүй байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

НАМЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

36 дугаар зүйл.Намын санхүүгийн тайлан

36.1.Намын санхүүгийн тайлан нь энэ хуульд заасан орлого, зарлагын тооцоо, түүнтэй холбоотой хөрөнгийн баланс болон тайлбар хэсгээс бүрдэнэ.

36.2.Нам санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагын дагуу гаргана.

36.3.Орлогод дараах зүйлийг бүртгэнэ:

36.3.1.намын гишүүний татвар;

36.3.2.сонгуульт гишүүний татвар;

36.3.3.иргэний өгсөн хандив;

36.3.4.хуулийн этгээдийн өгсөн хандив;

36.3.5.аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;

36.3.6.намын өөрийн хөрөнгөөс олсон орлого;

36.3.7.арга хэмжээ зохион байгуулах, ном болон нийтлэл хэвлэн борлуулах үйл ажиллагаанаас олсон орлого;

36.3.8.төрийн санхүүжилт;

36.3.9.төрөөс үзүүлсэн шууд бус дэмжлэг;

36.3.10.бусад орлого;

36.3.11.энэ зүйлийн 36.3.1-36.3.10-т заасан нийт орлого.

36.4.Зардалд дараах зүйлийг бүртгэнэ:

36.4.1.цалин хөлс;

36.4.2.урсгал зардал;

36.4.3.энэ хуулийн 26.3.1-т заасан үйл ажиллагааны зардал;

36.4.4.энэ хуулийн 26.3.2-т заасан үйл ажиллагааны зардал;

36.4.5.энэ хуулийн 26.3.3-т заасан үйл ажиллагааны зардал;

36.4.6.энэ хуулийн 36.4.3, 36.4.4, 36.4.5-д зааснаас бусад үйл ажиллагааны зардал;

36.4.7.сонгуулийн зардал;

36.4.8.эд хөрөнгийн ашиглалтын зардал;

36.4.9.аж ахуй эрхлэх зардал;

36.4.10.бусад зардал;

36.4.11.энэ зүйлийн 36.4.1-36.4.8-т заасан нийт зардал.

36.5.Хөрөнгийн балансад дараах зүйлийг бүртгэнэ:

36.5.1.эд хөрөнгө:

36.5.1.а.байшин, газар;

36.5.1.б.ажлын байрны тоноглол, техник хэрэгсэл.

36.5.2.эргэлтийн хөрөнгө:

36.5.2.а.намын салбар байгууллагаас авах авлага;

36.5.2.б.төрөөс авах санхүүжилт;

36.5.2.в.бэлэн мөнгөний үлдэгдэл;

36.5.2.г.хуримтлал;

36.5.2.д.бусад эд хөрөнгө.

36.5.3.энэ зүйлийн 36.5.1-36.5.2-т заасан нийт эд хөрөнгө.

36.5.4.өр:

36.5.4.а.намын салбар байгууллагад өгөх мөнгө;

36.5.4.б.төрийн санхүүжилтийн төрд буцааж төлөх мөнгө.

36.5.5.энэ зүйлийн 36.5.4-т заасан нийт өр.

36.6. Намын бүх орлого, зарлагыг тайланд зохих ёсоор бүрэн дүнгээр бүртгэн, хөрөнгийн балансад тусгана.

36.7. Намын хандивыг дараах үзүүлэлтээр бүртгэнэ:

36.7.1. намын дансанд төвлөрүүлсэн нийт хандивын хэмжээ, хандивлагчдын тоо;

36.7.2. хандивлагч иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хандивын хэмжээ, хэлбэр, мөнгөн бус хандивын үнэлгээ;

36.7.3. хандивлагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа хаяг, гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хандивын хэмжээ, хэлбэр, мөнгөн бус хандивын үнэлгээ.

36.8. Иргэн намын дансанд мөнгөн хандив шилжүүлэхдээ өөрийн орлогоос шилжүүлэх бөгөөд төлбөрийн даалгаварт эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, байнга оршин суугаа газрын хаяг, регистрийн дугаарыг тус тус заана.

36.9. Нам хандивыг сонгуулийн төв байгууллагаас баталсан бүртгэлийн маягтын дагуу цаасаар болон цахимаар бүртгэнэ.

36.10. Мөнгөн бус хөрөнгийг ижил төстэй хөрөнгийн зах зээлийн жишиг үнээр үнэлж мөнгөн дүнгээр бүртгэнэ.

36.11. Эд зүйлийг худалдах, зарцуулахад түүний эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнээр зарлага гаргана.

36.12. Намын орон нутгийн салбар хооронд хийгдсэн дотоодын суутган тооцоонд хөрөнгө зарцуулсан салбар дээр зарлагын бүртгэл хийгдэнэ.

36.13. Нам тайландаа нэмэлт тайлбар хавсаргаж болно.

36.14. Намын санхүүгийн тайланд намын салбар болон бүтцийн нэгж, бодлогын судалгааны байгууллага зэрэг түүний дэргэдэх, харьяа байгууллагын санхүүгийн тайланг тусгана.

36.15. Намын нэгдсэн тайланд намын төв байгууллагын тайланг доод шатны намын салбар нэгжийн тайлангийн хамт тус тус хавсаргана. Орон нутаг дахь салбар нэгжийн тайланд хандив өгсөн бүх хандивлагчийн овог нэр, тус бүр өргөсөн хандивын хэмжээтэй хамт бичиж тусгана. Намын төв байгууллага энэ хандив болон хандивлагчдын жагсаалтыг нэгтгэж, авсан нийт хандивын хэмжээ, тодорхой нэг хандивлагчаас өргөсөн хандивын нийлбэр дүнг нэгтгэн гаргана.

36.16. Сонгуулийн төв байгууллага намын санхүүгийн тайлан, түүнд холбогдох баримтыг тайлант хугацаа дууссанаас хойш 10 жил хадгална.

37 дугаар зүйл. Намын санхүүгийн тайлан гаргах

37.1. Нам санхүүгийн тайлангаа нэгдсэн байдлаар үнэн зөвөөр гаргана. Намын салбар нэгжийн гүйцэтгэх байгууллага өөрийн санхүүгийн тайланг гаргаж, намын төв байгууллагад хүргүүлнэ.

37.2. Намын санхүүгийн хагас жилийн тайланг 07 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг 02 дугаар сарын 10-ны дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эдгээр хугацаанд тайланг хүргүүлээгүй бол тайлан хүлээн авах хугацааг сонгуулийн төв байгууллага 30 хүртэл хоногоор сунгаж болно.

37.3. Нам санхүүгийн тайланг гаргахдаа Шилэн дансны тухай хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримталж, энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан зүйлийг тусгана.

37.4. Намын санхүүгийн тайланд дараах агуулга бүхий намын үйл ажиллагааны товч тайланг хавсаргана:

37.4.1. намын гишүүний тоо. Намын гишүүний тоог тайлант жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар заана;

37.4.2. намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагыг хуралдуулсан эсэх мэдээлэл;

37.4.3. энэ хуулийн 26.3-т заасан үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

37.4.4. энэ хуулийн 35.2-т заасан үйл ажиллагааны талаарх мэдээлэл.

37.5. Намын дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно. Түүнчлэн намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь төрийн алба, төрийн болон орон нутгийн өмчийт хуулийн этгээдэд даврах алба хашахыг хориглоно.

37.6. Нам нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн анхан шатны баримт хөтлөөгүй, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримтыг Архивын тухай хуулийн дагуу хадгалаагүй тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

37.7. Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг намын төлөөллийн төв байгууллагаас эсхүл төлөөллийн төв байгууллагагүй бол удирдах дээд байгууллагаас 4 жилийн хугацаатай томилно. Түүнийг нэг удаа улируулан томилж болно.

37.8.Тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэхээс өмнө намын гүйцэтгэх төв байгууллага хэлэлцэнэ.

37.9.Тайланг баталгаажуулж намын дарга болон санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан гарын үсэг зурна.

37.10.Санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны зурсан гарын үсэг нь тайланд агуулагдаж буй мэдээлэл үнэн зөв хийгдсэний баталгаа болно.

37.11.Намын дарга энэ хуулийн 37.9 дэх хэсэгт зааснаас бусдаар намын санхүү, төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэйгээр оролцохыг хориглоно.

38 дугаар зүйл. Тайланг аудитын байгууллагаар баталгаажуулах

38.1.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитор эсхүл аудитын байгууллага /цаашид "аудитор" гэх/-аар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулан тайлангийн хамт энэ хуулийн 37.2-т заасан хугацааны дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

38.2.Аудитор холбогдох баримт материалтай танилцах боломжийг нам бүрдүүлэх үүрэгтэй.

38.3.Аудитор намын санхүүгийн тайланг хянаад зөрчилтэй гэж үзвэл тайланг баталгаажуулахаас татгалзах эрхтэй бөгөөд энэ талаар сонгуулийн төв байгууллагад ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

38.4.Энэ хуулийн 38.1-д заасан аудиторын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс гаргана.

38.5.Дараах тохиолдолд намын санхүүгийн тайланд аудит хийхийг хориглоно:

38.5.1.тухайн намд болон тухайн намын улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн ажил, албан тушаал хашиж буй эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд хашиж байсан;

38.5.2.намын нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд эсхүл намын тайланг гаргахад оролцсон;

38.5.3.ашиг сонирхлын зөрчил үүссэн бусад нөхцөл.

38.6.Аудитор, түүний туслах, аудитын байгууллагын хууль ёсны төлөөлөгч нь ажил үүргээ шударга, үнэнчээр, төвийг сахиж биелүүлэх бөгөөд нууцыг хадгалж Аудитын тухай хуульд захирагдана.

38.7.Энэ хуулийн 38.1-д дурдсан аудитын шалгалтыг намын төв байгууллага болон аудиторын үзэмжээр сонгосон орон нутгийн салбар нэгжийн таван хувиас доошгүйг оролцуулан явуулна.

38.8.Аудитын шалгалтад нягтлан бодох бүртгэлийг хамруулна. Аудитын шалгалт хууль тогтоомжийг баримтлан сахисан эсэхийг тогтооход чиглэгдэнэ. Аудитын шалгалтыг хариуцлагатай мэргэжлийн өндөр түвшинд явуулж, алдаа болон хуулийн заалтуудын зөрчлийг олж тогтооно.

38.9.Аудитор хянан шалгах үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай тодруулга, баримт бичгийг намын гүйцэтгэх төв байгууллага болон түүний ажилтнаас шаардах эрхтэй. Үүнтэй холбоотойгоор аудитор тайланг гаргахад хэрэглэсэн баримт бичиг, нягтлан бодох бүртгэл, эд хөрөнгийг шалгах эрхтэй.

38.10.Шалгуулж буй намын орон нутгийн салбар нэгжийн гүйцэтгэх байгууллагаас тайланд тусгагдах ёстой бүх орлого, зарлага, эд хөрөнгийг бүртгэсэн тухай баталгааг аудиторт бичгээр гаргаж өгнө. Баталгааг орон нутгийн доод шатны намын гүйцэтгэх байгууллагаас гаргуулж болох ба санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан бичгээр баталгаа гаргахад хангалттай.

38.11.Аудитын шалгалтын үр дүнг бичгээр тайлагнаж, намын гүйцэтгэх төв байгууллага болон шалгуулсан орон нутгийн салбар нэгжийн гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгнө.

38.12.Намын тайланг шалгаж дууссаны дараа алдаа, зөрчил илрээгүй тохиолдолд аудитор өөрийн үүргээ хариуцлагатай биелүүлж, намын нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн намын тайлан нь энэ хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар нягтлан шалгасны дагуу энэ хуулийн шаардлагыг хангасныг баталгаажуулж тэмдэглэл үйлдэнэ.

38.13.Тайланд алдаа, зөрчил илрүүлсэн тохиолдолд аудитор дээрх шалгалтын тэмдэглэлд тайланг баталгаажуулахаас татгалзах эсхүл хэсэгчлэн баталгаажуулна. Шалгуулсан намын орон нутгийн байгууллагыг тэмдэглэлд заана.

38.14.Шалгалтын тэмдэглэлийг намын тайланд хавсаргах бөгөөд энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу бүрэн хэмжээгээр нийтэлнэ.

39 дүгээр зүйл.Намын санхүүгийн тайланг нягтлан шалгах

39.1.Сонгуулийн төв байгууллага намын тайланг хүлээн авч хэлбэр болон агуулгын хувьд зөв, бодитой эсэх, энэ хуулийн Тавдугаар бүлэгт заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгах бөгөөд энэ хуулийн 38.1-д заасан аудитын тайланг харгалзан үзнэ.

39.2.Хэрэв намын тайланд байгаа мэдээлэл үнэн, бодит эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл байвал сонгуулийн төв байгууллага тухайн намд ажлын 15-аас доошгүй хоногийн хугацаа заан мэдэгдэж, тайлбар хийх, залруулах боломж олгоно.

39.3.Энэ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллага хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

39.4.Нягтлан шалгах ажиллагаа дуусгавар болсны дараа сонгуулийн төв байгууллага дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтэд дараах зүйлийг тогтооно:

39.4.1.тайланд алдаа, зөрчил байсан эсэх;

39.4.2.тайланг зөрчил алдаатай гаргасан бол үүний улмаас намд олгосон санхүүжилт зөрүүтэй эсэх;

39.4.3.орлого, зарлагын тайлангийн баланс хууль тогтоомж зөрчсөн эсэх;

39.4.4.эд хөрөнгийн балансыг буруу гаргасан эсэх.

39.5.Энэ хуулийн 39.4-т заасан алдаа, зөрчилтэй тайлан ирүүлсэн нам тухайн алдаа, зөрчлийг арилгаж сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу тайлангаа бүрэн эсхүл хэсэгчлэн шинэчлэн ирүүлнэ. Шинэчилсэн тайлангийн үнэн зөвийг аудит хийлгэж баталгаажуулна.

39.6.Энэ хуулийн 39.4-т заасны дагуу тогтоогдсон алдаа, зөрчил хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрээгүй байвал энэ хуулийн 39.5-д заасны дагуу тайланг шинэчлэхгүйгээр дараа жилийн тайланд залруулан тусгаж болно.

39.7.Тайланг нягтлан шалгах ажиллагааны явцад олж авсан боловч намын тайланд шууд хамаарахгүй мэдээллийг нийтэлж болохгүй бөгөөд төрийн бусад байгууллагад дамжуулахгүй. Хяналт шалгалт дууссаны дараа эдгээр мэдээллийг сонгуулийн төв байгууллага даруй устгах үүрэгтэй.

40 дүгээр зүйл.Тайлангийн алдаа, зөрчлийг мэдүүлэх үүрэг

40.1.Нам сонгуулийн төв байгууллагад санхүүгийн тайланг албан ёсоор хугацаандаа хүргүүлсний дараа өөрийн тайланд алдаа, зөрчил байгааг мэдвэл сонгуулийн төв байгууллагад энэ тухай бичгээр даруй мэдүүлэх үүрэгтэй.

40.2.Алдаа, зөрчлийн тухай сонгуулийн төв байгууллагад мэдүүлсэн цаг мөчид тайланд алдаа, зөрчил агуулагдсан тухай олон нийт болон сонгуулийн төв байгууллага ямар нэгэн мэдээлэлгүй байсан, эсхүл нягтлан шалгах ажиллагааны явцад алдаа, зөрчлийг илрүүлээгүй бөгөөд нам алдаа, зөрчлийг бүрэн хэмжээгээр ил тод болгож залруулсан бол энэ хуулийн 41 эсхүл 42 дугаар зүйлд заасан эрх зүйн үр

дагавар үүсэхгүй. Хууль бусаар олж авсан орлогыг сонгуулийн төв байгууллагад түүний тогтоосон хугацаанд нам шилжүүлэн өгнө.

41 дүгээр зүйл. Төрөөс олгосон санхүүжилтийг буцааж төлөх

41.1. Энэ хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу тайланг нягтлан шалгаж алдаа, зөрчил илрүүлбэл 42 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд алдаа, зөрчлийн улмаас буруу тооцсон мөнгийг 2 дахин өсгөсөн дүнгээр тухайн нам сонгуулийн төв байгууллагад төлнө. Алдаа, зөрчил өмч хөрөнгийн балансад, эсхүл тайлангийн тайлбар хэсэгт байр, газрын өмчтэй холбоотой, эсхүл аж ахуйн нэгжид эзэмшдэг хувьтай холбоотой гарсан бол тайлагнаагүй орхигдуулсан буюу алдаатай үнэлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх мөнгийг тухайн нам сонгуулийн төв байгууллагад төлнө.

41.2. Энэ хуулийн 36.17-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд энэ хуулийн 41.1-д заасан төлбөр шаардахгүй.

41.3. Сонгуулийн төв байгууллага захиргааны акт гаргаж, намаас төрд буцааж төлөх мөнгөний хэмжээг тогтооно. Энэ хугацаанд төрөөс дараагийн санхүүжилт авах эрх намд үүссэн бол сонгуулийн төв байгууллага намаас буцааж төлөх мөнгийг дараагийн санхүүжилтээс суутгаж тооцно.

41.4. Энэ зүйлд заасан намын зөрчил нь бусад нам санхүүжилтийн хэмжээг тогтоох болон олгоход нөлөөлөхгүй.

41.5. Энэ хуулийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд хэрхэх асуудлыг нам дүрмээр зохицуулна.

42 дугаар зүйл. Хууль бусаар олж авсан эсхүл ил болгоогүй хандив

42.1. Нам энэ хуулийн 34.6, 34.7-д хориглосон хандивыг авч, 34.5.3, 34.5.4-ын дагуу сонгуулийн төв байгууллагад шилжүүлэн өгөөгүй бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрээр тухайн нам энэ хууль бусаар авсан хандивыг 3 дахин өсгөсөн дүнгээр улсад төлнө. Сонгуулийн төв байгууллага өмнө нь шилжүүлсэн хандивыг төлөх торгуулийн хэмжээнээс суутгаж тооцно.

42.2. Энэ хуулийн 36.17-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд энэ хуулийн 42.1-д заасан төлбөр шаардахгүй.

42.3. Сонгуулийн төв байгууллага намаас төрд буцааж төлөх мөнгөний хэмжээг тогтооно. Энэ хугацаанд төрөөс дараагийн санхүүжилт авах эрх намд үүссэн бол сонгуулийн төв байгууллага намаас буцааж төлөх мөнгийг дараагийн санхүүжилтээс суутгаж тооцно.

42.4. Бусад нам санхүүжилтийн хэмжээг тогтоох болон олгоход тухайн намын дээрх асуудал нөлөөлөхгүй.

42.5.Энэ хуулийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрэмдээ тусгана.

43 дугаар зүйл.Тайланг нийтэд мэдээлэх

43.1.Сонгуулийн төв байгууллага жил бүрийн дөрөвдүгээр сард багтаан намуудын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг нэгтгэж, Улсын Их Хуралд мэдээлэх бөгөөд өөрийн цахим хуудаст байршуулж, зохих тоогоор хэвлэн нийтэлнэ.

43.2.Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 4 дүгээр сард багтаан намуудын орлого, зарлага, хөрөнгийн байдлын талаар харьцуулсан товч мэдээлэл бэлтгэж, өөрийн цахим хуудаст байршуулж, зохих тоогоор хэвлэн нийтэлнэ.

43.3.Энэ хуулийн 39.5-т заасны дагуу алдаа, зөрчлийг арилган шинэчилсэн тайланг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нийтэлж, сонгуулийн төв байгууллагын цахим хуудаст байршуулна.

43.4.Нам санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор өөрийн цахим хуудаст байршуулж, цахим хуудасгүй намын хувьд өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлж, олон нийтэд танилцуулах үүрэгтэй.

43.5.Энэ хуулийн 43.4-т заасны дагуу цахим хуудаст байршуулсан тайланг арван жилийн хугацаанд устгахыг хориглоно.

43.6.Намын тайланг энэ хуулийн 38.1, 43.4-т заасны дагуу нийтэд мэдээлсний дараа санхүүгийн тайланд зөрчил илэрсэн бол залруулгыг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх, өөрийн цахим хуудаст байршуулах, хэвлэн нийтлэх 14 хоногийн хугацааг сонгуулийн төв байгууллагаас тухайн намд өгнө.

43.7.Намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлан, харьцуулсан товч мэдээллийг энэ хуулийн 43.1, 43.2, 43.4-т заасны дагуу цахим хуудаст бүхэлд нь татаж авах, хайлт хийх боломжтойгоор байршуулна.

43.8.Намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлан, харьцуулсан товч мэдээллийг нийтлэхдээ хандивлагч иргэний овог, нэр, оршин суугаа аймаг, сум, багийн эсхүл нийслэл, дүүрэг, хорооны нэр, дугаарыг нийтэлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БУСАД

44 дүгээр зүйл.Улсын Их Хуралд суудал бүхий нам, түүний эрх

44.1.Улсын Их Хурлын сонгуульд тухайн нам, эвслээс нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн бүхий нам, эвслийг Улсын Их Хурал суудал бүхий нам гэж ойлгоно.

44.2.Намыг дараах тохиолдолд Улсын Их Хуралд суудал бүхий намд тооцохгүй:

44.2.1.Улсын Их Хуралд төлөөлөлгүй болсон;

44.2.2.нам татан буугдсан болон тарсан.

44.3.Улсын Их Хуралд суудал бүхий нам дараах эрхтэй:

44.3.1.Монгол Улсын Ерөнхийлөгчид нам дангаараа буюу хамтран нэр дэвшүүлэх;

44.3.2.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бодлогын талаарх асуудлыг Улсын Их Хурал дах намын бүлгээрээ, хэрэв намын бүлэггүй бол Улсын Их Хурлын гишүүнээрээ дамжуулан Улсын Их Хуралд оруулах;

44.3.3.Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх санал тавих;

44.3.4.Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан Улсын Их Хурлын чуулганы нээлтийн ажиллагаанд улс орны бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх.

45 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

45.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

45.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

46 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

46.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намыг энэ хуульд нийцүүлэн дахин бүртгэхгүй.

2 дугаар зүйл. Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуультай нийцүүлэх арга хэмжээг уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор авах бөгөөд энэхүү өөрчлөлтөө Улсын дээд шүүх, Сонгуулийн төв байгууллагад 30 хоногийн дотор хүргүүлнэ.

3 дугаар зүйл. Намд үзүүлэх төрийн санхүүжилтийг Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус сонгуулийн үр дүнгээр бүрдэх Улсын Их Хурлын шинэ бүрэн эрх эхэлсэн цагаас эхлэн олгоно.

4 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө байгуулагдсан намын харьяа байгууллага хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор Улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ. Намын харьяа байгууллагыг шинэчлэн бүртгэхэд улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 112.1.6 дахь заалт нэмсүгэй:

"112.1.6. Сонгуулийн тухай хуулийн 21.6-д заасан маргаан;"

2 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.6 дахь заалтын дугаарыг "112.1.7" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oO---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2005 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн доор дурдсан хэсгийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай:

15.2. "Улс төрийн нам,";

"15.2.1. улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 60 000-150 000 төгрөг;"

"15.2.2. улс төрийн намын нэр сольсныг бүртгэхэд 20 000-50 000 төгрөг;"

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

16 дугаар зүйл. Улс төрийн намыг бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

16.1. Намыг бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

16.1.1. Гэрчилгээ олгоход 300 000 төгрөг;

16.1.2. намын нэр сольсныг бүртгэхэд 150 000 төгрөг;

3 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/17.2 дугаар зүйл:

17.2 дугаар зүйл.Улс төрийн намын тухай хуулийг зөрчих

17.2.1.Нам нь Улс төрийн намы тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчсөн бол арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.2.Монгол Улсын иргэд нам үүсгэн байгуулахад дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцсон бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.3.Намын хяналтын байгууллагад хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.4.Нам хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан тохиолдолд түүний өмч, хөрөнгийг тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэсэн бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.5.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 26.1-д заасан орлогыг нэг банк дахь нэг дансаар хүлээн аваагүй бол арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.6.Нам нь иргэний болон хуулийн этгээдийн хандивыг бэлэн мөнгөөр хүлээн авсан бол арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.7. Нам нь нэг жилд нэг иргэн, хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээг хуульд зааснаас хэтрүүлэн авсан бол арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.8. Намаас бусад хуулийн этгээд нам гэсэн оноосон нэр хэрэглэсэн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:

“3.1.6.төрийн санхүүжилт авч буй нам, эвсэл;

2 дугаар зүйл. Шилэн дансны тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/ 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг:

“6.11.Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу төрийн санхүүжилт авч буй нам, эвсэл энэ хуулийн 3.1.6-д заасны дагуу төрийн санхүүжилтийн төсөвт өртөг, зарлага, санхүүжилтийн мэдээлэл, тайланг хуульд өөрөөр заагаагүй бол жил бүр сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу гаргаж намын цахим хуудас, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байрлуулна.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

"25.8.8. Улс төрийн намын тухай хуулийн 13.4, 15.4, 25.3-т заасан асуудал;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг:

“4.1. Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн тав нь орон тооны, дөрөв нь орон тооны бус байна.”

2/4 дүгээр зүйлийн 4.2 дах хэсэг:

“4.2. Хорооны гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулж, Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийх замаар зургаан жилийн хугацаагаар томилно. Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгоно.”

2 дугаар зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд доор дурдсан зүйл, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.11 дэх хэсэг:

“3.11. Хорооны дүрмийг Улсын Их Хурал батална.”

2/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:

“7.6. Хороо улс төрийн намын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.6.1. намыг бүртгүүлэх өргөдлийн маягтыг батлах;

7.6.2.намыг бүртгүүлэх өргөдөл, холбогдох баримт бичгийг нягтлан шалгах, нэмэлт мэдээлэл гаргуулахаар шаардах;

7.6.3.намын бүртгэлийн жагсаалт, бүртгэлийн хувийг хэрэг хөтлөх;

7.6.4.намын оршин байх албан ёсны хаяг, хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэх;

7.6.5.намд өгөх хандивын бүртгэлийг хөтлөх маягтыг батлах;

7.6.6.хуульд заасан үндэслэл журмын дагуу намыг тараах тухай дүгнэлт гаргах;

7.6.7.намын бүртгэлд үндэслэн хуулийн этгээдийн гэрчилгээ, тамга, тэмдэг олгох;

7.6.8.намд олгох төрийн санхүүжилтийн тооцож төсөвт суулган олгох;

7.6.9.намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох;

7.6.10.намд олгох шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх;

7.6.11.намын үйл ажиллагаанд хэрэглэх цахим программ хангамжийг баталгаажуулах;

7.6.12.намын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг, холбогдох өөрчлөлтийг бүртгэх;

7.6.13.Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-т заасны дагуу хэрэгжүүлэх хяналт;

7.6.14.Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-т заасны дагуу хэрэгжүүлэх хяналт;

7.6.15.Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасны дагуу намыг идэвхгүйд тооцоох эсэх тухай шийдвэр гаргах;

7.6.16.Улс төрийн намын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.13-т заасны дагуу намд хяналт тавих;

7.6.17.Улс төрийн намын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.13-т заасны дагуу намд хяналт тавих;

7.6.18.Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13-т заасны дагуу намд хяналт тавих;

7.6.19. Улс төрийн намын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу намын санхүүгийн тайланд хяналт тавих;

7.6.20. Улс төрийн намын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т заасны дагуу намын санхүүгийн тайланд хяналт тавих.

3 дугаар зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь дугаарыг "7.7", 7 дугаар зүйлийн 7.7 дахь дугаарыг "7.8" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар ...

Улс төрийн намын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Улс төрийн намын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс хойш энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нарийвчилсан журам, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (П.Дэлгэрнаран)-д нарт тус тус даалгасугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

---oOo---



👁 25

📅 2022/05/02 3:12:11

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон үзэл баримтлал, танилцуулга, дагалдах хууль тогтоомжийн төсөлтэй танилцан, санал зөвлөмжөө office@president.mn хаягаар ирүүлнэ үү.

1. Үзэл баримтлал
2. Танилцуулга
3. Хуулийн төсөл
4. Дагалдах хуулийн төсөл



ХУУЧИРСАН МЭДЭЭ: 2022/03/05-нд НИЙТЛЭГДСЭН

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудын төлөөлөл оролцсон “Улс төрийн намын эрх зүйн шинэтгэл” хэлэлцүүлэг болов

А.ТӨГӨЛДӨР, IKON.MN

2022 ОНЫ 3 САРЫН 5

Like 3

Share

Tweet



Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран өчигдөр (2022.03.04) “Улс төрийн намын эрх зүйн шинэтгэл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Б.Пүрэвдорж, Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх С.Лүндэг, Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Шинжлэх ухааны академи, МУИС, Боловсролын их сургуулийн багш, эрдэмтэн судлаачид оролцлоо.

Мөн Улсын дээд шүүхэд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа намууд болох ИЗНН, Ногоон нам, Монголын хүний төлөө нам, Ард түмний олонхийн засаглал нам, Эх орончдын нэгдсэн нам, Хөгжлийн хөтөлбөрийн нам, Монголын үндэсний ардчилсан нам, Хамуг Монголын



хэрэгжүүлэгч нам, Иргэний хөдөлгөөний нам, Ард түмнээ хайрлая нам, Үнэн ба зөв нам, Зон олны нам, Шударга иргэдийн нэгдсэн эвсэл, Зүй ёс нам, Ардчилал шинэчлэлийн нам, Монголын уламжлалын нэгдсэн нам, Эх орон нам, Монголын либерал нам, Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нам, Монгол консерватив нам зэрэг намуудын төлөөлөл оролцсон.



Хэлэлцүүлгийн чиглүүлэгч, Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат улс төрийн намууд, түүний төлөөллийг цуглуулж санаа, бодлыг сонсож, нээлттэй ярилцахаар энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулж буйг тэмдэглэхийн зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн нэгдэл болох улс төрийн намын эрх зүйн шинэтгэлд анхаарал хандуулж, парламентад суудалтай намууд болон бусад намууд, эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулсан талаар мэдээлэв.

Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар ахалсан байна. Хэлэлцүүлгийг нээж Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч Я.Содбаатар нар үг хэллээ.



Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хэлсэн үгэндээ “Монгол Улсын Их Хурал 2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг амилуулж, хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолыг батлан гаргасан. Тус тогтоолын дагуу 31 хууль батлах ёстойгоос өнөөдрийн байдлаар 14 хуулийг шинэчлэн баталсан, хоёр хууль хэлэлцүүлгийн шатанд байна. 31 хууль бүгд батлагдаж байж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бүрэн утгаараа амьдралд хэрэгжинэ. Үлдэж буй 15 хуульд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улс төрийн намын санхүүжилтийн тухай анхдагч хуулийн төсөл багтаж байна.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч өргөн барина 🐦 .

Хуулийн төслийг намуудын оролцоог хангаж боловсруулах ёстой учраас олон намын төлөөллийг оролцуулан, олон нийтээр хэлэлцүүлээд, хийдэлгүй хууль хэлэлцэж батлахыг зорьж байна. Улс төрийн намын эрх зүйн шинэтгэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг. Бидний зорьж, тэмүүлж байгаа эдийн засгийн хөгжил, эрүүл нийгэм, хуулийн засаглал, шударга ёсыг тогтоох чин эрмэлзлэлийг үр дүнд хүргэх нэг чухал хөшүүрэг улс төрийн намын шинэтгэл. Ийм цаг үед энэ хэлэлцүүлэг болж буй нь их ач холбогдолтой. Улс төрийн намын санхүүжилтийн тухай анхдагч хуулийн төсөл боловсруулалтын шатандаа байна” гэлээ.





Улс төрийн намд яагаад шинэтгэл хэрэгтэй талаар Улсын Их Хурлын дарга мөн хэлсэн үгэндээ гурван асуудлыг тодруулан тэмдэглэсэн. Тухайлбал, улс төрийн нам авлигыг тэтгэгч, хэсэг бүлгийн албан тушаал өгсөх шат, эрх мэдлийг төвлөрүүлж, дураар дургих бүтэц, засгийн эрхийн төлөө сөргөлдөн тэмцэгч болсон тул уруудан доройтсоны гол эх сурвалж намуудад байна гэсэн дүгнэлтийг олон нийт хийдэг болсон, энэ сөрөг хандлага, үнэлэмжийн нөлөөгөөр улс төрийн нам, түүний үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэл алдарсан, улс төрийн намын эрх зүйн шинэчлэл цаг үеийн шаардлагаас илт хоцорсон учир засаглалын хямралт байдал руу түлхсэн зэрэг шалтгаан нь улс төрийн намын тухай, түүний санхүүжилтийн тухай хуулийг ард нийт, улс төрийн намуудын зөвшилцлийн үндсэн дээр хэлэлцэн, батлах зүй ёсны шаардлагыг бий болгож байна гээд хэлэлцүүлэгт оролцож буй намуудын төлөөлөлд амжилт хүсэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч Я.Содбаатар хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ, “Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажил гурван парламент дамжсан нь нийгмийн олон талын зөвшилцлийг хангах ёстойг харуулж байна. Төрийн тэргүүн улс төрийн намын шинэтгэлийг цогцоор нь харж, улсыг хөгжлийн урт хугацааны бодлогод тулгуурлан хийх ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Улс төрийн намын шинэтгэлийг хийх үндсэн зорилго парламентын ардчилал, Үндсэн хуульт ёсны төлөвшилтийг гүнзгийрүүлэх чиглэлд явах ёстой. Энэ хүрээнд нам дэвшилтэт бодлого хэрэгжүүлэх, институцын хувьд чадавхжиж, цаашид бодлогын институц байх нөхцөлийг бүрдүүлэн, намын санхүүжилт ил тод байж, түүнд тавих хяналтын механизм улам бүр боловсронгуй болж, мөн зохион байгуулалтын хувьд ардчилсан зарчимд нийцсэн байх, асуудлаа гудамжинд бус ширээний ард сууж, эв эеэ хичээн ярилцаж чаддаг байх эрх зүйн



Нээлтийн дараа гурван илтгэл танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Улс төрийн намын эрх зүйн шинэтгэл” сэдвээр, Боловсролын их сургуулийн багш, судлаач, доктор Э.Гэрэлт-Од “Монгол дахь улс төрийн намын төлөвшлийн асуудлууд” сэдвээр, Нээлттэй нийгэм форумын судлаач, Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг “Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин, шинэчлэл” сэдвээр тус бүр 20 минутын илтгэл тавилаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Улс төрийн намын эрх зүйн шинэтгэл” сэдэвт илтгэлээрээ дэлхийн улс төрийн намуудын хөгжлийн чиг хандлага, тэр дундаа намын санхүүжилт, бодлогын нам болохтой холбоотой асуудлыг, мөн Монгол дахь улс төрийн намууд, тэдгээрийн эрх зүйн шинэтгэлийн үндэслэл, шаардлагын талаар танилцуулаад улс төрийн намын эрх зүйн шинэтгэлийг Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, олон улсын жишиг, парламентын засаглалтай улс орнуудын сайн туршлагыг харгалзан хийх нь зүйтэй гэж дүгнэсэн. Мөн дэлхийн улс орнуудын намын хөгжлийн чиг хандлагыг судалж, Монголын нөхцөлд таарах сайн туршлага, ололтыг нэвтрүүлэх ёстой талаар хөндлөө.

Боловсролын их сургуулийн багш, судлаач, доктор Э.Гэрэлт-Од “Монгол дахь улс төрийн намын төлөвшлийн асуудлууд” сэдэвт илтгэлээрээ өнгөрсөн 32 жилд улс төрийн намын төлөвшилтөд тулгарч байсан асуудлуудыг тодруулж, олон намын тогтолцооны шилжилт, улс төрийн намын эрх зүй, бүтэц, зохион байгуулалт, гишүүнчлэл, дотоод ардчилал, санхүүжилт, бүртгэлийн тогтолцоо, хяналт хариуцлага, олон нийтийн дэмжлэг, сонгуулийн системийн өөрчлөлт гэсэн агуулгын хүрээнд мэдээлэл өгсөн.

Түүний илтгэлд Улсын дээд шүүхэд 35 улс төрийн нам бүртгэлтэй байдаг талаарх тоо баримт дурдагдлаа. Тэрбээр өнгөрсөн 32 жилийн хугацааны намын тухай хуулийн эрх зүйн орчин нь улс төрийн намын төлөвшилтийг дэмжихгүй байна гэдэг дүгнэлтийг хэлж, цаашид бүртгэлийн тогтолцоог өөрчлөх, бүтэц, зохион байгуулалтыг уян хатан болгох, намын чиг үүргийг тодорхойлох, санхүүжилтийг ил тод болгох, төрийн санхүүжилтийг өрсөлдөөнийг дэмжсэн аргаар шударга хуваарилах, дотоод ардчиллыг дэмжих, хариуцлагын механизмыг сайжруулах, олон нийтийн хяналтад оруулах шаардлага байгааг тэмдэглэсэн.



Нээлттэй нийгэм форумын судлаач, Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг “Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин, шинэчлэл” сэдэвт илтгэлээрээ Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтөд улс төрийн намын төлөвшил, намын системийн хөгжлийг чиглүүлэхэд чухал нөлөө үзүүлэх хэд хэдэн заалт багтсан. Тэдгээрээс намын санхүүжилттэй холбоотой намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэж тусгасан заалтыг онцлов.

Дээрх агуулгаа тодотгон улс төрийн санхүүжилт нь ардчиллыг санхүүжүүлэх үйл явц байх ёстой талаар мэдээллийг хуваалцлаа. Түүний илтгэлд санхүүжилтийн эх үүсвэрүүд, нэг сонгогчид ногдох сонгуулийн компанит ажлын зардлын хэмжээ, Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн зардал зэрэг тоон мэдээллүүд дурдагдав.

Тэрбээр дүгнэлт болгож нам ардчилсан тогтолцоонд гүйцэтгэх ёстой үүргээ хариуцлагатай гүйцэтгэхэд чиглүүлэх буюу нөхцөлт санхүүжилтийн хөшүүрэг бий болгох, сонгуульд тэгш өрсөлдөх нөхцөлийг сайжруулахын тулд сонгуулийн зардлыг аль болох бууруулах арга хэмжээ авах, эрх баригч хүчний зүгээс төрийн нөөц хөрөнгийг улс төрийн зорилгоор ашиглах байдлыг хянах, сонгуулийн санхүүжилтэд нэр дэвшигчдийн хувийн болон хуулийн этгээдийн хандив аль болох бага, харин сонгогч дэмжигчдийн хандив болон төрийн санхүүжилт аль болох түлхүү хувь эзлэхээр зохицуулах зэрэг цогц арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн.





Илтгэлүүдийн дараа хэлэлцүүлэгт оролцсон улс төрийн намуудыг төлөөлж тус бүр нэг хүн үг хэлж, асуулт, хариулт, санал өрнөлөө. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналаа улс төрийн намууд ажлын хэсэгт бичгээр гаргаж өгөх боломжтой юм гэж **УИХ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээлэв.**

Like 3

Share



ЖИРГЭХ



ХУВААЛЦАХ

ЭНЭ МЭДЭЭНД ӨГӨХ ТАНЫ ХАРИУЛАЛ?

1



2 СЭТГЭГДЭЛТЭЙ

Нэр...





0/1000

iKon сайтад сэтгэгдэл оруулахад анхаарах зүйлс

НИЙТЛЭХ

ЭХНИЙ

СҮҮЛИЙН

ШИЛДЭГ

Зочин [188.32.188.182] 2022/3/6

Ганц хүний энэ олон намын хязгаарлахаар юм.

^ 0 | v 0 Хариулах

Иргэн [64.119.25.61] 2022/3/5

энэ намуудыг одоо устгаачээ

^ 0 | v 0 Хариулах

[Бидний тухай](#) | [Үйлчилгээний нөхцөл](#) | [Редакцын бодлого](#) | [Сурталчилгаа байрлуулах](#) | [Холбоо барих](#) | [RSS](#)

© 2023 Бенекрафт ХХК





👁 1144 🔗

📅 2022/06/07 6:09:10

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан хэлэлцүүлэг зохион байгуулав



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх мөрийн хөтөлбөртөө улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэн, санхүүжилтийг нь шилэн болгохтой холбоотой хуулийн төсөл санаачлахаар тусгасан.

Энэ дагуу Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулан хэлэлцүүлэг хийж, намууд, иргэний нийгэм, эрдэмтэн судлаач, иргэдээс саналыг нь авч байна.

Энэ удаагийн “Улс төрийн намын тухай хууль: Өөрчлөлт-шинэчлэлт” хэлэлцүүлгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг хамтран зохион байгууллаа.



Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийн ахлагч Я.Содбаатар төслийн талаар товч танилцуулав.

“ Тэрбээр “Хууль санаачлагч хуулийн төсөлдөө бүх талын байр суурийг сонсож, саналыг нь авах үүрэгтэй. Хуулийг шинэчлэн боловсруулах асуудал гурван парламент дамжсан. Төрийн тэргүүн улс төрийн намын шинэтгэлийг цогцоор нь харж, хөгжлийн урт хугацааны бодлогод тулгуурлан хийх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Улс төрийн намын шинэтгэлийг хийх үндсэн зорилго нь парламентын ардчилал, Үндсэн хуульт ёсны төлөвшлийг гүнзгийрүүлэх юм” гэлээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат “Нийгэмд хамгийн нэр хүндгүй, авлигад идэгдсэн байгууллага нь улс төрийн намууд гэсэн судалгаа гардаг. Намуудын бодлого тодорхой байж, сонгуулиар дамжин парламентад бодлогоо хэрэгжүүлдэг байх ёстой. Үүнд шинэчилсэн найруулгын төсөл чухал үүрэгтэй” гэв.

Ажлын хэсэг хэлэлцүүлэг хийхээс гадна санал авахаар улс төрийн 35 намд хуулийн төслөө явуулснаас долоо нь бичгээр саналаа ирүүлээд байна.

УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ИРҮҮЛСЭН САНАЛ

I. Монгол Улсын Их Хурал дахь МАН бүлэг.....	1
II. Монгол Улсын Их Хурал дахь АН бүлэг.....	3
III. ХҮН нам	4
IV. Эх орончдын нэгдсэн нам.....	9
V. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам	11
VI. Иргэний зориг ногоон нам	12
VII. Монгол Үндэсний Ардчилсан нам	14
VIII. Үнэн ба зөв нам	15
IX. Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	17
X. Монгол хүний төлөө нам.....	17

I. Монгол Улсын Их Хурал дахь МАН бүлэг

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь хэсэгт “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг;

Санал: Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь хэсгийг “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хэсэгт заасныг ойлгоно.” гэж томъёолох.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Намын гишүүн хэзээ ч намаас гарах эрхтэй. Намын гишүүнээс гарах тухай өргөдлийг гаргаснаар намаас гарсанд тооцно.

Санал: Намын гишүүнээс гарах тухай өргөдлийг хэнд хандаж гаргах, өргөдлийн дагуу намын гишүүний бүртгэл, мэдээллийн санд хэрхэн тэмдэглэл үйлдэх талаарх зохицуулалтыг дэлгэрүүлж тусгах.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дахь хэсэгт “иргэдийн мэдээлэл авах, соён гэгээрүүлэх хүрээнд хуульд заасан үндэслэл журмын дагуу сум, дүүргийн соёлын төв, театр, иргэний танхимыг үнэ төлбөргүй ашиглах”

Санал: Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүй, урьдчилан төсөөлж, таамаглаагүй сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй байна. Мөн

сонгуулийн сурталчилгааны хугацаанд сум, дүүргийн соёлын төв, театр, иргэний танхимыг ашиглах зохицуулалт шат шатны сонгуулийн тухай хуулиудаар тодорхой зохицуулагдсан байх тул төслөөс хасах.

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь хэсэгт “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бодлогын талаарх асуудлыг Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ, хэрэв намын бүлэггүй бол Улсын Их Хурлын гишүүнээрээ дамжуулан Улсын Их Хуралд оруулах;” 7.2.4 дэх хэсэгт “Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан Улсын Их Хурлын чуулганы нээлтийн ажиллагаанд улс орны бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх;”

Санал: Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно. ”, Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж тус тус заасан байдаг. Өөрөөр хэлбэл хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах эрх, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын үйл ажиллагаанд улс төрийн нам оролцох талаар хуульчлах нь зохимжгүй байгаа тул төслөөс хасах.

5.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Үүсгэн байгуулах хурал болох өдөр эсхүл түүнээс өмнө нам нь намын гишүүнээр элсэхээ илэрхийлсэн 801-ээс доошгүй иргэний гарын үсгийг цаасаар эсхүл цахимаар баталгаажуулна.”

Санал: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.” гэж заасан байдаг. Иймд төслийн зохицуулалтыг Үндсэн хуультай нийцүүлэх шаардлагатай байна.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Улсын Их Хуралд суудал бүхий нам дараах эрхийг эдэлнэ.” 7.2.1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгчид өөрийн гишүүн, дэмжигчээсээ нэр дэвшүүлэх;”

Санал: Монгол Улсын Үндсэн хуулийн Гүчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ. ” гэж тусгасан байдаг. Иймд Үндсэн хуулийн дээрх зохицуулалттай нийцэхгүй байх тул төслөөс хасах.

7.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт “Намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчиж намд хүнд хохирол учруулснаас бусад тохиолдолд намын гишүүнээс хасахыг хориглоно.”

Санал: “...намд хүнд хохирол учруулах...” гэснийг хэрхэн ойлгох, хүнд хохиролд юуг хамааруулан үзэх, эсхүл нам дүрэмдээ тусган хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй байна.

8.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “Нам нь тухайн намтай холбоотой хэвлэмэл материал эсхүл өөрийн хөрөнгийг худалдан борлуулах замаар орлого олж болно.” 36.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 36.1-т зааснаас өөр үйл ажиллагаанаас орлого олохыг хориглоно.”

Санал: Тус зохицуулалт нь хэт явцуу, бусад хэлбэрээр орлого олох нөхцөл, боломжийг хязгаарласан зохицуулалт болжээ. Өөрөөр хэлбэл нам өөрийн үл хөдлөх бусад хөрөнгийг түрээслэх замаар орлого олох, банкн дахь дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн хүүгийн орлого гэх мэт бусад хэлбэрээр олсон орлого нь хууль зөрчиж олсон орлого болохоор харагдаж байна. Иймд тус зохицуулалтыг дахин томъёолох.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх хэсэгт “аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх.”, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Иргэд нам үүсгэн байгуулах зорилго, үзэл баримтлалаа олон нийтэд тайлбарлан таниулах, энэ хуулийн 12.3-т заасан тооны иргэдийг бүрдүүлэх, нам үүсгэн байгуулах хурал зохион байгуулах зорилгоор бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсэг /цаашид “ажлын хэсэг” гэх/-ийг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж сонгуулийн төв байгууллагад мэдэгдэнэ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх бөгөөд залуучуудын төлөөллийг оруулна.”, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэгт “Намын төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.”

Санал: Аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй буюу 40 : 60 харьцаатай байхаар хуулийн төсөлд тусгасныг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэгт заасантай нийцүүлэх.

II. Монгол Улсын Их Хурал дахь АН бүлэг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачилж, өргөн барих ажлын хүрээнд улс төрийн намууд болон эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан ажлын хэсэгт Ардчилсан нам бүрэлдэхүүнээ оруулан идэвхтэй ажиллаж байгаа билээ.

Таны ирүүлсэн хуулийн төслийн анхны хувилбартай танилцаж үзэхэд Ардчилсан намын төлөөллүүдээс оруулсан саналууд ихэнхдээ туссан байгаад талархалтай байна. Гэхдээ улс төрийн намын өмчлөлийн асуудлаарх Ардчилсан намын зарчмын зөрүүтэй байр суурийг тусгаагүй, төслийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтаар одоо байгаа улс төрийн намуудын төр шиг том бүтцийг хэвээр хадгалан оруулж ирсэн байгааг хүлээн зөвшөөрч боломгүй байна.

Улс төрийн намууд аймаг, сум, дүүрэг, хороо бүрт намын байртай, үл хөдлөх хөрөнгөтэй болохын төлөө уралдаж, тэрхүү хөрөнгийнхөө анхны хөрөнгө оруулалт болон урсгал зардлыг хэрхэн санхүүжүүлэх эх үүсвэргүйн улмаас төрийн эрх мэдлийг авсан хойноо эрх мэдлээ ашиглан төрөөс, эсвэл төрийн ажил үйлчилгээ эрхлэхээр санал тавьсан бизнесийнхнээс санхүүжилт гаргуулах гэдэг хандлага нь Монгол Улс дахь авлигын индексийн үзүүлэлтийг хурдтай нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болоод байгааг зоригтойгоор засах цаг болсон гэж Ардчилсан нам үзэж байгаа юм.

Иймд улс төрийн намуудыг үл хөдлөх хөрөнгөтэй байхыг энэхүү хуулиар хориглож, намууд нь сонгуульд ялсан суудлынхаа хувиар нэгдсэн нэг байранд тодорхой тооны өрөө талбайгаар хангагдан, бага төсөв, цомхон бүтцээр ажилладаг системд оруулах хөшүүргийг хуулийн төсөлд тусгаж өгөхийг хүсье.

III. ХҮН нам

Танай байгууллагаас 2022 оны 05 дугаар сарын 4-ний өдрийн ТГ/302 тоот албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хувилбартай танилцаж, гишүүд, дэмжигчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулан санал авч, нэгтгэсэнээ үүгээр уламжилж байна.

Манай намын зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгч чөлөөт ардчилсан тогтолцоо, Үндсэн хуульт байгуулал, парламентын ардчиллыг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой энэхүү хуулийн төслийг боловсруулах, Монгол Улсын Их Хуралд (цаашид “УИХ” гэх) өргөн барихад Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд ийнхүү манлайлан оролцож байгаад талархал илэрхийлье. Хуулийн төсөлд 2022 оны эхээр Ц.Мөнхцэцэг нарын УИХ-ийн гишүүдийн боловсруулаад байсан хуулийн төслийн дэвшилттэй заалтууд болон агуулга үндсэндээ хадгалагдсан нь таатай байна.

Уг хуулийн төсөлд хууль зүйн онолын болон техникийн хувьд алдаатай гэж болохоор, нэр томъёоны болон агуулгын хувьд тодорхойгүй, хэл найруулгын алдаатай зүйл, заалтууд багагүй байгааг дурдхийн зэрэгцээ эдгээр алдаа бүрийг энэхүү хариу саналд нэг бүрчлэн тусгаагүй бөгөөд зөвхөн зарчмын шинжтэй саналуудыг тоймлон хүргүүлж байна. Тус хуулийн төслийг боловсруулах дэд ажлын хэсэгт манай намын зүгээс судлаачид, хуульчдыг оролцуулан ажиллуулах сонирхолтой байгаагаа үүгээр илэрхийлж байна.

ХҮН намын зүгээс дараах зарчмын шинжтэй саналуудыг гаргаж байгаа бөгөөд Та бүхэн хуулийн төслийг сайжруулан боловсруулах үйл явцдаа харгалзан үзнэ гэдэгт найдаж байна. Үүнд:

1. Улс төрийн намыг бүртгэх, хянах, төрөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тодорхойлох, олгох, эрх зүйн, санхүүгийн, үйл ажиллагааны хяналт тавих гэх мэт олон чиг үүргийг Сонгуулийн төв байгууллагад энэ хуулиар хариуцуулахаар тусгасан байна. Энэ тохиолдолд сонгуулийн төв байгууллагын хараат бус байдлыг юуны өмнө онцгой анхаарч, эрх баригч намаас хамааралтай байдаг тогтолцоог зайлшгүй өөрчлөх шаардлагатай. Түүнчлэн энэ хуульд тусгасан чиг үүргүүдийг сонгуулийн төв байгууллагын зүгээс хангалттай биелүүлж чадах эрх зүйн орчин, хүний нөөц, санхүүгийн болон үйл ажиллагааны нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжуудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг хамтатган боловсруулах шаардлагатай.

2. Төслийн 4 дүгээр зүйлд улс төрийн намын тодорхойлолтыг өгч, чиг үүргийг заасан нь дэвшилттэй боловч нийгмийн гишүүдийн тодорхой хэсгийн эвлэлдэн нэгдсэн байгууллага болох нам нь "ард түмний улс төрийн хүсэл зоригийг илэрхийлэх" мэт, "ард түмнийг төлөөлдөг" байгууллага мэт, "иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тогтмол, чөлөөтэй илэрхийлдэг" гэх зэргээр нэг бол хэт томруулж, нэг бол хувь хүний хэмжээнд хүртэл хэт жижгэрүүлж тодорхойлсон нь алдаатай харагдаж байна.

3. Одоо мөрдөгдөж буй Улс төрийн намын тухай болон УИХ-ийн сонгуулийн тухай хууль тогтоомжуудад улс төрийн намуудын үүсгэн байгуулсан өдөрт онцгой ач холбогдол өгч, сонгуулийн саналын хуудсанд уг өдрөөр дараалуулан байршуулдаг эрх баригч, хуучин намуудын өөрсдөдөө зориулсан зүй бус зохицуулалтыг мөн хадгалж үлдэх агуулгатай зохицуулалт 12 дугаар зүйлийн 12.7, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг гэх мэт олон зүйл, хэсэгт тусгалаа олсон байна. ХҮН намын зүгээс энэ зохицуулалтыг эрс эсэргүүцэж байгаа бөгөөд үүний оронд улс төрийн намуудыг УИХ-ийн сонгуулийн саналын хуудаг бичихдээ өмнөх сонгуульд авсан саналын хувь болон жингээр нь дараалуулах саналыг гаргаж байна.

4. Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалт болон 20 дугаар зүйлд НАМЗХ, НАМЭХ гэх мэт намын харьяа төрийн бус байгууллагууд байгуулахыг зөвшөөрсөн агуулгатай заалт орсон байна. Ийм нийгмийн бүлгүүдэд чиглэсэн намын харьяа төрийн бус байгууллагууд нь Улс төрийн намын тухай болон Сонгуулийн тухай хуульд заагдсан улс төрийн санхүүжилтийн аливаа хориглосон зохицуулалтуудыг тойрч гарах, үр нөлөөгүй болгодог. Дэлхийн улсуудад ийм төрлийн байгууллагууд нь намынхаа бүтцийн нэгж байдлаар ажилладаг бөгөөд гагцхүү Бодлого судалгааны байгууллага нь намын дэргэд бус, харьяа бус, харин "ойр" байдлаар тусгай санхүүжилттэй, харьцангуй бие даасан статустайгаар ажилладаг. Гэтэл уг төслөөр намын дэргэд уг Бодлого судалгааны байгууллагыг заавал байгуулах ёстой мэт зааж, дээрээс нь тухайн намд нь төрөөс олгох санхүүжилтийн багагүй хэсгийг хуваарилахаар тусгасан байна. Аливаа шинжлэх ухааны байгууллага улс төрөөс, улс төрчдөөс аль болох хараат бус байж байж нийтэд хэрэгтэй шинжлэх ухааны

бүтээл, бүтээгдэхүүн гаргадаг. Нэгэнт ХБНГУ- ийн улс төрийн намын эрх зүйн энэ талаарх зохицуулалтыг сайн жишиг болгон авах гэж байгаа бол бодлого судалгааны байгууллагыг намын дэргэд бус ойр гэдэг байдлаар томъёолон тусгах, санхүүжилтийн асуудлыг нь тусгаар байдлаар шийдэх хэрэгтэй болно.

5. Нам хандив авч болохгүй этгээдүүд дотор төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод (35.6.4), төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, бусад удирдах албан тушаалтан (35.6.5), 35.6.9-35.6.13 хүртэлх заалтуудад тусгагдсан этгээдүүд зэрэг нь яагаад хандив өгөх, өөрийн өмчөө захиран зарцуулах эрхээ хязгаарлуулах ёстой болсон нь тодорхойгүй байна. Нөгөө талаас 35.6.9-35.6.11 дэх заалтуудад туссан "илэрхий этгээд" гэдэг нэр томъёо улс төрийн намуудад маш их хүндрэл дагуулах боломжтой. 35.7 дахь хэсэгт заагдсан тендер авсан иргэн, хуулийн этгээдийн хувьд худалдан авагч тал нь л төр болохоос тэд өөрөө бие даан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа л этгээдүүд юм. Гэтэл тэд аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоо, ашгаа гэрээний үүргээ биелүүлээд, гэрээ дуусгавар болсноос хойш 4 жилийн хугацаанд хэрхэн захиран зарцуулахыг төр ийнхүү хязгаарлах шаардлагатай эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал, 37.7.2 дахь заалтад заагдсан мэдээллүүд нь банкны гүйлгээний утга хэсэгт багтахаргүй их мэдээлэл байх бөгөөд өнгөрсөн сонгуулиудаар ХҮН намын хувьд тодорхой банкны программ хангамжийн ийм боломжгүй байдлаас болж их хэмжээний хандивыг буцаан шилжүүлэх, улсын орлого болгоход хүрч байсан муу туршлага бий. Иймэрхүү зорилгодоо нийцэхгүй, хэр хэмжээнээс хэтэрсэн, ойлгомжгүй хязгаарлалтууд нь эрх зүйт төрийн зарчимд нийцэхгүйгээс гадна улс төрийн намын трансакцийн зардлыг маш ихээр нэмэгдүүлж, хэчнээн хичээсэн ч алхам бүрийг ягштал мөрдлөг болгох боломжгүй болгохоор байна.

6. Төслийн 5 дугаар зүйлийн 5.16 дахь хэсэгт 3-аас 4 мянган Монгол Улсын иргэд хоёрдмол харьяалалтай болсон бодит байдлыг хуульчлан зохицуулахыг оролдсон мэт боловч эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх зохицуулалтыг зөрчсөн агуулгатай байна.

7. Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.9 ба 28.10 дахь хэсэг гэх мэт зохицуулалтаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт эдүгээ байгаа Үндсэн хуулийн суурь алдаануудын нэг болох намууд сонгуулийн өмнө эвсэл байгуулж сонгуульд оролцож болдог, улмаар сонгогдсоныхоо дараа уг эвсэл нь тарсан тохиолдолд сонгогчдын сонголтын үр дүн өөрчлөгддөг, ард түмний бүрэн эрх зөрчигддөг явдлыг цаашид хэвээр хадгалахаар тусгасан байна. Тус намын дарга, УИХ-ийн гишүүн Т.Доржханд энэхүү ардчиллыг үгүйсгэхэд хүргэдэг суурь алдааг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд засах саналыг саяхан иргэд, олон

нийтэд гаргаж тавьсан. Энэ нь цаашид УИХ-ийн сонгуульд хувь тэнцүүлэн сонгох сонгуулийн тогтолцоог хэсэгчлэн болон бүрэн хэрэглэсэн тохиолдолд улс төрийн намууд нэрийн жагсаалтаа нэгтгэх байдлаар илрэх бөгөөд энэ нь төлөөллийн байгууллагаа сонгон байгуулах ард түмний бүрэн эрхэд ноцтой хохирол учруулдаг зохицуулалт юм. Иймд энэхүү зохицуулалтаас аль болох зайлсхийх агуулгаар хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй.

8. Төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/01 дугаартай тогтоолын агуулгатай хэр нийцэж буй эсэхийг нягтлан шалгах шаардлагатай.

9. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт улс төрийн намын санхүүжилтийн эрхийн асуудлыг тусгах шаардлагатай.

10. Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд заагдсан хууль санаачлах эрхийг УИХ дахь намын бүлэг хэрэгжүүлэх боломжгой мэт заах эсвэл УИХ-ийн тухай болон УИХ-ийн чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тодорхой заасан зохицуулалтыг давтан хуульчлах гэх мэт ач холбогдол багатай, алдаатай зохицуулалтуудыг тусгасан байна. Үүний оронд Монгол Улсын дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн “Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” 48 дугаар тогтоолоор тодорхой болгохыг оролдсон УИХ-д суудал бүхий намын тухай ойлголтыг нэг мөр болгох, УИХ-ийн гишүүдийн гаргах шийдвэр үйл ажиллагаанаас шалтгаалан уг ойлголт, зохицуулалтыг хэрхэн хэрэглэх тухай, намын бүлгийн хэмжээнд хүрэхгүй төлөөлөлтэй сөрөг хүчний нам, улс төрчдөд чуулганы нээлтийн үйл ажиллагаанд байр сууриа илэрхийлэх боломжийг хангах гэх мэтийн бүтээлч хандлагатай зохицуулалтуудыг тусгаж өгөх нь зүйтэй.

11. Төслийн 9 дүгээр зүйлд намын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах боломжийг нээж өгсөн боловч 9.4 дэх хэсэгт нууц санал хураалт явуулах шаардлагатай тохиолдолд хэрхэх тухай зохицуулалтыг тусгаагүй байна.

12. Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалтуудад зөвхөн нам буюу хуулийн этгээд нь албан ёсны шийдвэр, байр сууриараа бус, мөн гишүүдийнхээ зан байдлаар” эдгээр заалтад заасан нөхцөлийг хангаж байвал, тэдэндээ хариуцлага тооцохгүй байвал уг намыг тараах зохицуулалтыг зайлшгүй нэмж тусгах хэрэгтэй. Энэ бол дархлаатай ардчиллын нэн чухал заалт, энэ хуульд байтугай Үндсэн хуульд зайлшгүй тусгах ёстой зохицуулалт юм. Гэтэл төслийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтад дээрхийг зөрчсөн намд 30 хоногийн дотор алдаагаа засаад дахиж бүртгүүлж болох боломжийг олгосон, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт ийм намуудыг сонгуулийн жил эхэлснээс хойш хориглож болохгүй гэсэн үндэслэлээр тараахгүй орхиж, тэр ч байтугай УИХ-ийн сонгуульд оролцуулж болох

мэт агуулгатай утга авцалдаагүй, аюултай зохицуулалтуудыг тусгасан байгааг хасах шаардлагатай.

13. "Нам үүсгэн байгуулах" гэсэн гарчигтай хоёрдугаар бүлэгт бүхэлдээ улс төрийн нам үүсгэн байгуулах үйл явцыг нарийвчлан зохицуулсан мэт боловч улам хүндрүүлж, хугацаагаар шахаж, улс төрийн нам байгуулагдах нь, олон байх нь муу мэт, Монголын ард түмэн, сонгогчид тэдгээр олон намаас сонголт хийх чадваргүй, чадамжгүй мэт дэвшилтэт бус үзэл санаа, байр суурийг хэвээр хадгалж байгаа нь учир дутагдалтай харагдаж байна.

14. Төслийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт сонгуулийн ямар тогтолцооны үед төрөөс олгох санхүүжилтийг хэрхэн тооцох вэ гэдэг асуудлыг тусгасан боловч өнөөг хүртэл хэрэглэж байгаагүй тогтолцоогоор сонгуулиа явуулсан тохиолдолд хэрхэх нь тодорхойгүй үлдэхээр байна. Тиймээс энд ерөнхий зарчмыг тодорхойлон хуульчлах нь зохистой.

15. Төслийн 31 дүгээр зүйл буюу төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгт төслийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрт заагдсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаалт гэх мэтийг мөн хамааруулах шаардлагатай. Түүнчлэн энэхүү өгүүлбэр нь татварын хууль тогтоомжтой хэр нийцэж буйг нягтлан шалгах хэрэгтэй. "Албан татвараас чөлөөлнө" гэхийн оронд төлсөн татварыг нь ирэх жилд тодорхой хувь хэмжээгээр буцаан олгох тухай бусад хууль тогтоомжид байдаг зохицуулалтыг авч хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

16. Төслийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт нэгдүгээрт, зөвхөн нэр дэвшигчид мөнгөн бус хандив өгөхөөр заасан нь цаашид сонгуулийн хувь тэнцүүлэн сонгох тогтолцоог хэрэглэсэн тохиолдолд хэрэгжих боломжгүй болох, хоёрдугаарт, зөвхөн энэ заалтаар ч бус төслийн ерөнхий агуулгаар улс төрийн намын санхүүжилт болон сонгуулийн санхүүжилтийг тусад нь авч үздэг, үүнийхээ улмаас сонгуулийн жилд улс төрийн намын санхүүжилтийн хуулиар тогтоосон хязгаарлалт, хяналтын зохицуулалт хэрэгжих боломжгүй болдог, сонгуулийн санхүүжилт нэрээр тойрч гардаг муу зохицуулалтыг мөн хадгалан үлдэхээр байна. Улс төрийн санхүүжилт зөвхөн энэ хуулиар тухайлан зохицуулагддаг байж нэг мөр хэрэгжих боломжтой болно.

17. 840 000 төгрөгөөс дээш үнийн дүнтэй хандивыг хандивлагчийн бүх мэдээллийн хамт нийтэд нээлттэй зарлахаар төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт зохицуулсан нь манай орны улс төрийн соёл, хандлагын онцлогийг харгалзан үзвэл олон иргэд, хуулийн этгээдийг улс төрийн намд хандив өгөхөөс зайлсхийхэд хүргэж болзошгүй зохицуулалт байна. Тиймээс нийтэд зарлах энэ босгохыг намд өгөх хандивын хэмжээтэйгээ уялдуулан иргэний хувьд 2 сая, хуулийн этгээдийн хувьд 5 саяас дээш хандивыг хамааруулахаар харьцангуй нэмэгдүүлэн өөрчлөх саналтай байна.

18. Төслийн 35 дугаар зүйлийн 35.5, 35.6 дахь хэсгээр хандив хүлээн авагч намд ногдуулсан үүрэг, хязгаарлалтууд нь улс төрийн намуудыг барагтай нөхцөлд хандив хүлээн авах боломжгүй болгож, нэвтрэх боломжгүй мэдээллийн баазад агуулагдах мэдээллийг мэдэх, шалгах үүргийг ногдуулсан нь зохимжгүй байна. Хуулийн төсөлд бүхэлдээ улс төрийн намуудыг хариуцлагажуулах, процессжуулах гэсэн сайн зорилго агуулсан байж болох ч хэтийдсэн, хүнд суртлын шинжтэй олон дарамт, нарийвчилсан зохицуулалтуудыг тусгасан нь улс төрийн намуудыг үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болгож, улмаар тухайн үеийнхээ эрх баригчдын эрх мэдэл, дур зоргын золиос болох эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

19. Санхүүгийн тайлангийн бүлэгт хэрэгцээгүй маш олон шат дамжлагыг үүсгэж, мөн л улс төрийн намыг чирэгдүүлэх зохицуулалтууд туссан байна. Санхүүгийн тайланг жилд хоёр удаа гаргах, тайланг намын удирдах дээд эсвэл төлөөлөх төв байгууллагаас сонгогдсон санхүүгийн асуудал хариуцсан ажилтан гаргаж байхад мөн тухайн намын удирдах дээд эсвэл төлөөлөх төв байгууллагаас сонгогдсон дотоод аудиторoor хянуулах ёстой. Түүнийгээ хөндлөнгийн аудитын байгууллагаар, улсын төсвийн хөрөнгөөр хянуулж, дүгнэлт гаргуулаад сонгуулийн төв байгууллагад хүргүүлмэгц тэнд мөн санхүүгийн мэдлэг, чадвартай, хянан шалгах чиг үүрэг бүхий нэмэлт нэгжийг байгуулан ажиллуулах шаардлага үүсэж байна. Тэдгээр нь хянасны дараа Төрийн аудитын дээд байгууллагад мөн хянуулахаар өгдөг байх маш хэцүү, олон давхардсан санхүүгийн хяналтын тогтолцоог хуульчилсан байна. Төрөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэмэгдэж байгаатай холбогдуулан хяналтын тогтолцоог сайжруулахыг хүссэн байж болох ч дээрх үе шатуудаас намын өөрийн дотоод аудитор болон сонгуулийн ерөнхий хорооны дээрх нягтлан шалгах үйл ажиллагааг тус тус хасах саналтай байна.

IV. Эх орончдын нэгдсэн нам

Улс төрийн намын тухай хуулийн үзэл баримтлалыг парламентын Бүгд найрамдах улсын намын эрх зүйн байдал, төр, нийгмийн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг, оролцоог хүний эрх, ардчилсан үзэл санаа, зарчимд бүрэн нийцүүлэн боловсруулж, нэгэнт гажиж тогтсон нэг, хоёр намын монопол байдлыг задлах, улс төрийн намуудад гарааны тэгш байдал бий болгох, гишүүнчлэл, санхүүжилт, төрийн дэмжлэг, сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна. Иймд тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Намын бүртгэл, хяналтын байгууллага Сонгуулийн ерөнхий хорооны бие даасан хараат бус, ил тод, шударга байдлыг хангах, хорооны гишүүний томилгоо, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад олон нийтийн хяналт, оролцооны тогтолцоог бүрдүүлэх,

2. Намын хатуу гишүүнчлэлийг намын зохион байгуулалт, улс төрийн мэргэшсэн үйл ажиллагаа дахь оролцоогоор хязгаарлаж, жинхэнэ гишүүн, дэмжигч гишүүний эрх зүйн статусыг тодорхойлох [21.1],

3. Нам аливаа хэлбэрээр төрийн үйл ажиллагаанд шууд оролцохыг хориглох [10],

4. Намын гишүүний нийгмийн хариуцлагын бодлогыг чангаруулж, дүрмийн алдаа, гэмт хэрэг, ёс зүйн зөрчилд гишүүнээс хасах хүртэл арга хэмжээ авах [21.3],

5. Сүүлийн 3 удаагийн УИХ-ын сонгуульд оролцсон намуудад төрөөс нэг удаагийн санхүүгийн дэмжлэг хүртээж, гарааны тэгш байдлыг дэмжсэн хүмүүнлэг бодлого хэрэгжүүлэх [28],

6. Төрөөс санхүүжилт олгох шинэчилсэн журмыг сонгуулийн үр дүнгээр хэрэгжүүлж эхлэхдээ эхний удаад нийт сонгогчдын 1 хувиас дээш санал авсан намд санхүүжилт олгох босгыг аажим нэмэгдүүлэх уян хатан бодлого гаргах [28.3],

7. Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг тодорхой хугацаанд аливаа босго, болзол тавихгүйгээр бүх намд тэгш эдлүүлж, намуудын үйл ажиллагаа төлөвшлийг дэмжих [31],

8. Намуудад өгөх, авах хандивын төрөл, хэмжээ, хэлбэрийг нарийвчлан зохицуулах. Тухайлбал бүх төрлийн гэнэтийн зардлыг гишүүдэд ногдуулан хуваарилах, мөнгө цуглуулах, мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эд хөрөнгө намд өгөхийг хандивт тооцохыг тодорхой болгох, хязгаарлах [33.8],

9. Улс төрийн авлигын далд хэлбэрт тооцогддог үнэ төлбөргүй эсвэл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хийгдэж буй үйлчилгээ, арга хэмжээ, ивээн тэтгэлэг, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх үйлдлүүдийг хандивт тооцох [34.3], төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцож гэрээ байгуулсан этгээдээс сонгон шалгаруулалт зарласнаас хойш болон шалгарсны дараа 4 жилийн хугацаанд хандив өгөх, авах [35.7], олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтран зохион байгуулах арга хэмжээ, хэрэгжүүлэх төслийн санхүүжилт [35.8], нам хэвлэмэл материал эсхүл өөрийн хөрөнгийг худалдан борлуулах үнэ зах зээлийн дундаж ханшаас дээгүүр байвал хандивт тооцох [36.3], зах зээлийн дундаж хүүгээс бага хүүгээр, хүүгүйгээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авсан тохиолдолд тухайн зээлийг намд өгсөн хандивт тооцох [36.7], зээлийг гуравдагч этгээд төлсөн тохиолдолд тухайн төлбөрийг хандивт тооцох [36.8] зэрэг хуулийн хориг, хязгаарыг давсан зүйл заалтуудыг бүрмөсөн хориглох,

10. Намын дарга намын санхүү төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэй оролцохыг хориглосон тохиолдолд тайланг баталгаажуулж намын дарга гарын үсэг зурахгүй байх [38.9],

11. Санхүү, санхүүгийн тайлантай холбоотой зөрчил, маргааныг таслах, хариуцлага тооцох асуудлыг Сонгуулийн ерөнхий хороо биш санхүүгийн хяналт шалгалтын эрх бүхий этгээд, байгууллага шийдвэрлэх.

Улстөрийн намын тухай хуулийн төслийн асуудлаар өмнө нь бусад намуудтай нэгдэж, санал хүсэлтээ хүргүүлсэн болохыг анхаарна уу.

V. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам

“Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн нам” нь Монгол Улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлсэн, нийгмийн ардчиллын үзэл баримтлал бүхий улс төрийн нам юм.

Монгол улс олон намын тогтолцоонд шилжсэн түүхэн цаг үеэс хойш 32 жил болох хугацаанд олон нам шинээр байгуулагдсан нь сайшаалтай боловч Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 36 намын олонх нь улс төрийн намын үндсэн үүргээ биелүүлдэггүй бүх шатны сонгуульд оролцдоггүй, нэг хүний эзэмшилтэй, бодлого хөтөлбөр нь тодорхой биш байсаар өнөөдрийг хүрсэн. Үүний хамгийн том шалтгаан нь санхүүжилт дутмаг учир хандивлагч сонирхлын бүлгүүдийн хараат, ил тод биш, дарга төвтэй зэрэг олон дутагдлыг засах арга зам нь өнөөгийн хуульд тодорхой биш учир иргэдийн улс төрийн намд итгэх итгэлийг бууруулж байна.

Иймд Манай намын зүгээс Монгол улсын ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлж байгаа улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дуу нэгтэй дэмжиж байгаа бөгөөд хуулийн төсөлд дараах 3 саналуудыг тусгуулах хүсэлтэй байна.

Үүнд:

1. Улс төрийн намын санхүүжилт нь гишүүдийн татвар, хандив, төрийн санхүүжилт байна гэж хуульд тодорхой зааж өгөх / төрөөс санхүүжилт авах улс төрийн нам нь сонгогчдын тодорхой хувийн санал авсан улс төрийн нам байх зохицуулалтыг хуульд тусгах /

Шалтгаан: Манай улс төрийн намууд санхүүжилтийн хувьд хандивлагчдын санхүүжилтээс хараат байдаг. Мөнгөний эрх мэдэл хэнд байна тэр хүн намд голлох нөлөөтэй. Тиймээс нам шийдвэр гаргахдаа мөнгөтэй хүмүүс болон тодорхой сонирхлын бүлгүүдийн явцуу эрх ашгийг намын бодлого, гол үзэл баримтлал болгож гаргаад, түүнийгээ хэрэгжүүлэх гэж оролдож байгаа нь өөрөө зохисгүй, бас амьдралд нийцэхгүй. Дэлхийн улс орнуудад 1950-аад оноос хойш ийм үзэгдэл бий болсон тул Герман, Солонгос зэрэг олон улсад шаардлага хангасан улс төрийн намуудаа төр нь санхүүжүүлэх болсон. Энэ бол намуудыг сонирхлын тодорхой бүлгүүдийн санхүүгийн дэмжлэгээс хараат бус байлгах зорилготой. Нам өөрийн үнэт зүйл, үзэл баримтлал дээрээ тулгуурлаж бодлого,

мөрийн хөтөлбөрөө гаргах ёстой гэсэн үг. Тэгж байж улс орны өнөө, ирээдүйн хөгжлийг цогцоор нь харж, төлөвлөж чадна.

2. Улс төрийн нам санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй хагас жил тутамд тайлагнадаг байх заалтыг хуульд тусгах.

Шалтгаан: Улс төрийн намуудын санхүүжилт ил тод биш улс төрийн намын тухай хуульд тодорхой зааж өгөөгүйн улмаас Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ихэнх намууд ил тод биш авлигын бүх төрлийн зөрчил тухайн намын удирдах төвшинд үүсдэг гэж олон нийт гишүүд, дэмжигчид нь үздэг бөгөөд улс төрийн намуудад итгэх итгэлийг алдагдуулж нэр хүндийг унагаах үндсэн шалтгаан болж байгаа тул хуулийн төсөлд тодорхой зааж өгөх нь зүйтэй юм.

3. Намын нийт санхүүжилтийн тодорхой хувийг сонгогчийн боловсрол, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадуудын нийгмийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулдаг зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах.

Шалтгаан: Монгол улсын хэмжээнд нийт сонгогчдын улс төрийн боловсрол дутмаг байдгаас болж бүх шатны сонгуульд оролцох идэвх сул саналаа мөнгөөр худалдах, эдийн засгийн тооцоогүй худал амлалтад итгэх зэрэг олон буруу үзэгдэл газар авсан нь сонгогчийн боловсролтой шууд хамааралтай бөгөөд явцуу эрх ашигтай аль нэг сонирхлын бүлгийн эрх ашгийг хангах таатай нөхцөл бүрдүүлээд зогсохгүй үндэсний аюулгүй байдал, эдийн засагт нэн хортой юм. Иймд төрөөс тодорхой санхүүжилтийг авч байгаа улс төрийн намууд сонгогч, иргэдийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, судалгааны төвүүдийг дэргэдээ байгуулж системтэйгээр насанд хүрсэн бүх хүнд улс төр, нийгмийн мэдлэг олгох нь зүйтэй гэж бидний зүгээс үзэж байна.

VI. Иргэний зориг ногоон нам

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад холбогдох саналаа хүргүүлж байна.

Нэг. Төсөл нь Улс төрийн намын тухай хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиас шинэлэг, дэвшилттэй, улс төрийн намыг дэмжиж төлөвшүүлэхэд чиглэснийг дэмжиж байна.

Хоёр. Улс төрийн намын бүртгэлийг олон улсын жишгийн дагуу Сонгуулийн төв байгууллага эрхлэхээр заасныг дэмжиж байна.

Гурав. Улс төрийн намууд өмнө хамтран хүргүүлсэн саналыг давталгүйгээр ирүүлсэн хуулийн зүйл, заалттай холбогдуулан найруулгын болон зарчмын зөрүүтэй байр суурь, шинэ саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал:

3 дугаар зүйлд, Идэвхтэй нам, идэвхгүй нам гэсэн томьёоллыг нэмж тусгах;

4.2 Улс төрийн нам нь ард түмний хүсэл зоригийг илэрхийлэх гэхийг иргэний/иргэдийн хүсэл зориг гэх /Намд сонгуулийн насны иргэн сайн дурын үндсэн дээр нэгддэг зарчмыг удирдлага болгон/;

5.7 Намаас гарах өргөдлийг хэнд гаргах нь тодорхойгүй байна /намын анхан шатны байгууллага эсвэл намын аль ч шатны байгууллагад эсвэл өөр агуулга?/;

8.2 Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх байгууллага, хяналтын байгууллага, төрийн улс төрийн албан тушаалд сонгогдох, томилоход нэр дэвшигчийг тодруулахдаа намын анхан шатны байгууллагын санал авах тухай төслийн заалтын дагуу санал авахад гишүүдийн оролцоог хэрхэн хангах нь ойлгомжгүй байна. Ийм механизм нь биелэгдэхэд маш хүндрэлтэй гэдгийг анхаарна уу.

8.4 Намын бүх гишүүдийн оролцоог хангана гэдгийг тодорхой болгох. Тухайн намын дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй хурлын гишүүдийн оролцоог хэлж байна уу? Ойлгомжгүй байна. Найруулах шаардлагатай;

24.2, 24.3, 24.4-д Улс төрийн намууд зөвхөн нийлэх бус нийлэх, нэгдэх үйл ажиллагаа явагддаг. Нэгдэх, нийлэх нь тус бүрдээ хууль зүйн өөр өөр агуулга илэрхийлдгийг анхаарч хамтад нь тусгах;

28.3 Нийт сонгогчийн гэснийг сонгуульд оролцсон нийт сонгогчийн гэж өөрчлөх. Мөн нам гэсний ард эвсэл гэж нэмэх;

28.6.1 Нийт сонгогчийн гэснийг сонгуульд оролцсон нийт сонгогчийн гэж өөрчлөх. Мөн нам гэсний ард эвсэл гэж нэмэх;

31.1 Нийт сонгогчийн гэснийг сонгуульд оролцсон нийт сонгогчийн гэж өөрчлөх. Мөн нам гэсний ард эвсэл гэж нэмэх.

31 дүгээр зүйл. Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг

Шинээр нэмэх заалт

31.6 Сонгуулийн сурталчилгааны үед төрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ.

31.6.1 Сонгуульд нэр дэвшигчдийн сурталчилгааны нэгдсэн сонин, сэтгүүл гарган нам, эвсэл бүрд ногдох хуудсыг тогтоож өгөх, сурталчилгааны материалыг сонгогчдод нэгдсэн журмаар тараах;

31.6.2 Сонгуульд нэр дэвшигчдийн сурталчилгааны нэгдсэн самбар гарган, нэр дэвшигчдэд тэнцүү талбай хуваарилан олгох;

31.6.3 Нэр дэвшигчдэд радио, телевизийн нэвтрүүлэг үнэ төлбөргүй явуулах сурталчилгааны хуваарь гарган мөрдүүлэх;

31.6.4 Нэр дэвшигчдийг уулзалтын нэгдсэн талбай, байраар хангах, хуваарийн дагуу сурталчилгаа явуулах боломж бүрдүүлэх.

VII. Монгол Үндэсний Ардчилсан нам

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газраас 2022 оны дугаар сарын 4- ний өдөр ирүүлсэн Улстөрийн намын тухай хуульд санал авах тухай ТГ/302 тоот албан бичигт үүгээр хариу хүргүүлж байна.

Үүнд:

Хуулийн төслийн 6.5 Орон нутаг дахь салбар нэгж нь намынхаа нэрийн өмнө тухайг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг заасан тодотголыг хэрэглэх гэснийг хасах

10.6 намын анхан шатны болон дунд шатны салбар нэгжийн төлөөллийн болон гүйцэтгэх байгууллагын гишүүдийн гэснийг хасах

21.5 -г Улс төрийн намын гишүүнчлэл 1 жилийн хугацаатай байх бөгөөд жил бүр намын гишүүдээ өөрийнх нь хүсэл зоригт түшиглэн шинэчлэн бүртгэнэ. гэж өөрчлөн найруулах

21.6/Намын гишүүн намын аль нэг байгууллагад намаас гарах хүсэлтээ гаргасан эсхүл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр намаас гарч байгаагаа мэдэгдсэнээр намаас гарсанд тооцно.

28.3 /28.6.1/ Нийт сонгогчдын 3 хувь гэснийг сонгуульд оролцсон нийт сонгогчдын 1 хувь гэж өөрчлөх,

28.6.1, 31.1 заалтууд дахь "Нийт сонгогчдын гэснийг сонгуульд тоологдсон хүчинтэй саналын гэж өөрчлөх,

Европын олон орны судалгааны байгууллагууд, судлаачид иргэний нийгмийн байгууллага хөгжөөгүй оронд зах зээлийн систем төлөвшиж чадахгүй байгаа болон төрийн хүчирхийлэл, намчирхсан туйлшрал, бодлогын савлагааг сөрөн зогсож

чадах уламжлалт иргэний нийгмийн хүчирхэг байгууллагуудтай орнууд эдийн засгийн хөгжил илүү хурдацтай байгааг дүгнэжээ.

Шведийн эрдэмтэн Жохан Норберг, Прагийн Их сургуулийн судлаач Майкл Клима нар энэ талаар ном бүтээл гаргасан байна.

Манай улсын хөгжилд хамгийн том чөдөр, тушаа болж байгаа саад бэрхшээл бол орон даяар засаг захиргааны нэгж, албан байгууллага бүрд намын нэгж бүхий хуучин тоталитар намын бүтцээ хадгалж шинээр байгуулагдсан бүх нам ийм бүтэцтэй болохоор зорьж байгаа нь Монгол улсыг бүхэлд нь намчирхал, талцлийг талбар болгож, нийгмээрээ ахуй амьдралаа умартан улс төр, сонгуулийн зорилготой үйл ажиллагаа явуулдаг, сонгуулийн эдийн засагтай орон болгож хувиргасан байна.

Монгол улсад том төсөл бүү хэл, жижиг, дунд үйлдвэрлэл хөгжихгүй, өрхийн үйлдвэрлэл сул, хөдөөд хоршоо үүсэхгүй байгаа болоод эхлэл төдий бүхнийг сонгууль бүрийн дараа ээлжлэн нухчин дарж байгаа нь улс орны хөгжилд асар их хор хохиролтой зохион байгуулалт болж ирлээ. Намчирхаж талцсан нийгмийн золиос нь төрийн халамж, улс төрчдийн гар харсан анхан, дунд шатны өргөн давхаргыг бий болгоод байна. Хот руу чиглэсэн их дүрвэлт, хөдөөд суурьших сонирхлын мухардал чухамдаа намчирхал талцлаас үүдэлтэй юм.

Улс төрийн нам хүчин, улс төрчдийн нөлөөлөлгүй иргэний нийгмийн байгууллага байхгүй шахам байгаа нь цаашид хүмүүнлэг иргэний нийгэм байгуулах Үндсэн хуулийн зорилт хэрэгжих боломжгүйг тод харуулж байна.

Иймд Монгол Үндэсний Ардчилсан нам "Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд хуулийн шалгуур хангасан иргэн өөрөө нэрээ дэвшүүлэн оролцоно. Улс төрийн нам сум, дүүрэгт намын бүтэц байгуулахыг хориглоно." гэж хуульчилж байж иргэний нийгэм соёолон хөгжих үндэс суурь бүрдэнэ гэсэн зарчмын байр суурьтай байгааг онцгойлон анхаарна уу.

Мөн Улс төрийн намын тухай хуульд оруулах намуудын зөвшилцөж нэгдсэн саналыг тусгайлан хүргүүлсэн болно.

VIII. Үнэн ба зөв нам

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдөр ирүүлсэн ТГ/302 тоот албан бичиг болон хуулийн төсөлтэй танилцлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч гэж үндсэн хуульд заасан эрхэм үүргээ нэр төртэй хангаж ард түмний улс төрийн эвлэлдэн нэгдэх эрх, оролцоог хангах, Улс төрийн намын тухай

хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихаар бэлдэхдээ улс төрийн намууд, эрдэмтэн судлаачдаас санал авч байгаа баярлаж байна.

Бид энэ хуулийн төсөлтэй холбоотой дараах саналыг дэвшүүлж байна.

Үүнд:

1. 4.2 дугаар зүйлд шинээр 4.2.8. нам нь хариуцлага алдсан, авлига албан тушаалын хэрэгт холбогдсон гишүүддээ ёс зүйн хариуцлага тооцдог байна.
2. 5.16.намын гишүүн байсан, улс төрийн алба хашиж байгаа хүн гэмт хэрэгт холбогдох юм бол тухайн ажиллаа өгч байгаад хуулийн байгууллагад шалгуулах.
3. 22.1.3. намын удирдах дээд байгууллагыг эсхүл төлөөллийн төв байгууллагыг 5 жилийн хугацаанд хуралдуулаагүй гэснийг намын удирдах дээд байгууллагыг эсхүл төлөөллийн төв байгууллагыг 6 жилийн хугацаанд хуралдуулаагүй гэж өөрчлөх.
4. 22.1.4. Намын төв байгууллага нь байнгын байрлах ажлын байргүй, нийгэмд үзэл санаа, бодлого хөтөлбөрөө танилцуулаагүй
5. 12.3.Үүсгэн байгуулах хурал болох өдөр эсхүл түүнээс өмнө нам нь намын гишүүнээр элсэхээ илэрхийлсэн 801-ээс доошгүй иргэний гарын үсгийг эсхүл цахимаар баталгаажуулна гэснийг Үүсгэн байгуулах хурал болох өдрөөс өмнө өөр намын гишүүн биш Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес*дүгээр 2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна. Гэсэн заалтын дагуу иргэний гарын үсгийг эсхүл цахимаар баталгаажуулна
6. 32.6. Бүх намаас нэр дэвшигчдийн танилцуулга материалыг нэгдсэн байдлаар сонгуулийн хороо хэвлэж өгнө. Ингэхдээ хэвлэлийн зардлыг нар дэвшигчдэд хувааж тэнцүү гаргуулна.
7. 32.7. Бүх намаас нэр дэвшигчдийн ухуулга сурталчилгааны байрыг нэг дор нэгдсэн зохин байгуулалттайгаар төрөөс хангаж өгнө.
8. 32.8. бүх намаас нэр дэвшигчид тухайн тойрогтоо нэгдмэл зохион байгуулалттай байна. Тус тусдаа тараах материал хэвлэх, ухуулах байртай байхыг хориглоно.
9. 32.9. бүх намаас нэр дэвшигчид буюу нэг нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны баг 21 хүнээс илүүгүй байна.

Дээрх саналыг гаргаж хүргүүлж байна. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг гаргаж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгч, тамгын газрын хамт олонд амжилт хүсье.

IX. Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад дараах санал, асуулга, хүсэлт байна. Үүнд :

1. Тус хуулийн 5.7 Намын гишүүн хэзээ ч намаас гарах эрхтэй. Намын гишүүнээс гарах тухай өргөдлийг гаргаснаар намаас нарсанд тооцно. Намын дотоод асуудал биш үү? Боловсон хүчнээ яаж тогтвортой барих бэ? Дүрмээр зохицуулах боломж олгохгүй юу?
2. Тус хуулийн 5.9 хүн амын мэнд гэж бичигдсэн байгааг хүн амын эрүүл мэнд гэж засах уу?
3. Тус хуулийн 5.12 Төрийн жинхэнэ албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх үедээ аль нэг намын эрх ашгийг хамгаалсан, давуу байдал олгосон шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Ямар арга хэмжээ авах? Ялангуяа сонгуулийн үеэр тухайн намын нэр дэвшигчийг эргүүлэн татах нх орноосоо урвасан гэсэн заалт руу оруулъя.
4. Тус хуулийн 7.2.1 Монгол Улсын Ерөнхийлөгчид тухай намдаа 12 сараас доошгүй хугацаагаар гишүүн байсан хүнийг л дэвшүүлье.
5. Тус хуулийн 8.2.4 аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх гэдгийг авч хаях
6. Тус хуулийн 10.3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, /гэж нэмж өгье/ улс төрд нөлөөлөх зорилго бүхий,
7. Тус хуулийн 11.1 аль нэг хүйсийн 40 хувиас доошгүй байх бөгөөд залуучуудын төлөөллийг оруулна гэдгийг хасъя.
8. Тус хуулийн 12.4 -д 30 хувиас доошгүй нь гэдэг нь ямар эндэслэлтэй бэ?
9. Тус хуулийн 15.8 Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалт болохоос 90 хоногийн дотор гэдгийг 180 хоног гэж өөрчилъе.
10. Тус хуулийн 18.2.2. Төв байгууллагын бүрэлдэхүүнийг тус тус дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох гэдгийг өөрчилж дөрвөн жил тутамд байж болох юм.
11. Тус хуулийн 18.6 Хасах санал байна.

X. Монгол хүний төлөө нам

Өнөөгийн улс төрийн байдал, төрийн чадамж, Засгийн газрын бодлого хэрэгжүүлэлт зэргийг үндэслэн дүгнэхэд манай оронд улс төрийн шинэчлэл хийж бодлогын өрсөлдөөн бий болгохгүй бол хөгжил өөд хөдөлгөөн муутай, ажил хэрэгжүүлэх биш бодлого шийдлийн эрэлд алтан цагаа барсан байдалд байна.

Улс төрийн шинэчлэлийг зоригтой хийх нь зөвхөн улс төрийн намуудын асуудал бус нийгмийн хөгжил дэвшлийн суурь гэдгийг ухамсарлан ажиллах нь улс төрийн салбарт зүтгэж буй хүн, хүчин бүрийн үүрэг.

Монгол улсын улс төрийг мөнгө хөрөнгөнөөс хараат бус, мэргэд ухаан бодлоо уралдуулж, сонгогчид мэдлэгтэй мэргэн байж, олон нийтийн санал гээгддэггүй, шилдгүүд төр засагт зүтгэдэг нөхцөлийг бүрдүүлж үлдээх нь бидний боломж, түүхэн үүрэг гэж бид үзэж байна.

Улс төрийн шинэчлэл хийхэд "Улс төрийн намуудын тухай", "Сонгуулийн тухай" хуулиуд цогцоор нь өөрчлөгдөх шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлэн "Улс төрийн намуудын тухай хууль"-д оруулах шаардлагатай гэж хавсралтаар хүргүүлээ.

Улс төрийн намын тухай, Улс төрийн санхүүжилтийн тухай хуульд оруулах зарчмын саналууд

Улс төрийн намын тухай, улс төрийн санхүүжилтийн тухай хуулийг сонгуулийн тухай хуультай хамт, зэрэгцүүлэн хэлэлцэх нь зүйтэй. Учир нь намын дийлэнхи зарлага сонгуулийн үеэр гаарч, хүч тэнцвэргүй "тулаан" болдог.

Улс төрийн намын тухай шинэ хуулийн үндсэн зорилго нь улс төрийн хүрээг, улс төрийн намыг мөнгөний болон гишүүнчлэлийн дарамтаас салгаж, улсын хэмжээнд бодлого боловсруулж, хэрэгжүүлж чаддаг бодлогын институци болгоход орших ёстой.

№	Санал	Үндэслэл	Ач холбогдол
1	Ямар нэгэн нам, олон нийтийн байгууллага байгуулж бүртгүүлэхэд хүний тоо г.м. ямар ч нэмэлт шаардлага байж болохгүй. Иймд бүртгэлтэй нам, бодлого хэрэгжүүлэгч нам гэсэн ойлголт бий болно.	2.16.10 - "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно." 2.19.1 "Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10- т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана."	1. Үндсэн хуульд заасан хүний эрхийг ялгаварлахгүй эдлүүлнэ. 2. Улс төрийн нам, ТББ байгуулахад ойлгомжтой хялбар болно. 3. Сонгогчдын тодорхой хувийн саналыг авч босго давснаар "Бодлого хэрэгжүүлэгч нам" статустай болж төсвийн санхүүжилт хүртэх эрх нээгдэнэ.

		2.14.2 "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно."	
2	Улс төрийн нам нь хатуу гишүүнчлэлгүй, бодлогын байгууллага байх.	2.19.1 "Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10- т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана."	<p>1. Намын гишүүнчлэлээр ялгаварлах үзэгдэл багасч, хүмүүсийг намын хатуу дэглэмээс чөлөөлж иргэдийн талцал үгүй болж, үзэл санааны эрх чөлөөтэй болгоно.</p> <p>2. Улс төрийн нам нь гишүүд, бизнес бүлэглэлээс хараат бус байх нөхцөл бүрдэнэ.</p> <p>3. Сонгох эрх илүү эрх чөлөөтэй, ухамсрын, мэдлэгийн сонголт хийдэг болно.</p> <p>4. Ж: намын гишүүнчлэлээсээ болоод ажилгүй байгаа жүжигчин ч байна, багш ч байна.</p> <p>5. Энэ заалт гишүүнтэй байхыг хориглохгүй /гишүүдийн дээд хязгаарыг зааж болно/.</p>

			6. Намын харьяаллаар ялгаварлахгүй, жинхэнэ мерит зарчмын төрийн сүлжээ бий болно.
3	Улс төрийн нам өөрийн мөрийн хөтөлбөр, бодлогын дагуу хууль боловсруулан Монгол улсын Ерөнхийлөгчөөр дамжуулан өргөн барих эрхтэй.	Үндсэн хуулийн 3-р бүлэг 26.2. 2. Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.	1. Улс төрийн нам нь бодлогын байгууллага байхын хувьд тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжтой болно. 2. Улс орны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд илүү зоримог, шийдэмгий ажиллах нөхцөл бүрдэнэ.
4	Улс төрийн намын өдөр тутмын үйл ажиллагааг тодорхой шалгуурын дагуу төсвөөс санхүүжүүлэх.	2-19-2 "Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна." гэснийг шалгуурт тооцох боломжтой. Нэгэнт төсвөөс санхүүжүүлэх бол шалгуур, хяналтыг төгс байлгах шаардлагатай.	1. Улс төрийн намын үйл ажиллагаа тасралтгүй, жигд, төлөвлөгөөтэй явагддаг болно. 2. Сонгуульд ч оролцдоггүй "тоглоомын" нам гэсэн ойлголт үгүй болно. 3. Улс төрийн нам санхүүжилт босгох биш бодлогын ажилдаа илүү анхаардаг болно.

5	Улс төрийн намын санхүүжилт нь ижил хэмжээний аппарат ажиллуулах хэмжээний байх нь оновчтой. Саналын тоо нь ажлын дүн мөн боловч дахин тэгш бус байдал үүсэх, нүсэр бүтэц рүү тэмүүлэх шалтгаан болно.	1-2-2 “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” 2-14-2 “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.”	
6	Улс төрийн нам татан буулгах нөхцөл, шалгуурыг тодорхой болгох. Ж: 2 удаагийн сонгуульд оролцоогүй бол, 2 удаагийн сонгуульд сонгогчдын 1%-ийн санал аваагүй бол г.м.	2.19.21 “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.” Улс төрийн нам нь бодлогоо үндэсний хэмжээнд, далайцтай хэрэгжүүлэхийн тулд төрийн эрхэнд гарахыг эрмэлзэх чанартай.	1. Олон намын тогтолцоо чанаржина, 2. Улс төрийн намуудын байдал ойлгомжтой болно 3. Мэргэшсэн улс төр шаардлагатай болж нийгмийн зүтгэлтнүүд төлөвшинө.
7	Улс төрийн нам ашгийн үйл ажиллагаа явуулах, өөрийн үл хөдлөх хөрөнгөтэй байхыг хориглох		1. Хөрөнгө, өмч мөнгөний төлөөх тэмцэл уралдаан болж, түүнийгээ илүү өмч бүрдүүлэх хэрэгсэл

			болгохоос сэргийлэх
8	Улс төрийн нам орон нутагт салбар нэгж байгуулах, орон нутгийн сонгуульд оролцохыг хязгаарлах	1.2.1 “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.”	1. Орон нутгийг нэгдсэн нэг бодлогоор, нэг л Засгийн газрын шийдвэрээр Засаг даргаар дамжуулан удирдах ёстой. 2. Эрх барьж байгаа намаас өөр нам орон нутгийн сонгуульд ялж, өөр намын харьяалалтай Засаг дарга тавигдах нь таамаглах аргагүй хавчлага, үл дэмжих г.м. асуудлуудыг үүсгэж холбооны улсын шинжтэй болгодог.

УЛСТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ

ШИНЭЧИЛСЭН ХУВИЛБАР

Хуулийн зорилт: Улс төрийн намын тухай хуулийн зорилт нь Монгол улсын Үндсэн хуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд ард түмнийг зохион байгуулалттайгаар эвлэлдэн нэгдэх, аливаа нийгмийн асуудлуудаар шинжлэх ухаанч бодлогыг хамтарч гаргах, УИХ-ыг байгуулахад оролцох, улс орныг удирдах үндсэн чиг үүрэг бүхий улс төрийн намын үйл ажиллагааны журмыг тодорхойлоход оршино.

1-Р БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	2-Р БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМ БАЙГУУЛАХ, ЭВЛЭЛДЭН	3-Р БҮЛЭГ УЛСТӨРИЙН НАМ БУСАД
---	--	-------------------------------------

	НЭГДЭХ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ	БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАРИЛЦАХ
4-Р БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГИШҮҮНЧЛЭЛ	5-Р БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ	6-Р БҮЛЭГ УЛСТӨРИЙН НАМЫГ ӨӨРЧЛӨХ, НЭГТГЭХ, ТАТАН БУУЛГАХ

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт

Улс төрийн намын тухай хуулийн зорилт нь Монгол улсын Үндсэн хуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд ард түмнийг зохион байгуулалттайгаар эвлэлдэн нэгдэх, аливаа нийгмийн асуудлуудаар шинжлэх ухаанч бодлогыг хамтарч гаргах, УИХ-ыг байгуулахад оролцох, улс орныг удирдах үндсэн чиг үүрэг бүхий улс төрийн намын үйл ажиллагааны журмыг тодорхойлоход оршино.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, УЛСТӨРИЙН НАМ БАЙГУУЛАХ

1-р зүйл. Улс төрийн намын тухай хууль тогтоомж

1. Улс төрийн намын тухай хууль тогтоомж нь Монгол улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжуудын актаас бүрдэнэ.
2. Энэхүү хуулийг дагаж мөрдөхөд маргаантай аливаа асуудал үүсвэл Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол улсын Үндсэн хуулийн үндсэн зарчим, үзэл санаанд нийцүүлэн тайлбарлах ба тухайн маргаантай асуудлаар тайлбар гаргуулахаар эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрх иргэн бүхэнд нээлттэй.

2-р зүйл. Улс төрийн намын тухай ойлголт

1. Улс төрийн нам нь Монгол улсын Үндсэн хуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө өөрийн үзэл бодол, итгэл үнэмшил, авьяас чадвар, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол улсын иргэдийн нэгдэл мөн.
2. Улс төрийн нам нь Монгол улсын ирээдүйн хөгжлийн шийдлийг цогцоор шийдвэрлэх бодлого боловсруулах, түүнийгээ сурталчлах, тухайн бодлогоороо улс орноо хөгжүүлэхийн төлөө төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их

Хуралд төлөөллөө оруулахын төлөө улс төрийн сонгуульд оролцох эрхтэй шинжлэх ухаанч иргэдийн нэгдэл мөн,

3. Улс төрийн нам нь өөрийн гишүүд, дэмжигчид төдийгүй Монгол улсын бүхий л ард иргэдийг шинжлэх ухаанчаар соён гэгээрүүлэх үүрэг бүхий мэдээлэл, хөгжлийн төв юм.

4. Улс төрийн нам нь үлгэр жишээ, үнэнч, шударга, манлайлагч иргэдийн нэгдэл бөгөөд аливаа гэмт хэрэг, хуйвалдаан, авлига, хээл хахууль, аминч үзлийг үл тэвчигч олон нийтийн хүсэл, эрх ашгийг дээдэлсэн ашгийн төлөө бус нийгмийн зөв зохистой харилцааг бүтээгч эв нэгдлийн төв юм.

5. Улс төрийн нам нь эрх бүхий байгууллагад бүртгэгдэж гэрчилгээ, тамга тэмдгээ гардан авснаар улс төрийн бүх шатны сонгуульд оролцох, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үйл ажиллагаа явуулах эрхтэй.

3-р зүйл. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга

1. Улс төрийн намыг зөвхөн Монгол улсын иргэн санаачилж үүсгэн байгуулна. Монгол улсыг ирээдүйд хөгжүүлэх шинжлэх ухаанч санал гаргасан хэн боловч өөрийн нийгмийг хөгжүүлэх санал, оюуны бүтээлийг үндэслэн улс төрийн нам үүсгэн байгуулах эрхтэй.

2. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга гаргасан иргэн Монгол улсын Дээд шүүхэд улс төрийн нам байгуулах санаачилга гаргаснаа мэдэгдэж тухайн санаачилгаа бүртгүүлэн өөрийн нам байгуулах үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

3. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга гаргасан иргэн дараах бичиг баримтын хамтаар хүсэлтээ Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Үүнд: өргөдөл, улс төрийн нам байгуулах зорилго, мөрийн хөтөлбөрийн төсөл, улс төрийн нам үүсгэн байгуулах үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө

4. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга гаргасан иргэн санаачилга бүртгүүлсэн өдрөөс эхлэн 365 хоногт багтаан өөрийн санаачилгыг олон нийтэд сурталчлан танилцуулах бөгөөд улс төрийн нам үүсгэн байгуулах Их хурлаа зохион байгуулж намын нэр, бэлгэдэл, дүрэм, мөрийн хөтөлбөр, намдаа элсүүлсэн Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй гишүүд, дэмжигчдийн бүртгэл зэргийг их хурлаараа баталгаажуулан Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

5. Улс төрийн нам байгуулах тухай санаачилга гаргасан иргэний хүсэлтийг Улсын дээд шүүх хүлээн авч улс төрийн нам үүсгэн байгуулах түр гэрчилгээ, тэмдгийг олгоно.

6. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга гарган Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн иргэнийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлага дэмжих бөгөөд ямар нэгэн байдлаар саатуулах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4-р зүйл. Улс төрийн намыг бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгүүд

1. Улс төрийн нам үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл
2. Улс төрийн намын оноосон нэрийн лавлагаа
3. Улс төрийн намын бэлгэдэл, түг
4. Улс төрийн намын мөрийн хөтөлбөр
5. Улс төрийн намын дүрэм
6. Улс төрийн намын даргыг сонгосон шийдвэр
7. Улс төрийн намд элссэн Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэдийн бүртгэл
8. Улс төрийн нам үүсгэн байгуулж намын их хурлаар хэлэлцэн баталсан асуудлуудыг баталгаажуулсан тогтоол
9. Улс төрийн намыг бүртгүүлэхийг хүссэн намын даргын хүсэлт

5-р зүйл. Улс төрийн намыг бүртгэх

1. Монгол улсын дээд шүүх нь улс төрийн намыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах бүх төрлийн бүртгэлийг эрхэлнэ.
2. Улс төрийн нам үүсгэн байгуулах, түүнийг бүртгэх үйл ажиллагаа нь улс төрийн нам байгуулах санаачилга гаргах, улс төрийн нам үүсгэн байгуулах гэсэн 2 үе шаттай байна.
3. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилгыг Монгол улсын сонгуулийн насанд хүрсэн хэн боловч ялгалгүй гаргах эрхтэй.
4. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга гаргасан иргэний хүсэлтийг Монгол улсын дээд шүүх хүлээн авч улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилгыг бүртгэж түр гэрчилгээ, тэмдэг олгоно.
5. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга гаргасан иргэн тухайн санаачилгыг бүртгүүлж түр гэрчилгээ, тэмдэг гардан авснаас хойш 365 хоногт багтаан нам үүсгэн байгуулах Их хурлаа хуралдуулж улс төрийн намаа үүсгэн байгуулж бүртгүүлэхээр Улсын дээд шүүхэд бичиг баримтаа хүргүүлнэ.
6. Улс төрийн нам бүртгүүлэх хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшилсон тохиолдолд түр гэрчилгээ, тэмдгийг шалтгаант хугацаагаар 1 удаа сунгаж болно.

7. Улсын дээд шүүх улс төрийн нам үүсгэн байгуулах Их хурлын шийдвэрүүдийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор улс төрийн намыг бүртгэж гэрчилгээ олгоно.

8. Хуулийн тогтоосон шаардлага хангаагүй тохиолдолд улс төрийн намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж болно.

6-р зүйл. Улс төрийн намыг бүртгэхээс татгалзах

1. Бичиг баримтын бүрдүүлбэр хуулийн шаардлагад нийцэхгүй байгаа бол улс төрийн намыг бүртгэхээс татгалзана.

2. Иргэдийн эрх чөлөөнд халдсан, улс төрийн намд нэгдэхийг албадсан, хуурсан, элдэв зүйл амласан гэх үндэслэл бүхий гомдол иргэдээс ирүүлсэн тохиолдолд улс төрийн намыг бүртгэхээс татгалзаж холбогдох шалгалтыг зохион байгуулахыг хуулийн байгууллагад даалган шалгалтын ажил дууссаны дараа бүртгэлийн асуудлыг дахин шийдвэрлэнэ.

7-р зүйл. Улс төрийн намыг бүртгэсний дараах эрх зүйн байдал

1. Улс төрийн нам бүртгүүлснээр улс төрийн сонгуульд оролцох эрх зүйн этгээд болно.

2. Улс төрийн нам өөрийн үйл ажиллагааг дэмжигч, гишүүдийн идэвхтэй үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.

3. Улс төрийн намын үйл ажиллагаа сайн дурын үйл ажиллагаа гэдгийг ухамсарлан аливаа эрсдэл, хариуцлагыг өөрсдөө хүлээнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УЛС ТӨРИЙН НАМ БАЙГУУЛАХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

8-р зүйл. Улс төрийн нам байгуулах, улс төрийн намд эвлэлдэн нэгдэх эрх

1. Монгол улсын иргэн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Улс төрийн нам үүсгэн байгуулах санаачилга гаргах эрхийг 18 наснаас эдэлнэ.

2. Улс төрийн амьдралд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй.

3. Монгол улсын иргэн улс төрийн намаар уламжлан улс төрийн сонгуульд нэрээ дэвшүүлэх эрхтэй.

4. Монгол улсын иргэний үзэл бодол, нам эвслээр нь ялгаварлан гадуурхаж үл болно.

5. Монгол улсын иргэн улс төрийн нэг намын гишүүн байна.

9-р зүйл. Төрийн албан хаагч улс төрийн намтай харилцах эрх

1. Төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгээгүй үедээ улс төрийн намын үйл ажиллагаатай танилцах, улс төрийн намын бодлогын хэлэлцүүлэг, үйл ажиллагаанд оролцох, санал гаргах эрхтэй

2. Төрийн албан хаагч улс төрийн намын гишүүн байж болохгүй.

3. Төрийн албан хаагч улс төрийн намаас хараат бус байж гагцхүү хуульд захирагдана.

9-р зүйл. Улс төрийн намын гишүүнээр элссэн иргэний эрх, эрх чөлөөний баталгаа

1. Өөрийн улс төрийн эрх, эрх чөлөөг зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ сэргээлгэхээр улс төрийн намын гишүүн нь хууль хяналтын байгууллагад гомдол гаргах эрхтэй.

2. Улс төрийн нам гишүүдээ хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах, эрх бүхий байгууллагад асуулга хүргүүлэх, шаардлага гаргах эрхтэй.

3. Улс төрийн нам нь өөрсдийн гишүүд болон нийгмийн эрх ашиг хөндөгдсөн гэж үзвэл хууль дээдлэх зарчмын хүрээнд тодорхой асуудлуудаар тайван жагсаал, цуглаан зохион байгуулах, хэвлэн нийтлэх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, шаардлагатай мэдээллийг олон нийтэд мэдээлэх эрхтэй.

4. Улс төрийн намд эвлэлдэн нэгдсэн иргэдийн эрхийг төр хамгаална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УЛСТӨРИЙН НАМ БУСАД БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАРИЛЦАХ

10-р зүйл. Улстөрийн намаас төрийн байгууллагатай харилцах

1. Улс төрийн нам нь нийгмийн тодорхой асуудлуудаар бодлого боловсруулахдаа төрийн байгууллагуудаас мэдээ, мэдээллийг гаргуулан авах эрхтэй.

2. Улс төрийн нам нь хууль санаачлах эрхийнхээ хүрээнд аливаа хуулийн төслийн талаар төрийн байгууллагуудаас санал авах, өөрсдийн боловсруулж буй хуулийн төслөө танилцуулж болно.

3. Улс төрийн нам төрийн байгууллагатай харилцахдаа өөрсдийн үзэл бодлыг тулгах, үйл ажиллагаанд нь хууль бусаар нөлөөлөхийг хориглоно.

4. Улс төрийн нам нь үйл ажиллагаандаа төрийн эрх мэдэл, төсвийн хөрөнгө мөнгийг ашиглахыг хориглоно. Гагцхүү хууль боловсруулах, сурталчлах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор ил тод, нээлттэй гэрээний үндсэн дээр санхүүжилт авч болно.

11-р зүйл. Улс төрийн намаас аж ахуй нэгжүүдтэй харилцах

1. Улс төрийн нам нь бодлого үйл ажиллагаагаа хөгжүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай тодорхой салбар асуудлуудаар нээлттэй хамтран ажиллаж болно.

12-р зүйл. Улс төрийн намаас олон нийтийн байгууллагуудтай харилцах

1. Улс төрийн намаас олон нийтийн байгууллагуудтай нээлттэй харилцаж нийгмийн тулгамдсан тодорхой асуудлуудаар бодлого боловсруулахаар хамтран ажиллаж болно.

2. Улс төрийн нам нь олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна өөрийн гишүүд дэмжигчдийн хүрээнд олон нийтийн байгууллагууд зохион байгуулж түүгээрээ дамжуулан ижил төрлийн холбоо, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ба үндэсний эв нэгдлийг хангах зарчмын хүрээнд эвлэлдэн нэгдэж нэг бүтэц болж болно.

13-р зүйл. Улс төрийн намаас шашны байгууллагуудтай харилцах

1. Улс төрийн нам нь үндсэн хуулийг дээдлэн ажиллах ба шашин шүтэх, эс шүтэх эрх эрх чөлөөг хүндэтгэнэ.

2. Улс төрийн нам шинжлэх ухаанч хөгжлийг дэмжих зорилготой бүтэц тул шашны аливаа зан үйлийг намын үйл ажиллагаандаа ашиглах, шашнаар дамжуулан гишүүн элсүүлэх зэргийг хориглоно.

14-р зүйл. Улс төрийн намаас гадаад улс орнууд, тэдний төлөөлөгчийн газартай харилцах

1. Улс төрийн нам нь Монгол улсын нэр хүндийг өндөрт өргөж гадаад улс орнуудын байгууллагуудтай харилцахдаа Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний эрх ашгийг ямагт эрхэмлэнэ.

15-р зүйл. Улс төрийн намаас хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцах

1. Улс төрийн намаас хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцахдаа өөрийн хэвлэл мэдээллийн албаараа уламжлан харилцана.

16-р зүйл. Улс төрийн намаас боловсролын байгууллагатай харилцах

1. Улс төрийн намаас мөрийн хөтөлбөр, хуулийн төсөл боловсруулах чиглэлээр хамтран ажиллаж болно.

17-р зүйл. Улс төрийн намаас бусад улс төрийн намуудтай харилцах

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

УЛСТӨРИЙН НАМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГИШҮҮНЧЛЭЛ

18-р зүйл. Улс төрийн намын эрх барих байгууллага

1. Улс төрийн намын эрх барих дээд байгууллага нь намын Их хурал байна.
2. Их хурлын чөлөөт цагт намын удирдах зөвлөл, намын дарга намын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

УЛСТӨРИЙН НАМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ

20-р зүйл. Улстөрийн намын үйл ажиллагаа

Улс төрийн нам дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

1. Хууль санаачлах
2. Хөгжлийн цогц бодлого боловсруулах | мөрийн хөтөлбөр |
3. Хууль сурталчлах, соён гэгээрүүлэх
4. Гишүүд, дэмжигчдээ хамгаалах, хөгжүүлэх, нэгтгэх
5. Улс төрийн бүх шатны сонгуульд оролцох
6. Улс орныг удирдах бүтэц, зохион байгуулалт, арга зүйг боловсруулах
7. Эрх баригч намын үйл ажиллагаа, шийдвэрт хяналт тавих, асуулга, санал, зөвлөмж хүргүүлэх

21-р зүйл. Улс төрийн намын үйл ажиллагааны зарчим

1. Ардчилсан ёс, хууль дээдлэх, тэгш байдал, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг хангах нь улс төрийн намын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

УЛСТӨРИЙН НАМЫГ ӨӨРЧЛӨХ, НЭГТГЭХ, ТАТАН БУУЛГАХ

---oOo---

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

2023 ОН

УДИРТГАЛ

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийн, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго нь оршино.

Хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”¹-д заасны дагуу

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн нөлөөг үнэлэхдээ үндсэн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалтууд нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн зорилгод нийцсэн, түүнд хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийснээс гадна хуулийн төслийн зохицуулалт практикт хэрэгжих боломжийг туршсан байдалд дүн шинжилгээ хийлээ.

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний судалгааг гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулалтын хүрээтэй уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуураас 4 шалгуур үзүүлэлтийг сонгож төслийн үр нөлөөг үнэллээ.

Үүнд:

- Зорилгод хүрэх байдал;
- Ойлгомжтой байдал;
- Харилцан уялдаа зэрэг болно.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгов. Эдгээр зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдолтой заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалт бий болгож буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа. Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцохоор сонгосон хэсгээ шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзэв.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Тус хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулагдсан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1-д “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана” гэж, 2-т “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна” гэж, 3-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэж нэмэлт оруулсан.

Түүнчлэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 1.4-т Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлтэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах; намын үйл ажиллагаа,

дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах; Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх; төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох.” чиглэл баримтална гэж заасан.

Шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам /цаашид “нам” гэх/ үүсгэн байгуулах, намын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.” заасан байна. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой дараах зохицуулалтыг сонгов.

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	<p>Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1-д “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана” гэж, 2-т “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна” гэж, 3-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэж нэмэлт оруулсан.</p>	<p>Хуулийн төслийн ТАВДУГААР БҮЛЭГ</p> <p>НАМЫН САНХҮҮЖИЛТ</p> <p>26 дугаар зүйл.Намын орлогын эх үүсвэр</p> <p>26.1.Намын орлого нь дараах эх үүсвэртэй байна:</p> <p>26.1.1.төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;</p> <p>26.1.2.гишүүний татвар;</p> <p>26.1.3.хандив;</p> <p>26.1.4.намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого;</p> <p>26.1.5.энэ хуулийн 36.3-т заасан бусад орлого.</p> <p>26.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу төрөөс намд үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу олгох төрийн санхүүжилт болон энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгээс бүрдэнэ.</p>

26.3.Жил бүрийн намд олгох төрийн санхүүжилтийн дор дурдсан хувийг дараах зориулалтаар зарцуулна:

26.3.1.төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сурган бэлтгэх;

26.3.2.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг олон нийтэд таниулах;

26.3.3.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх.

26.4.Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар зарцуулна.

26.5.Энэ хуулийн 26.3-т заасан санхүүжилтийг тухайн зорилгоос өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

26.6.Төрийн санхүүжилтийн холбогдох хувийг энэ хуулийн 26.3-т заасныг зөрчин зарцуулсан бол хууль бусаар зарцуулсан хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх эсхүл дараагийн төрийн санхүүжилтээс хасан тооцно.

26.7.Нам нь энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр данстай байхыг хориглоно. Тус хориглолт нь энэ хуулийн 34.4, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлд хамаарахгүй.

26.8.Нам нь энэ хуулийн 26.1-т заасан орлогыг цахим мөнгөн хэрэгсэл /крипто валют, NFT зэрэг/-ээр хүлээн авахыг хориглоно.

27 дугаар зүйл.Төрийн санхүүжилт

27.1.Улсын Их Хурлын сүүлийн ээлжит эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид "нийт сонгогч" гэх/-ийн тоог нэг сарын

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиар үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу хуваарилах замаар төрийн санхүүжилт олгоно.

27.2.Төрийн санхүүжилтийн хэмжээ нь энэ хуулийн 27.1, 27.8-т зааснаас хэтрэхгүй байна.

27.3.Нийт сонгогчийн 2-оос дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно.

27.4.Энэ хуулийн 27.3-д заасан шаардлагыг хангаагүй намд төрийн санхүүжилт олгохыг хориглоно.

27.5.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд дараах томъёогоор төрийн санхүүжилтийг жил бүр олгоно.

$$H = (C1 * T1) + (C2 * T2)$$

27.6.Энэ хуулийн 27.5-д заасан томъёо дахь дараах тэмдэглэгээг доор дурдсан утгаар ойлгоно:

27.6.1.“H” гэж нийт сонгогчийн 2-оос дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг;

27.6.2.“C1” гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог;

27.6.3.“C2” гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог;

27.6.4.“T1” гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг;

27.6.5.“T2” гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг.

27.7.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг

тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.

27.8.Энэ хуулийн 27.6.2-т заасан саналын тоог дараах байдлаар тооцно:

27.8.1.хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоогоор сонгууль явуулбал намын нэрсийн жагсаалтаар авсан хүчинтэй саналын хувь;

27.8.2.нэг мандаттай олонхын тогтолцоогоор сонгууль явуулбал нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын хувь;

27.8.3.олон мандаттай олонхын тогтолцоогоор сонгууль явуулбал нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын нийлбэрийг энэ хуулийн 27.7.2-т заасантай дүйцүүлэн гаргасан саналын хувь;

27.8.4.холимог тогтолцоогоор сонгууль явуулбал энэ хуулийн 27.8.1, 27.8.2, 27.8.3-т заасан аргачлалаар тооцсон нийлбэр саналын хувь.

27.9.Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын энэ хуулийн 36.3.1-36.3.3-д заасан орлогын нийлбэрээс хоёр дахин их эсхүл түүнээс илүү байж болохгүй.

27.10.Хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн нам эвсэл болж сонгуульд оролцсон тохиолдолд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийг эвсэлд олгоно. Эвсэлд олгосон санхүүжилтийг энэ хууль болон эвслийн гэрээгээр хуваарилна.

27.11.Намыг идэвхгүйд тооцсон, татан буулгасан, эсхүл эвсэл тарсан бол энэ тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн нам, эвсэлд олгох төрийн санхүүжилтийг зогсооно.

28 дугаар зүйл.Төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах

28.1.Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд төрийн санхүүжилт авах зорилгоор уул санхүүжилтийн хэмжээг тогтоолгох, санхүүжилт авах тухай хүсэлтээ нам тухайн жилийн өмнөх жилийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн төв байгууллагад гаргана. Энэ хуулийн 28.1-д заасан хугацаанд хүсэлт гаргаагүй бол

сонгуулийн төв байгууллага энэ тухай сануулж, 30 хоногийн дотор хүсэлт гаргах боломж олгоно.

28.2. Намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан энэ хуулийн 28.1-д заасан хүсэлтийг сонгуулийн төв байгууллагаас гаргасан маягтын дагуу гаргана. Энэ маягтад намын шуудангийн хаяг, намын дансны дугаар зэрэг мэдээллийг бичихээр тусгана.

28.3. Намын төв байгууллага нь нийт намыг төлөөлж нэгдсэн хүсэлт гаргана.

28.4. Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн өмнөх онд сонгуулийн төв байгууллага төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоосон шийдвэр гаргасан бол төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд нам шинээр хүсэлт гаргах шаардлагагүй. Төрийн санхүүжилтийн хэмжээнд нөлөөлөх өөрчлөлт гарсан бол сонгуулийн төв байгууллагад даруй мэдэгдэх бөгөөд энэ талаар цаг тухайд нь мэдэгдээгүйн үр дагаврыг нам хариуцна.

28.5. Нам энэ хуулийн 27.5-д заасны дагуу үүссэн эрхээсээ татгалзах эрхтэй бөгөөд ийнхүү татгалзсан тохиолдолд тухайн намд олговол зохих төрийн санхүүжилт улсын төсөвт үлдэнэ.

29 дүгээр зүйл. Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох

29.1. Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 9 дүгээр сарын 15-наас өмнө төрийн санхүүжилт авах эрх бүхий нам бүрд төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн санхүүжилтийн хэмжээг энэ хуульд заасны дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ.

29.2. Энэ хуулийн 29.1-д заасан шийдвэрийн дагуу олгох санхүүжилтийг дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн энэ хуульд өөрөөр заагаагүй бол ээлжит болон ээлжит бус сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан тухайн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл хугацаанд жил бүр 2 удаа олгоно.

29.3. Сонгуулийн төв байгууллага нь намаас энэ хуулийн 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангаж ирүүлсэн тайланг үндэслэн энэ хуулийн 28 дугаар зүйлд заасныг баримтлан төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож олгоно.

29.4. Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланг нягтлан шалгах ажиллагаа явуулж буй бол уул ажиллагаа дууссаны дараа санхүүжилтийн хэмжээг эцэслэн тогтооно.

29.5. Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох үндэс суурь нь төрийн санхүүжилт авах намын эрх үүссэн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө хамгийн сүүлд явагдсан Улсын Их Хурлын сонгуулиар авсан хүчинтэй саналын тоо болон энэ хуулийн 27.5-д заасан бусад үзүүлэлт байна.

29.6. Энэ хуулийн 29.2-т заасан хугацаанд хагас жилийн тайланг ирүүлээгүй бол энэ хуулийн 27.5-д заасны дагуу тухайн намын авсан хүчинтэй саналын тоо (С1)-нд суурилсан төрийн санхүүжилтийн хэсгийг олгохгүй.

29.7. Тайлангийн агуулга алдаа, зөрчилтэй эсэхээс үл хамааран тайлангаа энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан бүтэц, хэлбэрээр 38.12-т заасан аудитын тэмдэглэлийн хамт тогтоосон хугацаанд ирүүлбэл хугацаа баримталсанд тооцно.

29.8. Бусад намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээ, олголт нь тухайн нэг намын үйлдлээс шалтгаалан өөрчлөгдөхгүй.

29.9. Энэ хуулийн 27.8-д дурдсан хязгаарыг тооцон бодоход тайлант жилд авч, тайланд нийтлэгдсэн намын орлогын хэмжээг энэ хуулийн 36.3.1-37.3.3-д үндэслэнэ.

29.10. Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоохдоо эхлээд нам бүрээр энэ хуулийн 29.7-д заасан хязгаарыг, дараа нь энэ хуулийн 27.1-д заасан хязгаарыг баримтална. Төрийн санхүүжилт энэ хуулийн 27.1-д заасан хязгаараас давж хэтрэх тооцоо гарсан бол уул хязгаартай тэнцүү санхүүжилтийг намуудад ногдох хувь хэмжээгээр нь олгоно.

29.11. Төрийн санхүүжилтийг хуваарилахад харгалзан үзэх тухайн намд өгсөн хүчинтэй саналын тоо нь түүнд нөхөн болон дахин сонгуулийн дүн, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу өөрчлөлт орсноос бусад тохиолдолд тухайн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөгдөхгүй.

30 дугаар зүйл.Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг

30.1.Нийт сонгогчийн 1 хувиас доошгүй санал авсан нам нь сонгуулийн бус жилд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг дараах хэлбэрээр авах эрхтэй:

30.1.1.намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулахад төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд 1 удаа үнэ төлбөргүй ашиглах;

30.1.2.хуваарийн дагуу намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг үндэсний олон нийтийн радио, телевизээр жилд гучин минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэг авах тухай намын хүсэлтийг үндэслэн 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллага шийдвэрлүүлнэ.

30.3.Энэ хуулийн 30.1.1-д заасан байгууллага уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах, энэ хуулийн 30.1.2-д заасны дагуу Үндэсний олон нийтийн радио, телевиз үнэ төлбөргүй нэвтрүүлэх үүрэгтэй.

30.4.Энэ хуулийн 30.1.2-г заасан нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд төрөөс үзүүлсэн шууд бус дэмжлэгийг дурдана.

30.5.Сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс санал хураалтын дүн гарах хүртэл хугацаанд энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэгийг намд үзүүлэхгүй.

31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт

31.1.Намд олгох төрийн санхүүжилт болон төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгт шаардагдах зардлыг жил бүр сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлуулна.

31.2.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох

бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллага намд олгох төрийн санхүүжилт болон төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг зөв тогтоож олгосон эсэх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.

32 дугаар зүйл.Гишүүний татвар

32.1.Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно.

32.2.Гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байна.

32.3.Сонгуульт гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

32.4.Гишүүний татварыг тухайн намын гишүүн зөвхөн өөрийн орлогоос төлнө.

32.5.Намын гишүүн нь бусад гишүүний өмнөөс гишүүний татвар төлөхийг хориглоно.

32.6.Нам өөрийн дүрэм, журмаар намын гишүүний татварыг хөнгөлөх, чөлөөлөхөөр зохицуулж болно.

32.7.Хуульд өөрөөр заагаагүй бол намын гүйцэтгэх төв байгууллага нь гишүүний татвар төлсөн баримтыг арван жилийн хугацаанд архивлан хадгална.

32.8.Намын гишүүнээс энэ хуулийн 32.2, 32.3-т заасны дагуу төлөх татвар, намд өгөх бусад аливаа мөнгийг хандив гэж үзэх бөгөөд тэдгээрийн нийлбэр нь энэ хуулийн 33.8-д заасан хэмжээнээс илүүгүй байна. Бүх төрлийн гэнэтийн зардлыг гишүүдэд ногдуулан хуваарилах, мөнгө цуглуулах, мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эд хөрөнгө намд өгөхийг хандивт тооцно.

33 дугаар зүйл.Хандив

33.1.Хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна.

33.2.Иргэний болон хуулийн этгээдийн мөнгөн хандивыг зөвхөн намын дансаар хүлээн авах бөгөөд бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно. Гишүүний татвар болон хандивыг тооцооны нэг дансанд байршуулна.

33.3.Дараах зүйл нь үнэ төлбөргүйгээр эсхүл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хийгдэж буй тохиолдолд мөнгөн бус хандивт хамаарна:

33.3.1.хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялгийг ашиглуулах, эзэмшүүлэх;

33.3.2.үйлчилгээ үзүүлэх;

33.3.3.төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх;

33.3.4.арга хэмжээний зардлыг төлөх;

33.3.5.ивээн тэтгэх.

33.4.Хандивыг мөнгөн бус хэлбэрээр авах тохиолдолд түүнийг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн үнэлэн бүртгэж, мөнгөн дүнгээр илэрхийлэн санхүүгийн тайланд тусгана.

33.5.Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.

33.6.Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээс нэг жилийн хугацаанд нэг намд өгөх хандив нь энэ хуулийн 33.8, 33.9-т заасан хэмжээнээс илүүгүй байна. Намд өгсөн хандивын хэмжээг уг нам, түүний салбар болон бүтцийн нэгжид өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.7.Нэг жилд нэг иргэнээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван хоёр дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.8.Нэг жилд нэг хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.9.Хуулийн этгээдийн намд өгсөн хандивын хэмжээг уг хуулийн этгээд, хуулийн этгээдийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрын өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно. Намд өгсөн хандивын хэмжээг мөнгөн болон мөнгөн бус хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.10.Хандивлагч намын салбар болон бүтцийн нэгжид нэр заан өгсөн хандивыг тухайн зориулалтын дагуу захиран зарцуулна.

33.11.Намын харьяа байгууллага нь энэ хуулийн 34.6, 34.7-д хориглосон этгээдээс хандив авахыг хориглоно.

33.12.Нэг хуулийн этгээд эсхүл иргэнээс намд болон тухайн намын харьяа байгууллагад өгөх нийт хандив нь энэ хуулийн 33.7, 33.8-д зааснаас илүүгүй байна.

33.13.Намын харьяа байгууллагад өгөх байгууллага нь санхүүгийн тайлангаа энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан шаардлагын дагуу гаргаж тухайн намд болон сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

34 дүгээр зүйл.Хандивтай холбогдуулан хүлээх үүрэг, хориглох зүйл

34.1.Нам дараах хандив өгсөн иргэний овог, нэр эсхүл хуулийн этгээдийн нэр, хандивын хэмжээ, хандивыг хүлээн авсан огноог цахим хуудастаа хайлт хийх боломжтой нээлттэй өгөгдлийн санд улирал татам байршуулж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх бөгөөд уул мэдээллийг намын санхүүгийн тайланд тусгайлан заана.

34.1.1.нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх эсхүл түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн;

34.1.2.нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх эсхүл түүнээс дээш төгрөгийн үнийн дүнтэй мөнгөн бус хандив.

34.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 34.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас

хойш ажлын таван өдрийн дотор цахим хуудаастаа нийтэлж, ил тод, нээлттэй байлгана. Иргэн, хуулийн этгээд энэ хуульд тусгасан хандивын дээд хэмжээнд багтаан нэгээс дээш удаа хандив өгсөн бол хандивын дүнг өмнөх хандивын дүн, хүлээн авсан огнооны хамт мэдээлнэ.

34.3.Нам энэ хуулийн 34.1-д заасан мэдээллийг нээлттэй өгөгдлийн санд улирал тутамд байршуулаагүй эсхүл сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй бол тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг олгохгүй.

34.4.Нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс бага хандивыг намын санхүүгийн тайланд тусгана.

34.5.Нам хандивтай холбогдуулан дараах үүрэг хүлээнэ:

34.5.1.хандивлагч хандив өгөх эрхтэй эсэхийг хуулийн дагуу тодорхойлох;

34.5.2.хандивлагчийн нэр, хаягийн талаар бүртгэл хөтлөх;

34.5.3.энэ хуулийн 34.6, 34.7-д хориглосон этгээдээс хандив өгсөн бол хандивыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад энэ тухай мэдэгдэж, хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх;

34.5.4.нэр хаяг нь тодорхойгүй, буцаах боломжгүй хандивыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад мэдэгдэж, сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх;

34.5.5.хандив болон хандивлагчийн мэдээллийг санхүүгийн тайланд тусгаж, сонгуулийн төв байгууллагад мэдэгдэх, сонгуулийн төв байгууллагын шаардсан нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгөх;

34.5.6.энэ хуульд заасан бусад.

34.6.Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно:

	<p>34.6.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүн;</p> <p>34.6.2.гадаад улс буюу гадаад улсын төрийн байгууллага, нам, хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж;</p> <p>34.6.3.төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага;</p> <p>34.6.4.үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо;</p> <p>34.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, тэдгээрийн захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, бусад удирдах албан тушаалтан;</p> <p>34.6.6.арван найман нас хүрээгүй Монгол Улсын иргэн;</p> <p>34.6.7.Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг, намын бодлогын судалгааны байгууллага, намын харьяа байгууллага;</p> <p>34.6.8.байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд;</p> <p>34.6.9.тодорхой нэр, хаяггүй этгээд эсхүл нэр нь тодорхойгүй гуравдагч этгээдийн хандивыг дамжуулж буй нь илэрхий этгээд;</p> <p>34.6.10.өөртөө эсхүл бусдад давуу байдал бий болгох зорилгоор хандив өгч буй этгээд;</p> <p>34.6.11.бусад иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс мөнгөн болон мөнгөн бус хандивыг намд өгч буй иргэн, хуулийн этгээд;</p> <p>34.6.12.дампуурсан хуулийн этгээд;</p> <p>34.6.13.шүүхээр тогтоогдсон болон татвар, нийгмийн даатгалын хугацаа хэтэрсэн өр, төлбөртэй болох нь илэрхий хуулийн этгээд;</p> <p>34.6.14.хуулиар хориглосон бусад этгээд.</p>
--	--

	<p>34.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцож гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд тухайн гэрээний хугацаанд эсхүл уул гэрээ дуусгавар болсноос хойш 4 жилийн хугацаанд намд хандив өгөхийг, эсхүл нам уул хугацаанд эдгээр иргэн, хуулийн этгээдээс хандив авахыг хориглоно.</p> <p>34.8.Иргэн, хуулийн этгээд намд хандив өгсөн өдрөөс хойш 4 жилийн хугацаанд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох, гэрээ байгуулахыг хориглоно.</p> <p>34.9.Иргэдийн улс төрийн боловсрол, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дэмжих эсхүл тухайн намыг ардчилсан зарчмын дагуу бэхжүүлэх зорилгоор хамтарч ажиллах хүрээнд олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтран зохион байгуулах арга хэмжээ, хэрэгжүүлэх төслийн санхүүжилт энэ хуулийн 34.6.2-т хамаарахгүй.</p> <p>34.10.Хандивлагч өөртөө, бусдад давуу байдал бий болгох зорилгоор хандив өгөхийг хориглоно.</p> <p>34.11.Намд хандив өгснийхөө төлөө хандивлагч нь өөртөө болон бусдад аливаа давуу байдал олгохыг болон намын дотоод асуудлыг ардчилсан бус зарчмаар шийдвэрлэхийг шаардах, шахалт үзүүлэхийг хориглоно.</p> <p>34.12.Хандивлагч нь намд хандив өгөхдөө бусад этгээдийн нэр, хаяг, мэдээллийг ашиглахыг хориглоно.</p> <p>34.13.Иргэн, хуулийн этгээд нь бусад иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс мөнгөн болон мөнгөн бус хандивыг намд өгөхийг хориглоно.</p>
--	--

		<p>35 дугаар зүйл. Намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого, зээл</p> <p>35.1. Нам нь тухайн намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар орлого олж болно.</p> <p>35.2. Энэ хуулийн 35.1-д зааснаас өөр аж ахуйн үйл ажиллагаанаас орлого олохыг хориглоно.</p> <p>35.3. Энэ хуулийн 35.1-д заасан худалдан борлуулах үнэ зах зээлийн дундаж ханшаас их байвал түүнийг намд өгсөн хандивт тооцох бөгөөд түүний хэмжээ энэ хуулийн 35.8, 35.9-т зааснаас илүүгүй байна.</p> <p>35.4. Намын нэг жилд өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого нь тухайн намд олгосон төрийн санхүүжилтийн 25 хувиас ихгүй байна.</p> <p>35.5. Нам нь зээлийн гэрээний үндсэн дээр зээл авч болно.</p> <p>35.6. Банк намд олгосон зээлийг чөлөөлөхийг хориглоно.</p> <p>35.7. Зах зээлийн дундаж хүүгээс бага хүүгээр, хүүгүйгээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авсан тохиолдолд тухайн зээлийг намд өгсөн хандивт тооцно.</p> <p>35.8. Зээлийг гуравдагч этгээд төлсөн тохиолдолд тухайн төлбөрийг хандивт тооцно.</p>
--	--	---

2.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов.

2.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцсон. /Хуулийн төсөл 7 бүлэг, 45 зүйлтэй./

2.5. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслөөр нам болон төрийн байгууллага, сонгуулийн төв байгууллага, улсын дээд шүүхэд чиг үүрэг нэмэгдэж байгаа бөгөөд нам болон төрийн байгууллага өөрийн дотоод зохион байгуулалтын хувьд хэрэгжүүлэх боломжтой юм. Тухайлбал

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улс төрийн намын тухай хууль	Хуулийн төсөлд тусгагдсан байдал
Намын чиг үүрэг	
Ийм чиг үүрэг байхгүй	<p>9 дүгээр зүйл. Намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах</p> <p>9.1. Хуульд өөрөөр заагаагүй бол намын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулна.</p> <p>9.2. Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, бусад журам, санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг ил тод, нээлттэй байлгаж, нийтэд тогтмол мэдээлэх, мэдээлэл авах боломжоор хангана.</p> <p>9.3. Нам өөрийн бүх шатны байгууллагын хуралдаан, санал хураалт, сургалт, зөвлөгөөн, гишүүн элсүүлэх, гишүүний татвар хураах, хандив цуглуулах болон бусад ажиллагаа, нийгэмд болон гишүүдэд чиглэсэн арга хэмжээг цахимаар явуулж болно. Ингэхдээ сонгуулийн төв байгууллагаар баталгаажсан программ хангамжийг ашиглана.</p> <p>9.4. Цахим хуралдаан, санал хураалтын үр дүнд гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно. Нам цахим хуралдаан, санал хураалтыг зохион байгуулахдаа цахим системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах боломжит арга хэмжээг авах бөгөөд нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд түүний нууцлалыг алдагдуулахгүй.</p> <p>9.5. Нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягтай</p>

бол тэдгээрийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.

9.6. Нам цахим хуудастаа дараах баримт бичиг, мэдээллийг ил тод байршуулж, тухай бүр шинэчилнэ:

9.6.1. намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;

9.6.2. намын дүрэм;

9.6.3. намын хөтөлбөр;

9.6.4. намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа хаяг;

9.6.5. намын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

9.6.6. намын удирдах дээд байгууллага эсхүл төлөөллийн төв байгууллагатай бол төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын төв байгууллагын дарга, гишүүний овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

9.6.7. намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

9.6.8. намын гишүүний тоо;

9.6.9. намын санхүүгийн тайлан;

9.6.10. намын үйл ажиллагааны товч тайлан;

9.6.11. намын аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх салбар нэгжийн даргын овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

9.6.12. намын бүтэц, зохион байгуулалт;

9.6.13. намын үйл ажиллагааны мэдээлэл;

9.6.14. бусад мэдээлэл.

	<p>9.7. Намын дансанд хүлээж авсан хандивын болон бусад мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу намын цахим хуудаст байршуулна. Хандивлагчдыг мэдээлэхдээ хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг ил тод мэдээлнэ.</p> <p>9.8. Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан цахим хуудастаа байршуулж олон нийт, гишүүд, дэмжигчдэдээ нээлттэй танилцуулж байна.</p> <p>9.9. Нам энэ хуулийн 9.6.1-9.6.7-д заасан баримт бичиг, мэдээлэлд өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.</p> <p>9.10. Сонгуулийн төв байгууллагын цахим хуудаст намын цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг, энэ хуулийн 9.6.1-9.6.7-д заасан намын баримт бичиг, мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчилнэ.</p>
Сонгуулийн төв байгууллага, Улсын дээд шүүх	
<p>9 дүгээр зүйл. Намыг улсын бүртгэлд бүртгэх Хэвлэх</p> <p>9.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14.1-д заасны дагуу тухайн нам үүсгэн байгуулагдсан өдрөөсөө хойш ажлын 10 хоногт багтаан бүртгэх байгууллагаас баталсан маягтын дагуу бүртгүүлэх өргөдлөө Улсын дээд шүүхэд гаргана.</p> <p><u>/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p> <p><u>/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p> <p>9.2. Бүртгүүлэх өргөдөлд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14.2-т заасан мэдээллийг тусгана.</p> <p><u>/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p> <p><u>/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p>	<p>12 дугаар зүйл. Намыг бүртгүүлэх өргөдөл</p> <p>12.1. Энэ хуулийн 11.3.4-д заасан намын даргаар сонгогдсон гишүүн эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нам үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн хамт сонгуулийн төв байгууллагад бичгээр хүргүүлнэ.</p> <p>12.2. Намыг бүртгүүлэх өргөдлийг сонгуулийн төв байгууллагын баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд өргөдөл гаргагч гарын үсэг зурна:</p> <p>12.2.1. өргөдөл гаргасан он, сар, өдөр;</p> <p>12.2.2. намын нэр;</p>

<p>9.3.Нам нь Улсын дээд шүүхэд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ: <u>/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p> <p><u>/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p> <p>9.3.1.намыг бүртгүүлэхийг хүссэн намын даргын гарын үсэг бүхий өргөдөл; 9.3.2.намын нэр, бэлгэдэл, далбаа; 9.3.3.намын дүрэм; 9.3.4.намын мөрийн хөтөлбөр; 9.3.5.намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг; 9.3.6.засаг захиргааны нэгж буюу аймгуудын гуравны нэгд намын байгууллага байгуулсан тухай шийдвэр, тэдгээрийн оршин байгаа хууль ёсны хаяг; <u>/Энэ заалтыг 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u></p> <p>9.3.7.намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/; <u>/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p> <p>9.3.8.намын санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий удирдах ажилтан /менежер, ерөнхий нягтлан бодох/-ны бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын болон гэрийн хаяг, гарын үсэг/</p> <p><u>/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p> <p>9.3.9.намын хөрөнгийн мэдээ; 9.3.10.хуульд заасан бусад баримт бичиг.</p> <p>9.4.Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш энэ хуулийн 6; 9.2- 9.3-т заасан зүйлийг нягтлан үзэж, ажлын 30 хоногийн</p>	<p>12.2.3.намын гүйцэтгэх төв байгууллагын хаяг;</p> <p>12.2.4.намын үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;</p> <p>12.2.5.өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл.</p> <p>12.3.Намыг бүртгүүлэх өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:</p> <p>12.3.1.нам үүсгэн байгуулах тухай шийдвэр, уг шийдвэрт хуралдаан даргалагч эсхүл тэргүүлэгчид гарын үсэг зурсан байна;</p> <p>12.3.2.намын бүтэн болон товчилсон нэрийн бичвэр, намын нэр, бэлгэдэл, далбааны зургийг тайлбарын хамт;</p> <p>12.3.3.намын дүрэм;</p> <p>12.3.4.намын хөтөлбөр;</p> <p>12.3.5.намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа хаягийн нотлох баримт;</p> <p>12.3.6.намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг/;</p> <p>12.3.7.намын санхүүгийн асуудал хариуцсан ажилтны бүртгэл /овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг, иргэний үнэмлэхийн хуулбар/;</p> <p>12.3.8.намын хөрөнгийн жагсаалт, намд өгсөн хандивын жагсаалт, намыг үүсгэн байгуулахтай холбогдон гарсан зардлын эх үүсвэр зэргийг тусгасан намын хөрөнгийн мэдээ;</p> <p>12.3.9.нам үүсгэн байгуулах хурлын тов, байршлыг энэ хуулийн 11.2-т заасны дагуу мэдэгдэж, зарласан тухай баримт;</p>
---	--

дотор тухайн намыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох бөгөөд энэ тухай нийтэд мэдээлнэ.

9.5.Улсын дээд шүүх намыг бүртгэхдээ энэ хуулийн 9.3-т болон холбогдох хуульд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

9.6.Хуульд заасан шаардлагыг хангаж улсын бүртгэлд бүртгүүлснээр нам үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулах эрхтэй.

12.3.10.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

12.4.Энэ хуулийн 12.3.8-д заасан намын хөрөнгийн мэдээнд намыг бүртгүүлэх өргөдөл гаргахаас өмнө тухайн намын аль нэг үүсгэн байгуулагчийн нэр дээр банкны түр данс нээж намын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, гишүүний татвар, хандив, намыг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг тусгаж тайлагнана.

12.5.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 12.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийг хамт сонгуулийн төв байгууллагад хүргүүлж болно.

13 дугаар зүйл.Намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг нягтлан шалгах

13.1.Сонгуулийн төв байгууллага нь намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн өргөдөл, дагалдах баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

13.2.Сонгуулийн төв байгууллага нь өргөдөл, бичиг баримтад дараах зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уул зөрчлийг арилгаж, нэмэлт мэдээллийг ирүүлэх тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

13.2.1.энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу;

13.2.2.намын дүрэм нь энэ хуулийн 15.2-т заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй;

13.2.3.гишүүдийн тоо нь энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй, бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай эсхүл өөр хүн төлөөлсөн;

13.2.4.намын бүтэн нэр, товчилсон нэр, бэлгэдэл, далбаа энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй.

	<p>13.3.Сонгуулийн төв байгууллага намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, нягтлан шалгахдаа энэ хуулийн 12.3-т болон хуульд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.</p> <p>13.4.Сонгуулийн төв байгууллага намыг бүртгүүлэх өргөдөл, холбогдох баримтыг хүлээн авч, энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаанд нягтлан шалгаж дуусгаснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх намыг бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.</p> <p>13.5.Намын бүртгэлийн жагсаалт, бүртгэлийн хувийн хэрэг, холбогдох мэдээллийг Сонгуулийн төв байгууллага эрхлэн хариуцна.</p> <p>13.6.Нам хуулийн этгээд болох хувьдаа оршин байх албан ёсны хаяг, хөрөнгө түүний өөрчлөлттэй холбоотой бүртгэлийг холбогдох шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор Сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.</p>
--	---

Иймд хуульд заасан чиг үүргийг Улсн дээд шүүх болон Сонгуулийн ерөнхий хороо одоо байгаа бүтэц төсвийн хүрээнд нэмэлт зардалгүйгээр хариуцах боломжтой.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох заалтууд	Зорилгод дүн шинжилгээ хийх.

2	Ойлгомжтой байдал	Хуулийн бүхэлдээ төсөл	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн бүхэлдээ төсөл	Хуулийн төслийн уялдаа холбоог хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хуулийн зорилт, зохицуулах харилцааг нарийвчлан тогтоох, алдаа хийдэлгүйгээр зөв тодорхойлж зохицуулах хүрээнд бүхэлд нь дүн шинжилгээ хийсэн байдал

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 7 бүлэгтэй байна.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, улс төрийн намын эрх, үүрэг, намд эвлэлдэн нэгдэх иргэний эрх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан байх, нам цахим орчинд үйл ажиллагаа явуулах, намын үйл ажиллагаанд хориглох зүйлийг;

Хуулийн төслийн зорилтод Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам байгуулах, намын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг;

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт улс төрийн намыг үүсгэх байгуулах, бүртгүүлэх, сонгуулийн төв байгууллагын уламжилсанаар Улсын дээд шүүх улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах талаар;

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт намын бүтэц зохион байгуулалтыг дэлхийн чиг хандлага, дотоод ардчилал, хүний эрх, жендерийн тэгш эрхийг хангах зарчмуудын дагуу уян хатан бүтэцтэй, хүний эрхийг дээдэлсэн, гишүүдийн оролцоо, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад үе, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн оролцоог дэмжсэн, бодлогын нам болж ажиллах талаар;

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт намын үйл ажиллагааг идэвхгүйд тооцох, өөрчлөн байгуулах, намын үйл ажиллагааг зогсоох, намыг тараах асуудлыг;

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт улс төрийн намуудад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл шалгуур, түүний мөнгөн болон мөнгөн бус хэмжээ,

хуваарилалт, шилэн санхүүжилтийн зарчим, зарцуулалтын зориулалт гишүүний татвар, хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлогыг нарийвчлан тусгахаар;

Хуулийн төслийн зургадугаар бүлэгт намууд санхүүгийн тайлан гаргах, тайланг мэдүүлэх, аудит хийлгэх, сонгуулийн төв байгууллага тайланг нягтлан шалгах, нийтэд мэдээлэх, улмаар намын тайлантай холбоотой алдаа зөрчилд хариуцлага тооцох, 7 дугаар бүлэгт Улсын Их Хуралд суудал бүхий намуудын эрх, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтын талаар тусгасан байна.

Намуудын төлөвшилтийг дэмжсэн, институцыг хангасан, улс төрийн намуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, цөөнхийн явцуу бүлэглэл бус, улс орны нийтлэг ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, нийгмийн өргөн давхаргын төлөөлөл бүхий бодлогын нам болж, намд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх, төрийн бодлого, шийдвэр гаргах явцад ард иргэдийн шууд оролцоо нэмэгдүүлэх, улс төрийн намуудад өрсөлдөөний ижил нөхцөл бий болгож, авлигын түвшин бууруулах зорилгын хүрээнд Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн намыг үүсгэн байгуулах, намын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоох суурь зохицуулалт, суурь үзэл баримтлалд нь нийцүүлэн хуулийн төслийн зорилтыг хангах хүрээнд тодорхой зохицуулсан байна.

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төсөл нь хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон байна.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

	Шалгах асуултууд	
1	Төслийн зохицуулалт тухайн тогтоолын зорилттой нийцэж байгаа эсэх?	Нийцэж байна.
2	Хуулийн төслийн хууль тогтоомж гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх?	нийцэж байгаа
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх?	нийцэж байгаа
4	Хуулийн төслийн зүйл заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх?	Зөрчилдсөн зүйл заалт байхгүй.

5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх?	Бусад хуулийн зүйл заалттай давхардсан зүйл байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх?	Нам, сонгуулийн төв байгууллага, Улсын дээд шүү
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх?	Орхигдуулсан зохицуулалт байхгүй, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахыг даалгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх?	Чиг үүрэг давхардуулсан зүйл байхгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Боломжгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Намын гишүүний татварыг зохих журмын дагуу
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх?	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал үүсгэхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх?	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй. эерэг үр дагавар бүхий зохицуулалттай.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх?	байхгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?	Байхгүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?	Байхгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх?	Тодорхой тусгасан.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлагыг хангасан. Уялдсан байгаа.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тухайн асуудлыг зохицуулах нийгмийн харилцааг бүрэн тусгаж өгөөгүй, зарим асуудлыг засгийн газар үүрэг өгөх байдлаар шилжүүлж зохицуулсан байна.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Боловсруулсан

29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

Тав.Үр дүн, зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд сонгон авсан практикт хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, зардлын шалгуур үзүүлэлтээр хуулийн төсөлд тусгагдсан агуулгаар үр нөлөө гарна гэж үнэлсэн.

Хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд төсөл нь практикт хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөхүйц, нэмэлт зардал гарахгүй үр өгөөжтэй байдлаар боловсруулагдсан байна.

---oOo---

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

2023 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	5
Нэг. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох	11
Хоёр. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох	16
Гурав. Гарах зардлыг урьдчилан тооцох	23
Дөрөв. Үр дүнг тооцох	24
Тав. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	26
ИРГЭНД УЧРАХ ЗАРДЛЫН ТООЦОО.....	28
Нэг. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох	28
Хоёр. Зардал тооцох	28
Гурав. Тоон үзүүлэлтийг тооцох	30
Дөрөв. Зардлын дүнг тооцож гаргах	30
Тав. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	31
Зургаа. Нэмэлт зардлыг тооцох	31
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	32

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэх хүрээнд иргэн, төрийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдуулан энэхүү төсөлд тусгасан үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай гаргах зардлыг тооцож, тэдгээрт ногдох зардал, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, зохицуулалтын боломжит хувилбарыг боловсруулахад энэхүү зардлын тайлангийн гол зорилго нь оршино.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1-д "Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана" гэж, 2-т "Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна" гэж, 3-т "Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно" гэж нэмэлт оруулсан.

Түүнчлэн "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 1.4-т Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлтэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд

"Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах; намын үйл ажиллагаа, дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах; Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх; төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох." чиглэл баримтална гэж заасан.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг Конвенцод 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Тус Конвенцын 7 дугаар зүйлийн 3-т "Сонгогддог төрийн албан тушаалтны нэрийг дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор оролцогч улс бүр энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд

нийцүүлэн хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ” гэж тунхагласныг Монгол Улс гишүүн орны хувьд дагаж мөрдөх, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээж байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт “Улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, санхүүжилтийг шилэн болгох улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиуд санаачилна.” гэж заасан.

Монгол Улс 1990 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиа баталж, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч, улс төрийн ардчилсан дэглэмд шилжсэнээс хойш эдүгээ 40 гаруй улс төрийн нам байгуулагдан үйл ажиллагаагаа эрхлэн явуулж иржээ. Эдүгээ Монгол Улсын Дээд шүүхэд албан ёсоор 35 улс төрийн нам бүртгэлтэй байна.

Иймд намуудын төлөвшилтийг дэмжсэн, институтийг хангасан, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлсэн улс төрийн намын хууль зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх хуулийн төсөлтэй холбоотойгоор хэрэгжилтийн зардал гарах тул холбогдох тооцооллыг гүйцэтгэсэн болно. Ингэхдээ зардлыг тооцоог Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэгт тусгаснаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д дурдсаны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй гарах зардал, нөлөөллийг эрх зүйн зохицуулалтад хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардал тус бүрээр тооцон боловсруулсан болно.

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу тооцов.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1-д “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана” гэж, 2-т “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна” гэж, 3-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэж нэмэлт оруулсан.

Түүнчлэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 1.4-т Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлтэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах; намын үйл ажиллагаа, дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах; Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх; төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох.” чиглэл баримтална гэж заасан.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг Конвенцод 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Тус Конвенцын 7 дугаар зүйлийн 3-т “Сонгогддог төрийн албан тушаалтны нэрийг дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор оролцогч улс бүр энэхүү конвенцын зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ” гэж тунхагласныг Монгол Улс гишүүн орны хувьд дагаж мөрдөх, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээж байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт “Улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга

хариуцлагыг дээшлүүлж, санхүүжилтийг шилэн болгох улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиуд санаачилна.” гэж заасан.

Монгол Улс 1990 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиа баталж, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч, улс төрийн ардчилсан дэглэмд шилжсэнээс хойш эдүгээ 40 гаруй улс төрийн нам байгуулагдан үйл ажиллагаагаа эрхлэн явуулж иржээ. Эдүгээ Монгол Улсын Дээд шүүхэд албан ёсоор 35 улс төрийн нам бүртгэлтэй байна.

Улс төрийн намын төлөвшил сул, үйл ажиллагаа, санхүүжилт нь ил тод бус байгаа нь Үндсэн хуулиар бий болгосон төрийн байгуулал, түүний тогтолцоо, институтийн чадавх, ардчиллын бэхжилтэд сөргөөр нөлөөлөх болов. Монгол Улсын төрийн байгуулал институтүүдийг бүрдүүлэхэд чухал үүрэг бүхий улс төрийн намуудын чиг үүрэг, дотоод зохион байгуулалтыг ардчилсан зарчимд нийцүүлж, нийт үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг ил тод, нийтэд нээлттэй болгох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Улс төрийн намын үйл ажиллагаа, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад өөрийнх нь хяналтын нэгж буюу дотоод хяналтаас өөр хяналт тавих хөндлөнгийн бүтэц байхгүй, дотоодын хяналтын нэгж нь үр дүнтэй байж чадахгүй байгаагаас санхүүгийн тайландаа аудит хийлгэж, олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлдэггүй байна.

Иймд Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам /цаашид “нам” гэх/ үүсгэн байгуулах, намын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоох харилцааг зохицуулахаар боловсруулсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн задал үүсгэх холбоотой зохицуулалтуудыг судлав.

9 дүгээр зүйл. Намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах

9.1. Хуульд өөрөөр заагаагүй бол намын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулна.

9.2. Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, бусад журам, санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг ил тод, нээлттэй байлгаж, нийтэд тогтмол мэдээлэх, мэдээлэл авах боломжоор хангана.

9.3. Нам өөрийн бүх шатны байгууллагын хуралдаан, санал хураалт, сургалт, зөвлөгөөн, гишүүн элсүүлэх, гишүүний татвар хураах, хандив цуглуулах болон бусад ажиллагаа, нийгэмд болон гишүүдэд чиглэсэн арга хэмжээг цахимаар явуулж болно. Ингэхдээ сонгуулийн төв байгууллагаар баталгаажсан программ хангамжийг ашиглана.

9.4.Цахим хуралдаан, санал хураалтын үр дүнд гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно. Нам цахим хуралдаан, санал хураалтыг зохион байгуулахдаа цахим системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах боломжит арга хэмжээг авах бөгөөд нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд түүний нууцлалыг алдагдуулахгүй.

9.5.Нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягтай бол тэдгээрийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.

9.6.Нам цахим хуудастаа дараах баримт бичиг, мэдээллийг ил тод байршуулж, тухай бүр шинэчилнэ:

9.6.1.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;

9.6.2.намын дүрэм;

9.6.3.намын хөтөлбөр;

9.6.4.намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа хаяг;

9.6.5.намын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

9.6.6.намын удирдах дээд байгууллага эсхүл төлөөллийн төв байгууллагатай бол төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын төв байгууллагын дарга, гишүүний овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

9.6.7.намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

9.6.8.намын гишүүний тоо;

9.6.9.намын санхүүгийн тайлан;

9.6.10.намын үйл ажиллагааны товч тайлан;

9.6.11.намын аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх салбар нэгжийн даргын овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

9.6.12.намын бүтэц, зохион байгуулалт;

9.6.13.намын үйл ажиллагааны мэдээлэл;

9.6.14.бусад мэдээлэл.

9.7.Намын дансанд хүлээж авсан хандивын болон бусад мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу намын цахим хуудаст байршуулна. Хандивлагчдыг мэдээлэхдээ хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг ил тод мэдээлнэ.

9.8.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан цахим хуудастаа байршуулж олон нийт, гишүүд, дэмжигчдэдээ нээлттэй танилцуулж байна.

9.9.Нам энэ хуулийн 9.6.1-9.6.7-д заасан баримт бичиг, мэдээлэлд өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

9.10.Сонгуулийн төв байгууллагын цахим хуудаст намын цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг, энэ хуулийн 9.6.1-9.6.7-д заасан намын баримт бичиг, мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчилнэ.

12 дугаар зүйл.Намыг бүртгүүлэх өргөдөл

12.1.Энэ хуулийн 11.3.4-д заасан намын даргаар сонгогдсон гишүүн эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нам үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн хамт сонгуулийн төв байгууллагад бичгээр хүргүүлнэ.

12.2.Намыг бүртгүүлэх өргөдлийг сонгуулийн төв байгууллагын баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд өргөдөл гаргагч гарын үсэг зурна:

12.2.1.өргөдөл гаргасан он, сар, өдөр;

12.2.2.намын нэр;

12.2.3.намын гүйцэтгэх төв байгууллагын хаяг;

12.2.4.намын үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;

12.2.5.өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл.

12.3.Намыг бүртгүүлэх өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

12.3.1.нам үүсгэн байгуулах тухай шийдвэр, уг шийдвэрт хуралдаан даргалагч эсхүл тэргүүлэгчид гарын үсэг зурсан байна;

12.3.2.намын бүтэн болон товчилсон нэрийн бичвэр, намын нэр, бэлгэдэл, далбааны зургийг тайлбарын хамт;

12.3.3.намын дүрэм;

12.3.4.намын хөтөлбөр;

12.3.5.намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа хаягийн нотлох баримт;

12.3.6.намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг/;

12.3.7.намын санхүүгийн асуудал хариуцсан ажилтны бүртгэл /овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг, иргэний үнэмлэхийн хуулбар/;

12.3.8.намын хөрөнгийн жагсаалт, намд өгсөн хандивын жагсаалт, намыг үүсгэн байгуулахтай холбогдон гарсан зардлын эх үүсвэр зэргийг тусгасан намын хөрөнгийн мэдээ;

12.3.9.нам үүсгэн байгуулах хурлын тов, байршлыг энэ хуулийн 11.2-т заасны дагуу мэдэгдэж, зарласан тухай баримт;

12.3.10.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

12.4.Энэ хуулийн 12.3.8-д заасан намын хөрөнгийн мэдээнд намыг бүртгүүлэх өргөдөл гаргахаас өмнө тухайн намын аль нэг үүсгэн байгуулагчийн нэр дээр банкны түр данс нээж намын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, гишүүний татвар, хандив, намыг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг тусгаж тайлагнана.

12.5.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 12.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийг хамт сонгуулийн төв байгууллагад хүргүүлж болно.

13 дугаар зүйл.Намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг нягтлан шалгах

13.1. Сонгуулийн төв байгууллага нь намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн өргөдөл, дагалдах баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

13.2. Сонгуулийн төв байгууллага нь өргөдөл, бичиг баримтад дараах зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уул зөрчлийг арилгаж, нэмэлт мэдээллийг ирүүлэх тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

13.2.1. энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу;

13.2.2. намын дүрэм нь энэ хуулийн 15.2-т заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй;

13.2.3. гишүүдийн тоо нь энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй, бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай эсхүл өөр хүн төлөөлсөн;

13.2.4. намын бүтэн нэр, товчилсон нэр, бэлгэдэл, далбаа энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй.

13.3. Сонгуулийн төв байгууллага намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, нягтлан шалгахдаа энэ хуулийн 12.3-т болон хуульд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

13.4. Сонгуулийн төв байгууллага намыг бүртгүүлэх өргөдөл, холбогдох баримтыг хүлээн авч, энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаанд нягтлан шалгаж дуусгаснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх намыг бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

13.5. Намын бүртгэлийн жагсаалт, бүртгэлийн хувийн хэрэг, холбогдох мэдээллийг Сонгуулийн төв байгууллага эрхлэн хариуцна.

13.6. Нам хуулийн этгээд болох хувьдаа оршин байх албан ёсны хаяг, хөрөнгө түүний өөрчлөлттэй холбоотой бүртгэлийг холбогдох шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор Сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл. Намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах

14.1. Улсын дээд шүүх нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 13.4-д зааснаар ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тухайн намыг намын бүртгэлд бүртгэх эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж, ажлын гуч хоногийн дотор өргөдөл гаргагч, сонгуулийн төв байгууллагад бичгээр болон цахимаар хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

14.2. Улсын дээд шүүх энэ хуулийн 14.4-д зааснаас бусад тохиолдолд намыг улс төрийн намын бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргана.

14.3. Намыг улс төрийн намын бүртгэлд бүртгэх шийдвэрийг нийтэд мэдээлснээс хойш ажлын таван өдрийн дотор сонгуулийн төв байгууллага гэрчилгээ олгоно. Сонгуулийн төв байгууллага тухайн намын зорилго, үнэт зүйл, үзэл баримтлалын товч, гүйцэтгэх төв байгууллага, албан тушаалтны мэдээлэл, намын оршин

байгаа хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаягийн талаарх мэдээлэл багтаасан танилцуулгыг нийтэд ил тод байршуулна.

14.4.Улсын дээд шүүх намыг дараах үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

14.4.1.намын дүрэм, хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан;

14.4.2.энэ хуулийн 10.1-10.4-т заасан үндэслэл байгаа бол;

14.4.3.гишүүдийн тоо нь энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй буюу бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн;

14.4.4.энэ хуулийн 6 дугаар зүйлийг зөрчин нэр хэрэглэсэн.

14.5.Улсын дээд шүүх тухайн намыг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг энэ хуулийн 14.1-т заасан хугацаанд гаргах бөгөөд уг шийдвэрт татгалзсан үндэслэлээ тодорхой заана. Энэхүү шийдвэрийг зохих этгээдэд албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлнэ.

14.6.Улсын дээд шүүх нь энэ хуулийн 14.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө өргөдөл гаргагч, сонгуулийн төв байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг мэдээлэл гаргуулан авч болно.

14.7.Энэ зүйлийн 14.1-д заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

14.8.Энэ хуулийн 14.5-т заасан шийдвэр гаргасан тохиолдолд уул зөрчлийг арилгасан этгээд энэ хуульд заасны дагуу намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12, 13 дугаар зүйлд заасан журмыг үндэслэн дахин гаргах эрхтэй.

14.9.Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалт болохоос 90 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг сонгуулийн төв байгууллага хүлээн авахгүй бөгөөд энэ хуулийн 13.1, 14.1-д заасан хугацаа түдгэлзэнэ.

16 дугаар зүйл.Намын бүтэц, зохион байгуулалт

16.1.Нам нь намын удирдах дээд, төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагатай байна.

16.2.Намын бүтцийн нэгжийг намын дүрмээр зохицуулах бөгөөд энэ хуулийн 16.1-д зааснаас бусад байгууллагыг намын дүрмээр байгуулж болно.

16.3.Нам ардчилсан зарчим болон энэ хуульд заасан бусад шаардлагад нийцүүлэн орон нутгийн салбар нэгжийг нэгээс доошгүйг байгуулан ажиллуулна.

21 дүгээр зүйл.Намыг идэвхгүйд тооцох

21.1. Сонгуулийн төв байгууллага дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэр гаргана:

21.1.1. Улсын Их Хурлын ээлжит сонгуульд хоёр удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй;

21.1.2. Энэ хуулийн 37.2-т заасан үүргээ зөрчин 2 жил дараалан санхүүгийн тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй;

21.1.3. Намын удирдах дээд байгууллагыг эсхүл төлөөллийн төв байгууллагыг 5 жилийн хугацаанд хуралдуулаагүй.

21.2. Намыг идэвхгүйд тооцсон бол тухайн намд олгох төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд нам бүх шатны сонгуульд оролцох эрхгүй болно. Энэ хугацаанд намын гишүүний аливаа сонгуульд бие даан нэр дэвших эрхийг үл хязгаарлана.

21.3. Энэ хуулийн 21.1-д заасан хугацаанд тухайн зөрчлийг арилгасан болохоо мэдэгдэж, холбогдох нотлох баримтын хамт сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

21.4. Энэ хуулийн 21.3-т заасан нотлох баримтыг сонгуулийн төв байгууллага хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянан үзэж, намыг идэвхтэйд тооцох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

21.5. Сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш санал хураалт явагдаж дуусах хүртэл намыг идэвхгүйд тооцох шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргахгүй.

21.6. Энэ хуулийн 21.1-д заасан сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн талаарх маргааныг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.6, 112.2-т зааснаар шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл. Намыг татан буулгах

22.1. Намын удирдах дээд байгууллагын шийдвэрээр намыг өөрчлөн байгуулах, түүний үйл ажиллагааг зогсоох, эсхүл Улсын дээд шүүхийн шийдвэрээр намыг тараах замаар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгана.

22.2. Сонгуулийн төв байгууллага нь энэ хуулийн 23.1 эсхүл 25.3-т заасан шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор уг намыг намын бүртгэлээс хасаж гэрчилгээг нь хүчингүй болгох бөгөөд энэ тухай мэдээллийг сонгуулийн төв байгууллагын цахим хуудаст байнга байршуулж, нийтэд түгээнэ.

22.3. Татан буугдсан намын хөрөнгийг гишүүдэд хуваарилахыг хориглоно.

22.4. Энэ хуулийн 23.6-д заасныг зөрчиж өөрчлөн байгуулагдсан намын өмч, хөрөнгийг эзэмшил, өмчлөлдөө байлгасан, 22.3-т заасныг зөрчин гишүүддээ

хуваарилсан тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол хураан авч, улсын орлого болгоно.

22.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол татан буулгах комисс томилох зэрэг намыг татан буулгахтай холбогдсон бусад харилцааг Иргэний хуулиар зохицуулна.
26 дугаар зүйл.Намын орлогын эх үүсвэр

26.1.Намын орлого нь дараах эх үүсвэртэй байна:

- 26.1.1.төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;
- 26.1.2.гишүүний татвар;
- 26.1.3.хандив;
- 26.1.4.намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого;
- 26.1.5.энэ хуулийн 36.3-т заасан бусад орлого.

26.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу төрөөс намд үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу олгох төрийн санхүүжилт болон энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгээс бүрдэнэ.

26.3.Жил бүрийн намд олгох төрийн санхүүжилтийн дор дурдсан хувийг дараах зориулалтаар зарцуулна:

- 26.3.1.төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сурган бэлтгэх;
- 26.3.2.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг олон нийтэд таниулах;
- 26.3.3.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх.

26.4.Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар зарцуулна.

26.5.Энэ хуулийн 26.3-т заасан санхүүжилтийг тухайн зорилгоос өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

26.6.Төрийн санхүүжилтийн холбогдох хувийг энэ хуулийн 26.3-т заасныг зөрчин зарцуулсан бол хууль бусаар зарцуулсан хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх эсхүл дараагийн төрийн санхүүжилтээс хасан тооцно.

26.7.Нам нь энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр данстай байхыг хориглоно. Тус хориглолт нь энэ хуулийн 34.4, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлд хамаарахгүй.

26.8. Нам нь энэ хуулийн 26.1-т заасан орлогыг цахим мөнгөн хэрэгсэл /крипто валют, NFT зэрэг/-ээр хүлээн авахыг хориглоно.

27 дугаар зүйл. Төрийн санхүүжилт

27.1. Улсын Их Хурлын сүүлийн ээлжит эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид "нийт сонгогч" гэх/-ийн тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиар үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу хуваарилах замаар төрийн санхүүжилт олгоно.

27.2. Төрийн санхүүжилтийн хэмжээ нь энэ хуулийн 27.1, 27.8-т зааснаас хэтрэхгүй байна.

27.3. Нийт сонгогчийн 2-оос дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно.

27.4. Энэ хуулийн 27.3-д заасан шаардлагыг хангаагүй намд төрийн санхүүжилт олгохыг хориглоно.

27.5. Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд дараах томъёогоор төрийн санхүүжилтийг жил бүр олгоно.

$$H = (C1 * T1) + (C2 * T2)$$

27.6. Энэ хуулийн 27.5-д заасан томъёо дахь дараах тэмдэглэгээг доор дурдсан утгаар ойлгоно:

27.6.1. "H" гэж нийт сонгогчийн 2-оос дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг;

27.6.2. "C1" гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог;

27.6.3. "C2" гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог;

27.6.4. "T1" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг;

27.6.5. "T2" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг.

27.7. Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.

27.8. Энэ хуулийн 27.6.2-т заасан саналын тоог дараах байдлаар тооцно:

27.8.1.хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоогоор сонгууль явуулбал намын нэрсийн жагсаалтаар авсан хүчинтэй саналын хувь;

27.8.2.нэг мандаттай олонхын тогтолцоогоор сонгууль явуулбал нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын хувь;

27.8.3.олон мандаттай олонхын тогтолцоогоор сонгууль явуулбал нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын нийлбэрийг энэ хуулийн 27.7.2-т заасантай дүйцүүлэн гаргасан саналын хувь;

27.8.4.холимог тогтолцоогоор сонгууль явуулбал энэ хуулийн 27.8.1, 27.8.2, 27.8.3-т заасан аргачлалаар тооцсон нийлбэр саналын хувь.

27.9.Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын энэ хуулийн 36.3.1-36.3.3-д заасан орлогын нийлбэрээс хоёр дахин их эсхүл түүнээс илүү байж болохгүй.

27.10.Хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн нам эвсэл болж сонгуульд оролцсон тохиолдолд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийг эвсэлд олгоно. Эвсэлд олгосон санхүүжилтийг энэ хууль болон эвслийн гэрээгээр хуваарилна.

27.11.Намыг идэвхгүйд тооцсон, татан буулгасан, эсхүл эвсэл тарсан бол энэ тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн нам, эвсэлд олгох төрийн санхүүжилтийг зогсооно.

28 дугаар зүйл.Төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах

28.1.Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд төрийн санхүүжилт авах зорилгоор уул санхүүжилтийн хэмжээг тогтоолгох, санхүүжилт авах тухай хүсэлтээ нам тухайн жилийн өмнөх жилийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн төв байгууллагад гаргана. Энэ хуулийн 28.1-д заасан хугацаанд хүсэлт гаргаагүй бол сонгуулийн төв байгууллага энэ тухай сануулж, 30 хоногийн дотор хүсэлт гаргах боломж олгоно.

28.2.Намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан энэ хуулийн 28.1-д заасан хүсэлтийг сонгуулийн төв байгууллагаас гаргасан маягтын дагуу гаргана. Энэ маягтад намын шуудангийн хаяг, намын дансны дугаар зэрэг мэдээллийг бичихээр тусгана.

28.3.Намын төв байгууллага нь нийт намыг төлөөлж нэгдсэн хүсэлт гаргана.

28.4.Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн өмнөх онд сонгуулийн төв байгууллага төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоосон шийдвэр гаргасан бол төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд нам шинээр хүсэлт гаргах шаардлагагүй. Төрийн санхүүжилтийн хэмжээнд нөлөөлөх өөрчлөлт гарсан бол сонгуулийн төв байгууллагад даруй мэдэгдэх бөгөөд энэ талаар цаг тухайд нь мэдэгдээгүйн үр дагаврыг нам хариуцна.

28.5. Нам энэ хуулийн 27.5-д заасны дагуу үүссэн эрхээсээ татгалзах эрхтэй бөгөөд ийнхүү татгалзсан тохиолдолд тухайн намд олговол зохих төрийн санхүүжилт улсын төсөвт үлдэнэ.

30 дугаар зүйл. Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг

30.1. Нийт сонгогчийн 1 хувиас доошгүй санал авсан нам нь сонгуулийн бус жилд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг дараах хэлбэрээр авах эрхтэй:

30.1.1. намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулахад төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд 1 удаа үнэ төлбөргүй ашиглах;

30.1.2. хуваарийн дагуу намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг үндэсний олон нийтийн радио, телевизээр жилд гучин минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх.

30.2. Энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэг авах тухай намын хүсэлтийг үндэслэн 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллага шийдвэрлүүлнэ.

30.3. Энэ хуулийн 30.1.1-д заасан байгууллага уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах, энэ хуулийн 30.1.2-д заасны дагуу Үндэсний олон нийтийн радио, телевиз үнэ төлбөргүй нэвтрүүлэх үүрэгтэй.

30.4. Энэ хуулийн 30.1.2-т заасан нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд төрөөс үзүүлсэн шууд бус дэмжлэгийг дурдана.

30.5. Сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс санал хураалтын дүн гарах хүртэл хугацаанд энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэгийг намд үзүүлэхгүй.

32 дугаар зүйл. Гишүүний татвар

32.1. Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно.

32.2. Гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байна.

32.3. Сонгуульт гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

32.4. Гишүүний татварыг тухайн намын гишүүн зөвхөн өөрийн орлогоос төлнө.

32.5. Намын гишүүн нь бусад гишүүний өмнөөс гишүүний татвар төлөхийг хориглоно.

32.6. Нам өөрийн дүрэм, журмаар намын гишүүний татварыг хөнгөлөх, чөлөөлөхөөр зохицуулж болно.

32.7. Хуульд өөрөөр заагаагүй бол намын гүйцэтгэх төв байгууллага нь гишүүний татвар төлсөн баримтыг арван жилийн хугацаанд архивлан хадгална.

32.8. Намын гишүүнээс энэ хуулийн 32.2, 32.3-т заасны дагуу төлөх татвар, намд өгөх бусад аливаа мөнгийг хандив гэж үзэх бөгөөд тэдгээрийн нийлбэр нь энэ хуулийн 33.8-д заасан хэмжээнээс илүүгүй байна. Бүх төрлийн гэнэтийн зардлыг гишүүдэд ногдуулан хуваарилах, мөнгө цуглуулах, мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эд хөрөнгө намд өгөхийг хандивт тооцно.

33 дугаар зүйл. Хандив

33.1. Хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна.

33.2. Иргэний болон хуулийн этгээдийн мөнгөн хандивыг зөвхөн намын дансаар хүлээн авах бөгөөд бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно. Гишүүний татвар болон хандивыг тооцооны нэг дансанд байршуулна.

33.3. Дараах зүйл нь үнэ төлбөргүйгээр эсхүл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хийгдэж буй тохиолдолд мөнгөн бус хандивт хамаарна:

33.3.1. хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялгийг ашиглуулах, эзэмшүүлэх;

33.3.2. үйлчилгээ үзүүлэх;

33.3.3. төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх;

33.3.4. арга хэмжээний зардлыг төлөх;

33.3.5. ивээн тэтгэх.

33.4. Хандивыг мөнгөн бус хэлбэрээр авах тохиолдолд түүнийг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн үнэлэн бүртгэж, мөнгөн дүнгээр илэрхийлэн санхүүгийн тайланд тусгана.

33.5. Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.

33.6. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээс нэг жилийн хугацаанд нэг намд өгөх хандив нь энэ хуулийн 33.8, 33.9-т заасан хэмжээнээс илүүгүй байна. Намд өгсөн хандивын хэмжээг уг нам, түүний салбар болон бүтцийн нэгжид өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.7.Нэг жилд нэг иргэнээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван хоёр дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.8.Нэг жилд нэг хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.9.Хуулийн этгээдийн намд өгсөн хандивын хэмжээг уг хуулийн этгээд, хуулийн этгээдийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрын өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно. Намд өгсөн хандивын хэмжээг мөнгөн болон мөнгөн бус хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.10.Хандивлагч намын салбар болон бүтцийн нэгжид нэр заан өгсөн хандивыг тухайн зориулалтын дагуу захиран зарцуулна.

33.11.Намын харьяа байгууллага нь энэ хуулийн 34.6, 34.7-д хориглосон этгээдээс хандив авахыг хориглоно.

33.12.Нэг хуулийн этгээд эсхүл иргэнээс намд болон тухайн намын харьяа байгууллагад өгөх нийт хандив нь энэ хуулийн 33.7, 33.8-д зааснаас илүүгүй байна.

33.13.Намын харьяа байгууллагад өгөх байгууллага нь санхүүгийн тайлангаа энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан шаардлагын дагуу гаргаж тухайн намд болон сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

37 дугаар зүйл.Намын санхүүгийн тайлан гаргах

37.1.Нам санхүүгийн тайлангаа нэгдсэн байдлаар үнэн зөвөөр гаргана. Намын салбар нэгжийн гүйцэтгэх байгууллага өөрийн санхүүгийн тайланг гаргаж, намын төв байгууллагад хүргүүлнэ.

37.2.Намын санхүүгийн хагас жилийн тайланг 07 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг 02 дугаар сарын 10-ны дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эдгээр хугацаанд тайланг хүргүүлээгүй бол тайлан хүлээн авах хугацааг сонгуулийн төв байгууллага 30 хүртэл хоногоор сунгаж болно.

37.3.Нам санхүүгийн тайланг гаргахдаа Шилэн дансны тухай хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримталж, энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан зүйлийг тусгана.

37.4.Намын санхүүгийн тайланд дараах агуулга бүхий намын үйл ажиллагааны товч тайланг хавсаргана:

37.4.1.намын гишүүний тоо. Намын гишүүний тоог тайлант жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар заана;

37.4.2.намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагыг хуралдуулсан эсэх мэдээлэл;

37.4.3.энэ хуулийн 26.3-т заасан үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

37.4.4.энэ хуулийн 35.2-т заасан үйл ажиллагааны талаарх мэдээлэл.

37.5.Намын дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно.

37.6.Нам нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн анхан шатны баримт хөтлөөгүй, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримтыг Архивын тухай хуулийн дагуу хадгалаагүй тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

37.7.Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг намын төлөөллийн төв байгууллагаас эсхүл төлөөллийн төв байгууллагагүй бол удирдах дээд байгууллагаас 4 жилийн хугацаатай томилно. Түүнийг нэг удаа улируулан томилж болно.

37.8.Тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэхээс өмнө намын гүйцэтгэх төв байгууллага хэлэлцэнэ.

37.9.Тайланг баталгаажуулж намын дарга болон санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан гарын үсэг зурна.

37.10.Санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны зурсан гарын үсэг нь тайланд агуулагдаж буй мэдээлэл үнэн зөв хийгдсэний баталгаа болно.

37.11.Намын дарга намын санхүү, төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэйгээр оролцохыг хориглоно.

38 дугаар зүйл. Тайланг аудитын байгууллагаар баталгаажуулах

38.1.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитор эсхүл аудитын байгууллага /цаашид "аудитор" гэх/-аар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулан тайлангийн хамт энэ хуулийн 37.2-т заасан хугацааны дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

38.2.Аудитор холбогдох баримт материалтай танилцах боломжийг нам бүрдүүлэх үүрэгтэй.

38.3.Аудитор намын санхүүгийн тайланг хянаад зөрчилтэй гэж үзвэл тайланг баталгаажуулахаас татгалзах эрхтэй бөгөөд энэ талаар сонгуулийн төв байгууллагад ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

38.4.Энэ хуулийн 38.1-д заасан аудиторын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс гаргана.

38.5.Дараах тохиолдолд намын санхүүгийн тайланд аудит хийхийг хориглоно:

38.5.1.тухайн намд болон тухайн намын улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн ажил, албан тушаал хашиж буй эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд хашиж байсан;

38.5.2.намын нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд эсхүл намын тайланг гаргахад оролцсон;

38.5.3.ашиг сонирхлын зөрчил үүссэн бусад нөхцөл.

38.6.Аудитор, түүний туслах, аудитын байгууллагын хууль ёсны төлөөлөгч нь ажил үүргээ шударга, үнэнчээр, төвийг сахиж биелүүлэх бөгөөд нууцыг хадгалж Аудитын тухай хуульд захирагдана.

38.7.Энэ хуулийн 38.1-д дурдсан аудитын шалгалтыг намын төв байгууллага болон аудиторын үзэмжээр сонгосон орон нутгийн салбар нэгжийн таван хувиас доошгүйг оролцуулан явуулна.

38.8.Аудитын шалгалтад нягтлан бодох бүртгэлийг хамруулна. Аудитын шалгалт хууль тогтоомжийг баримтлан сахисан эсэхийг тогтооход чиглэгдэнэ. Аудитын шалгалтыг хариуцлагатай мэргэжлийн өндөр түвшинд явуулж, алдаа болон хуулийн заалтуудын зөрчлийг олж тогтооно.

38.9.Аудитор хянан шалгах үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай тодруулга, баримт бичгийг намын гүйцэтгэх төв байгууллага болон түүний ажилтнаас шаардах эрхтэй. Үүнтэй холбоотойгоор аудитор тайланг гаргахад хэрэглэсэн баримт бичиг, нягтлан бодох бүртгэл, эд хөрөнгийг шалгах эрхтэй.

38.10.Шалгуулж буй намын орон нутгийн салбар нэгжийн гүйцэтгэх байгууллагаас тайланд тусгагдах ёстой бүх орлого, зарлага, эд хөрөнгийг бүртгэсэн тухай баталгааг аудиторт бичгээр гаргаж өгнө. Баталгааг орон нутгийн доод шатны намын гүйцэтгэх байгууллагаас гаргуулж болох ба санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан бичгээр баталгаа гаргахад хангалттай.

38.11.Аудитын шалгалтын үр дүнг бичгээр тайлагнаж, намын гүйцэтгэх төв байгууллага болон шалгуулсан орон нутгийн салбар нэгжийн гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгнө.

38.12.Намын тайланг шалгаж дууссаны дараа алдаа, зөрчил илрээгүй тохиолдолд аудитор өөрийн үүргээ хариуцлагатай биелүүлж, намын нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн намын тайлан нь энэ хуулийн 40 дүгээр зүйлд

зааснаар нягтлан шалгасны дагуу энэ хуулийн шаардлагыг хангасныг баталгаажуулж тэмдэглэл үйлдэнэ.

38.13.Тайланд алдаа, зөрчил илрүүлсэн тохиолдолд аудитор дээрх шалгалтын тэмдэглэлд тайланг баталгаажуулахаас татгалзах эсхүл хэсэгчлэн баталгаажуулна. Шалгуулсан намын орон нутгийн байгууллагыг тэмдэглэлд заана.

38.14.Шалгалтын тэмдэглэлийг намын тайланд хавсаргах бөгөөд энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу бүрэн хэмжээгээр нийтэлнэ.

39 дүгээр зүйл. Намын санхүүгийн тайланг нягтлан шалгах

39.1.Сонгуулийн төв байгууллага намын тайланг хүлээн авч хэлбэр болон агуулгын хувьд зөв, бодитой эсэх, энэ хуулийн Тавдугаар бүлэгт заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгах бөгөөд энэ хуулийн 38.1-д заасан аудитын тайланг харгалзан үзнэ.

39.2.Хэрэв намын тайланд байгаа мэдээлэл үнэн, бодит эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл байвал сонгуулийн төв байгууллага тухайн намд ажлын 15-аас доошгүй хоногийн хугацаа заан мэдэгдэж, тайлбар хийх, залруулах боломж олгоно.

39.3.Энэ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллага хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

39.4.Нягтлан шалгах ажиллагаа дуусгавар болсны дараа сонгуулийн төв байгууллага дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтэд дараах зүйлийг тогтооно:

39.4.1.тайланд алдаа, зөрчил байсан эсэх;

39.4.2.тайланг зөрчил алдаатай гаргасан бол үүний улмаас намд олгосон санхүүжилт зөрүүтэй эсэх;

39.4.3.орлого, зарлагын тайлангийн баланс хууль тогтоомж зөрчсөн эсэх;

39.4.4.эд хөрөнгийн балансыг буруу гаргасан эсэх.

39.5.Энэ хуулийн 39.4-т заасан алдаа, зөрчилтэй тайлан ирүүлсэн нам тухайн алдаа, зөрчлийг арилгаж сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу тайлангаа бүрэн эсхүл хэсэгчлэн шинэчлэн ирүүлнэ. Шинэчилсэн тайлангийн үнэн зөвийг аудит хийлгэж баталгаажуулна.

39.6.Энэ хуулийн 39.4-т заасны дагуу тогтоогдсон алдаа, зөрчил хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрээгүй байвал энэ хуулийн 39.5-д заасны дагуу тайланг шинэчлэхгүйгээр дараа жилийн тайланд залруулан тусгаж болно.

39.7.Тайланг нягтлан шалгах ажиллагааны явцад олж авсан боловч намын тайланд шууд хамаарахгүй мэдээллийг нийтэлж болохгүй бөгөөд төрийн бусад байгууллагад дамжуулахгүй. Хяналт шалгалт дууссаны дараа эдгээр мэдээллийг сонгуулийн төв байгууллага даруй устгах үүрэгтэй.

1. Гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох
3. Хүний нөөцтэй холбоотой гаргах зардлыг урьдчилан тооцох
4. Хувилбарыг нягтлах.

Үе шат 1: Гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох

Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын алба өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэлд оруулж, мэдээллийг нягтлан шалгах

Үе шат 2: Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох

Төрийн байгууллага	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Хийгдэх ажиллагаа	Зарцуулах хугацаа
СЕХ	13.1.Сонгуулийн төв байгууллага нь намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн өргөдөл, дагалдах баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.	13.1.Сонгуулийн төв байгууллага нь намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн өргөдөл, дагалдах баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.	13.1.Сонгуулийн төв байгууллага нь намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн өргөдөл, дагалдах баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.
		Шийдвэрийн төсөл боловсруулах	Ажлын 2 өдөр-960 минут
		Шийдвэрийн төслийг хорооны гишүүдэд танилцуулах	Ажлын 1 өдөр-480 минут

		СЕХ-ны гишүүдийн саналыг тусган эцэслэн боловсруулах	Ажлын 1 өдөр-480 минут
		Шийдвэрийн төслийг албажуулах	Ажлын 6 цаг-360 минут
Улсын дээд шүүх	13.4.Сонгуулийн төв байгууллага намыг бүртгүүлэх өргөдөл, холбогдох баримтыг хүлээн авч, энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаанд нягтлан шалгаж дуусгаснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх намыг бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.	-өргөдөл хүлээн авна -мэдээллийг нягтлан шалгана -холбогдох шийдвэрийг гаргах	3720 минут
Нэг тохиолдлыг шийдвэрлэх хугацаа			7500 минут

Үе шат 3: Хүний нөөцтэй холбоотой гаргах зардлыг урьдчилан тооцох

Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлно. Өмнөх шатанд гаргасан ажиллах шаардлагатай хүний нөөцөд зардлын бусад бүрдлээс оногдох хэсгийн нийлбэрээр зардлыг тооцно. Хуулийн төслөөр нэмэлтээр орж байгаа чиг үүргийг СЕХ-ны Ажлын алба болон Улсын дээд шүүх аливаа нэмэгдэл зардал гарахгүй гүйцэтгэх бөгөөд улс төрийн намд төрөөс санхүүжилт олгохтой холбоотой зардлыг хавсралт хүснэгтээр харуулав.

Үе шат 4: Нийт зардал

Нэг. Хуулийн төслийн 27.5, болон 27,7 дахь заалтыг үндэслэн улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг тооцоо

2023 оны 4 сарын 12-ны өдөр

Нэг. Хуулийн төслийн заалт

27.5.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд дараах томъёогоор төрийн санхүүжилтийг жил бүр олгоно.

$$H = (C1 * T1) + (C2 * T2) + (Э1 * T2) + (ХБ1 * T2)$$

27.7.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.9-д заасан дүнгээр **Үржүүлсэнтэй** тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.

Хоёр. Улсын төсөв

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйл.Монгол Улсын төсөвт 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого **13,910,441.9 сая төгрөг** байна.¹ Энэ нь арван гурван их наяд есөн зуун арван тэрбум дөрвөн зуун дөчин нэгэн сая есөн зуун мянган төгрөг болно.

Улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг 2023 оны Монгол улсын төсвийн нэгдсэн орлоготой харьцуулбал дараах дүн гарч байна.

№	Монгол Улсын төсвийн нэгдсэн орлого /сая төгрөгөөр/	Улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг ХХДХ-ны 1 хувь	Улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг ХХДХ-ны 0,6 хувь	Улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг ХХДХ-ны 0,5 хувь
		5,500 төгрөг	3,300 төгрөг	2,750 төгрөг
1	13,910,441.9 сая	9,539,419,353	6,680,651,612	5,965,959,677
			0.048%	0.043%

¹ Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532001935011>


		0.069%		
--	--	--------	--	--

Жич: ХХДХ- хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өсөх үед төрөөс улс төрийн намд олгох санхүүжилтийн дүн өөрчлөгдөнө.


Гурав. Гадаад орнуудтай харьцуулсан дүгнэлт

1. Улсын төсөвт эзлэх хувь

2. Төрөөс санхүүжилт авах босго.



3. Улс төрийн намын санхүүжилтэд төрийн санхүүжилтийн эзлэх хувь



Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийн хувь хэмжээ, зарцуулалтыг нарийн тогтоож, ил тод болгох нь улс төрийн намуудад өрсөлдөөний ижил нөхцөл бий болгож, авлигын төвшин бууруулахад эерэг үр дүн авчрах бөгөөд хуулийн төслийн үр өгөөж, зардлын харьцаа өндөр байна.

---oOo---